

Сурьеэз өвчний хянагийн тархвар судалгын цндэс

Нэг дэх жэвлэл
Ханс П. Райдер



МННХ
(Соросын сан)



ХЭСҮТЭВ
(Сурьеатгийн Тандамт
Судалгааны алба)

Сүрьеэз өвчний хяналтын таржвар судлалын чигдэс

Нэг дэх жэвлэл
Ханс П.Райдер

International Union Against Tuberculosis and Lung Disease
(Олон Улсын Сүрьеэз ба Ушигны Өвчинтэй Тэмцэх Холбоо)
68, boulevard Saint-Michel, 75006 Paris



МНХХ
(Соросын сан)



ХӨСҮТӨВ
(Сүрьеэгийн Тандалт
Судалгааны алба)

ГАРЧИГ

Өмнөтгөл.....	5
Талархал.....	7
Оршил	9

БҮЛЭГ НЭГ

СҮРҮЕЭГИЙН САВХАНЦЫН ХАЛДВАРЫН НӨЛӨӨЛӨЛДӨРТӨХ

Шинэөвчлэлийн тохиолдлын тоо	11
Халдвэр ялгаруулах хугацаа	12
Нэгж хугацаанд халдвэр авах хавьтлын тоо	12
Хүн амын нягтрал	12
Ам бул	13
Цаг агаар, уур амьсгалын онцлог	13
Халдварьн эх уурхайн нас	13
Хүйсний ялгаа	15

БҮЛЭГ ХОЁР

СҮРҮЕЭГИЙН САВХАНЦЫН ХАЛДВАР

Үүсгэгчийн холбогдлыг судлах тархвар судлал: нөлөөлөлдөртөсний дараагаар халдвэр авах эгзэг	17
Халдварьг агуулсан цөмтэй дусалтай агаараар	
халдвэр тархан дамжих	17
Халдвартай өвчтөний тодорхойлолт	21
Агаарын эргэлт солиццоо ба агааржуулалт	24
Халдварьн эх уурхайн халдвэр ялгаруулахыг таслан зогсоох	25
Хүний биеийн дархлалын тогтолцоо	25
Халдвэр дамжих замын бусад хэлбэр: <i>M.bovis</i>	25

Бичиглэлийн тархвар судлал: халдварьн шинэ тохиолдол болон тархалт	26
Халдварьг хэмжих арга зүй	26
Туберкулины сорилын мэдрэг чанарын үнэлгээ	28
Мал эмнэлэгт туберкулины сорилын өөврмөц чанартай холбоотой учирч буй хүндрэлүүд	28
Хүнд тохицуулж туберкулиныг стандартчлах болон тунг тохицуулах	30

<i>Стандарт тунтай туберкулины сорилын мэдрэг чанарын хэлбэлзэл</i>	34
<i>Хүрээлэн буй орчны mycobacteria-ийн хэрээс харилцан нөлөөлөх урвал байгаа тохиолдолд сурьеэгийн тархалтыг тодорхойлох аргууд</i>	41
<i>Халдварын тархалт</i>	43
<i>Нас хүйнээс хамаарсан халдварын тархалт.</i>	43
<i>Халдварын тархалт болон хүн амын нягтрал</i>	46
<i>Сурьеэ ёвчний халдвар болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлс</i> ... 46	
<i>Таамаглах халдвар судлал – халдвар авах эгзийн загварчлал</i>	49
<i>Халдварын тархалтаас халдварын эгзийг тодорхойлох</i>	50
<i>Цаг хугацаа болон халдварын эгзэгийн чиг хандлага</i>	52
<i>Тоо баримтыг түшиглэн наснаас хамааралтай халдварын тархалтаас халдварын эгзийг урьдчилан тооцоолох</i>	56
<i>Халдвартай тохиолдууд болон халдварын эгзэг</i>	59
БҮЛЭГ 3	
СУРЬЕЭ ЁВЧИН	
<i>Үүсгэгчийн холбогдлийг судлах тархвар судлал: халдвар ёвчин болж даамжрахад нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс</i>	63
<i>Халдвар авснаас хойших хугацаа</i>	63
<i>Хүний дархлаг хомсдолын вирусын халдвар</i>	66
<i>Фибринэн сорвижилттойгоор аяндаа эдгэрдэг сурьеэ ёвчин</i>	71
<i>Нас</i>	71
<i>Генетикийн хүчин зүйлс</i>	72
<i>Хүйс</i>	72
<i>Биеийн галбир бүтэц</i>	74
<i>Цагаан цогцосны эсрэг төрөгч (HLA) -ийн хэлбэр</i>	74
<i>Цусны бүлэг</i>	74
<i>Гемофили</i>	75
<i>Цэвэр хүн ам</i>	75
<i>Генетикийн бусад хүчин зүйлс</i>	75

<i>Хүрээлэн буй орчны хүчин зүйлс</i>	77
<i>Гаж зурилт</i>	77
Тамхи татах	77
Архи хэтрүүлэн хэрэглэх	77
Хар тамхичид	77
<i>Хоол тэжээл</i>	78
Хоол тэжээлийн дутагдал	78
Хоолны дэглэм	79
<i>Эмнэлгийн нөхцөл байдлыуд</i>	79
Уушиг тоосжих буюу силикоз	79
Чихрийн шижин өвчин	79
Хорт хавдрууд	80
Бөөрний дутагдал	80
Улаан бурхан	81
Гастроэктоми (ходоод тайрах)	81
Нарийн болон өлөн гэдэсний хагалгаа	82
Кортикоостероид эмчилгээ	82
<i>Жирэмслэлт</i>	82
<i>Шалтгааны хүчин зүйлстэй холбоотой нөлөөлөгч хүчин зүйлс</i>	83
Халдвартуулах тунгийн үр нөлөө	83
Омогийн хоруу чанар	84
<i>M. bovis</i> -ын халдвар	85
<i>Халдвар давтсан авах (re-infection)</i>	86
<i>Бичиглэлийн тархвар судлал: өвчлөл</i>	87
<i>Аж үйлдвэржссэн орнууд дах чиг хандлага</i>	87
<i>Газар зүйн онцлог ба өвчлөлийн давтамж</i>	92
<i>Нийгэм дэх өвчлөлийн давтамжийн ялгаа</i>	94
<i>Nas</i>	94
<i>Xuis</i>	96
<i>Нийгэм эдийн засгийн байдал</i>	98
<i>Арсын өнгө болон гарал угсаа</i>	98
<i>Цагаачлал</i>	100
<i>Хүн амын нягтрал</i>	105
<i>Гэрлэлтийн байдал</i>	105
<i>Архи хар тамхийг хэтрүүлэн хэрэглэх</i>	106
<i>Бусад эмзэг бүлгийн хүмүүс</i>	106

<i>ХДХВ-ын халдвартын үйлчлэл</i>	108
АНУ ба баруун Европ	109
Сахарын Африк	112
Ази	114
Латин Америк	116

<i>Нийт сурьеэгийн өвчлөлд анхдагч хүрц өвчин, хүрээлэн буй орчноос давтан халдварт авах болон дотоод идэвхжилт явагдсанаас үүссэн өвчин нөлөөлөх нь</i>	116
<i>M.bovis</i> -ын нөлөөгөөр үүсэх сурьеэ	118

Таамаглах тархвар судлал: эпидем гарах хэтийн төлөв	119
Аж үйлдвэржссэн улс орон	119
Буурай хөгжилтэй улс орнууд	120

БҮЛЭГ 4 СУРЬЕЭГИЙН НАС БАРАЛТ

<i>Үүсгэгчийн холбогдолтой тахвар судлал: сурьеэгийн нас баралтанд нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйлс (тохиолдолын эндэгдэл)</i>	123
Бичиглэлийн тархвар судлал: нас баралт	126
Таамаглах тархвар судлал: сурьеэгийн улмаас нас барах хүмүүсийн таамагласан тоо	131

ТОВЧ ХУРААНГУЙ БОЛОН ДҮГНЭЛТ


Нөлөөлөл	133
Халдвэр	133
Өвчин	137
Нас баралт	138
<i>Лавлах</i>	140

Өмнөтгол

Үр дунтэйгээр сүрьеэгийн хяналтыг явуулахад онолын мэдлэг хангалттай биш байж болно. Гэвч өвчиний үүсгэгч, сүрьеэгийн тархвар судлал, сүрьеэ өвчиний эмнэл зүй, өвчин үүсэхэд нөлөөлөх янз бурийн гадны нөлөөллийн үр дагавар, сүрьеэ өвчиний хяналтыг явуулахад хэрэглэж байгаа арга хэрэгслэлүүдийг бурэн гүйцэд ойлгох нь Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн үр дүнг нэмэгдүүлэхэд магадгүй ихээр нөлөөлнө. Хөтөлбөрийн зохицуулагч наарт онолын суурь мэдлэг нь сүрьеэтэй тэмцэх ажилын орчин үеийн бодлого, чиглэлийг өөрийн орны бүх түвшинд нэвтрүүлэн хэрэгжүүлж, өөрийн үйл ажиллагааг бусдад тайлбарлан зөвтгөн батлахад туслах юм.

Олон Улсын Сүрьеэ ба Ушигны Өвчинтэй Тэмцэх Холбоо (ОУСҮӨТХ) нь сүрьеэгийн хяналтын олон улсын сургалтыг зохион байгуулдаг. Энэ сургалт нь Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн хүрээнд бус, муж, үндэсний түвшинд ажилладаг эрүүл мэндийн байгууллагын ажилтанд зориулагдаг юм. Энэ сургалтын гол зорилго бол оролцождод сүрьеэтэй тэмцэх орчин үеийн бодлогыг ойлгуулж, суурь мэдлэгийг олгоход оршино. Сургалт доорхи турван том бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулна:

Сүрьеэ өвчиний хяналтын нян судлалын үндэс
Сүрьеэ өвчиний эмнэл зүй ба эмчилгээ
Сүрьеэ өвчиний хяналтын тархвар судлалын үндэс
Сүрьеэ өвчиний хяналтанд хөндлөнгөөс оролзох (интервенции) бодлого
Сүрьеэ өвчиний хяналтын үндсэн зарчмууд (зураг 1)



Зураг 1. Орчин үеийн сүрьеэ өвчиний хяналтын бодлогыг ойлгоход зайлшгүй шаардагдах таван элемент.

Сургалтанд оролцогчид нь дээрхи бүлэг хичээлүүдийн үндэс болсон сүрьеэ өвчний талаар гарсан зуугаад шинэ өгүүллэл материалыг агуулсан номын сангаар хангагдсан байдаг.

Эдгээр таван бүлэг хичээлүүд нь утга, ач холбогдоороо дараалсан байна. Нэгдүгээрт сургалтанд оролцогчид нь сүрьеэ өвчний шалтгаан үүсгэгчийн талаар гүнзгийрүүлэн судална, *Mycobacterium tuberculosis*-ын бүрдлийг буюу сүрьеэ өвчний хяналтын нян судлалын үндэсийг судална.

Хоёрдугаарт, үүсгэгч хувь хүнд яаж нөлөөлдөг, сүрьеэ өвчин эмнэл зүйн оношлогоог яаж хийх талаар судална. Гуравдугаарт, энэ өвчин яаж нийгэм нийт хүн амд нөлөөлдөг тухай сүрьеэ өвчиний хяналтын тархвар судлалын үндэсийг судална. Энэ турван гол цөм болсон хэсгүүдээс, яаж хувь хүн болон нийт хүн амьтны хамгаалах бодлого боловсруулах талаар лараагийн ээлжинд судалдаг байна. Эцэст нь эдгээр дөрвөн бүлгийг нэгтгэн нэг багц болгон амьдралд яаж хэрэгжүүлэх талаар судална.

Эх материал хангалтай их байсан боловч сургалтанд оролцогчид хичээл бүрээс зарим чухал зураг хүснэгтүүдтэй монографийг онцолж авах санал хүснэгтэй байгаагаа удаа дараа илэрхийлж байсан юм. Энэ сүрьеэ өвчиний хяналтын тархвар судлалын үндэс номонд дээрхи хүснэгтийг хангахыг оролдсон болно.

Талархал

Зохиогч нэн тэргүүнд энэ номын материалыг дэлгэрэнгүй болгох, шалгахад оролсон сургалтанд хамрагдаж байсан зуугаад хүнд гун талархалаа илэрхийлэхийг хүсэж байна. Оролцогчидтой харилцан санал солилцож, хамтран ажилласан нь сурьеэ өвчинтэй тэмцэхэд тархвар судлалын шинжлэх ухаан нь суурь шинжлэх ухаан юм гэдгийг ойлгох ойлголтыг нэмэгдүүлж хөгжүүлсэн юм.

Martien W Borgdorff, George W Comstock болон Kevin M De Cock нар тус номын агуулга бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэхэд маш ихээр туслав. Thuridur Arnadottir, Christopher Dye, Donald A Enarson болон Arnaud Trévisq нар тус номыг хянаж засварлан санал өгсөн юм. Мөн Robert L Cowie болон Robert Steffen нар номын сэдвүүдийг няմбай хянаж үнэтай зөвлөмж өгч туслав. Clare Pierard эх бичлэгийн эцсийн хяналтыг хийхэд тусалсан юм.

Тус номын хэвлэн хувиарлалт нь ДЭМБ, Норвегийн Зүрх Ушигны Холбооны Дэлхий Нийтээр Сурьеэ Өвчний эсрэг Хөтөлбөр, Их Британийн Колумбия Ушигны Холбоо, Тайландын Сурьеэ Өвчний Эсрэг Нийгэмлэг, Финландийн Ушигны Эрүүл Мэнд Нийгэмлэг болон Францийн Гадаад Харилцааны Яамны санхүүгийн өгөөмөр тусламж дэмжлэгтүйгээр боломжгүй байсан юм.


Парис болон Берн, 1999 оны 7 дугаар сар

Оришил

Тархвар судлал нь урьдчилан сэргийлэлт болон нийгмийн эрүүл мэндийн суурь шинжлэх ухаан юм. Тархвар судлалын шинжлэх ухаан нь эмнэлгийн бүхий л үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний судалгаа болон нийгмийн эрүүл мэндийн бодлогод өргөн оролцно.

Энэ номонд сурьеэ өвчний тархвар судлалын талаар өгүүлэх болно. Сурьеэ өвчинд өртөх, халдвэр авах, өвчлөх, нас барах явдлуудын тодорхойлогч хүчин зүйлсийн талаар багтаалаа. Сурьеэ өвчний тархвар судлалын үндэс суурь бүтцийн талаархи ойлголтуудыг тодорхойлоходоо энэ асуудалтай холбоотой анагаах ухааны хэвлэлүүд дээр хэвлэгдэн гарсан материалуудыг ашигласан болно. Ийм арга барил нь эпидемийн процессыг зөн совин болон оюун ухаанаараа ойлгоход суурь болж егөх ёстой.

Сурьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөрийг (CTYX) амжилттай хэрэгжүүлэхийн үндэс нь сурьеэгийн тархвар судлал юм гэдгийг амархан ойлгохын тулд, сурьеэгийн эмгэг жамын дагуу өртөхөөс эхлэн нас баралт гэсэн загварыг мөрдөн судлах хэрэгтэй. Энэ загвар нь сурьеэгийн тархвар судлал дахь маш олон янзын тодорхойлогч хүчин зүйлсийн ялгааг илтгэхэд бүрэн хангалттай байх ёстой бөгөөд нөгөө талаас өвчний явцыг ойлгоход нөлөөлөх хүчин зүйлсийн талаар маш хялбараар дүрслэн бичсэн байвал зохино. Ийм загварыг American Thoracic Society болон United States Centers for Disease Control (Centers for Disease Control, одоо Centers for Disease Control and Prevention нэртэй болсон) -ийн [1] сурьеэгийн эмгэг жамд дөрвөн үе шатыг тодорхойлно: нөлөөлөлд өртөх, халдвэр авах, өвчлөх, нас барах.



Зураг 2. Сурьеэгийн эмгэг жамын тархвар зүйн загвар. Urban болон Vogel нарын зөвшөөрөлтейгөөр зургийг хэвлэв[2].

Халдварт ялгаруулж буй тохиолдолтой учирч өртсөнөөр эрүүл хүн халдвар авна. Нэгэнтээ энэ нөлөөлөлд өртсөн хувь хүн сурьеэгийн халдварт авахад тодорхой эрсдэлт хүчин зүйлс нөлөөлнө; халдварт авсан хүн сурьеэ өвчнөөр өвчлөхөд мөн л тодорхой эрсдэлт хүчин зүйлс нөлөөлнө; сурьеэгээр өвчилсөн хүн сурьеэ өвчний улмаас нас барагад мөн л тодорхой эрсдэлт хүчин зүйл нөлөөлнө.

Нийгэм нийт хүн амд сурьеэгийн нөлөөллийг судлахад тархвар судлалын бүтэц болох гурван төрлийн асуудлыг авч үзнэ. Үүнд аналитик тархвар судлал буюу үүсгэгчийн холбогдлыг судлах (etiological) тархвар судлал орно [3]. Үүсгэгчийн холбогдлыг судлах тархвар судлал нь нэг шатнаас нөгөө шатанд дамжихад нөлөөлж буй хүчин зүйлүүдийг ялган тогтоох гол зорилготой юм. Бичиглэлийн (descriptive) тархвар судлал нь янз бүрийн бүлэг хүн амын дундах сурьеэ өвчний халдварталт, өвчлөл, нас барагтын давтамж тархалтыг судална. Таамаглах (predictive) тархвар судлал нь өмнөх судалгаа ажиглалтууд дээр үндэслэн өгөгдсөн хүн ам дахь сурьеэгийн эпидемийн ирээдүйг таамаглаж дүгнэлт өгнө. Сурьеэ өвчинд өртөх, халдварт авах, өвчлөх, нас бараг талаар энэ номонд дэс дараатай өгүүлэх болно. Зарим тохиолдолд ихэвчлэн үүсгэгчийн холбогдлыг судлах тархвар судлалын эхэнд бичиглэлийн тархвар судлал орсон байх болно, энэ нь тогтсон загварыг өөрчлөн үүсгэгчийн холбогдлыг судлах тархвар судлалыг бичиглэлийн тархвар судлалын ард оруулж, үүний дараа таамаглах тархвар судлалыг оруулсан сэтгэгдэлийг төрүүлнэ. Яагаад ийм арга барилыг сонгосон бэ гэвэл, одоогийн нөхцөл байдлыг үүсэхэд ямар хүчин зүйлс нөлөөлснийг нэн тэргүүнд мэдэж тухайн нөлөөллийн ач холбогдлыг тодорхойлж, ингэснээр эпизэмтэй тэмцэх алсын хөтөлбөрийг боловсруулж гаргаж авах ач холбогдолтой.

БҮЛЭГ НЭГ

СҮРЬЕЭГИЙН САВХАНЦАРЫН ХАЛДВАРЫН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨХ

Нийт хүн ам дотроос бүртгэгдэх халдвартай хэлбэрийн сүрьеэгийн тохиолдлын тоо, эдгээр тохиолдлуудын халдвар ялгаруулах хугацаа болон тохиолдол болон хавьтлын хамт байсан нэгж хугацаа ба давтамж нь сүрьеэгийн савханцирын нөлөөлөлд өртөхөд тодорхойлогч эрсдэлт хүчин зүйлсээр тодорхойлогдоно.

Тодорхой тооны халдварын эх уурхай хичнээн хүнийг савханцирын халдварт өртөх магадлалыг нарийн тогтооход, мөн л халдварын эх уурхайтай хамт байсан хугацаа, халдвар тараагч тухайн үед ялгаруулж байгаа нянгийн тооноос хамаарна. Халдварт өртөх тоог нарийн тогтоох тийм ч хялбар биш юм, яагаад гэвэл дэлхий дээрхи нийт хүн ам нэг л агаараар амьсгалдаг шүү дээ. Тийм учраас өртөлтийг pragmatik аргаар тодорхойлдог.

Энэ номонд хувь хоёр хүний хавьталаын үед нөлөөлөл хүрэлцэхүйц ойрхон байх, эсвэл агаарын солилцоо хангалтгүй зарим орон нутагт агаар бүрэн солигдож цэвэршээгүйгээс нөлөөлөлд өртөх зэргийн аль нь чухал ач холбогдолтой байх талаар өгүүлэх болно.

Хөдөө орон нутагт амьдардаг хүмүүсээс ганц нэг халдвартай тохиолдлын халдварт өртөх эзэг хотод амьдардаг хүмүүсийнхээс доогуур байх магадлалтай юм. Үүнтэй ижил гэр бүлийн гишигдийн тоо халдвар тархаад нөлөөтэй, их олуулаа хамт амьдардаг бол олон хүн халдвар авах болно. Мөн сүрьеэгийн халдвар авах тохиолдлын тоо нийгмийн давхрага насны булгээс хамаарах чиг хандлагатай. Тухайн орон нутгийн газар зүй, цаг уурын онцлог нь халдвар тархад нөлөөлнө.

ШИНЭ ӨВЧЛӨЛИЙН ТОХИОЛДЛЫН ТОО

Халдвартай тохиолдлуудын оролцоогүйгээр ач холбогдол бүхий нөлөөллийг тодорхойлох боломжгүй юм. Гэвч, олон төрлийн хүчин зүйлсийн улмаас жинхэнэ гол нөлөөлөл нь хувирч харагддаг тул, халдвартай тохиолдлын нөлөөллийг шинэ тохиолдлын түвшинд зохицуулан тодорхойлох нь зайлшгүй юм. Энэ мэтээр ижил тувшингийн шинэ тохиолдлууд нөлөөлөлд өртөх эзэг мөн л ихээр хэлбэлзэж болно. Халдвар тархах нөлөөллийн

эгзэгийг, нийгэм дэх шинэ халдварын эх уурхайн тоог тогтмол хэмжигдэхүүнээр илэрхийлж тодорхойлж болно.

Халдвартай хугацаа

Нийт хүн амд сурьеэгийн халдвартай тархахад халдвартай хүний нян ялгаруулах хугацааны ургэлжлэл хамгийн чухал. Нян ялгаруулах хугацаа урт байх нь, нян ялгаруулах хугацаа богино байхтай харьцуулавал нийгэмд халдвартай тархах эгзэгийг нэмэгдүүлэх нь ойлгомжтой. Нян ялгаруулах хугацаа нь халдвартай тараах хугацаа нь болох бөгөөд нэг эх уурхайгаас дахин халдвартай ижил чухал боловч тархвар судлалын ач холбогдлын хувьд бага юм. Хэдий тийм боловч, цэрний-турхэц эзрэг байсан хүнийг оношлох үед, хавьтлуудын 30-40 хувь нь халдвартай авсан [4] байжээ. Хэрэв халдвартай тохиолдолыг оношлохгүй бол (тохирсон эмчилгээнд оруулахгүй бол) түүнтэй хавьталаатай байсан хүмүүсийн үлдсэн ихэнхи хувь нь халдвартай авахад мэдрэг хэвээр байх болно.

Цаг тухайд нь оношлогдож зохистой эмчлэгдэж байгаа өвчтентэй эмчилгээ хийлгээгүй халдвартай хэлбэрийн сурьеэтэй өвчтөнийг харьцуулвал, сүүлийн тохиолдол нь урт хугацаанд халдвартай тараасаар байх болно. Цаг алдалгүй эрт оношлогдож тохирсон эмчилгээг явуулах нь халдвартай боломжийг устгаж, нийт хүн ам болон хувь хүн халдвартай авах эгзэгийг угүй болгоно. Харин сурьеэтэй өвчтөнийг оношлогдож эмчилгээг эхэлсэн боловч зохистой эмчилгээ хийж чадахгүй бол халдвартай тархах хугацаа уртсах болно.

Сурьеэгийн эмийн тунг өвчтөний жинд тохируулахгүй өгөх, эсвэл ганц болон олон эмэнд дасалттай омогийн нянгаар халдвартай өвдсөн өвчтөн байх [5-7], эсвэл өвчтөн эмчийн бичиж өгсөн эмийт тогтмол биш ууснаас буруу эмчилгээ явагдах болно.

Нэгж хугацаанд халдвартай авах хавьтлын тоо

Халдвартай өвчтөнөөс халдвартай авах боломжтой хавьтлын тоо нь хувь хүний зан үйлийн онцлог, нийгмийн идэвхий бусад хүмүүстэй харьцах боломж бололшооноос ихээхэн хамаарна. Мөн хавьталаатай орсон нийт хугацаа, орон нутгийн газар зүйн байрлал онцлогоос хамаарна.

Хүн амын нягтрал

Улс орнууд хүн амын нягтралаараа олон янз. Хүмүүсийн сурьеэгийн өвчний тохиолдлын нөлөөлөлд өртөх эгзэг нь оршин сууж буй орно нутгийн онцлог болон тухайн газар оршин сууж буй хүмүүсийн тоо нягтралаас хамаарна. Нэмж тэмдэглэхэд, хот суурин газрын хүн амын нягтрал хөдөө орон нутгийнхаас их байдаг. Хөдөө орон нутагт амьдарч буй хүмүүсийн нэгж хугацаанд хавьталаатай өртөх боломж нь хотод оршин суудаг хүмүүсийнхээс бага

байна (ам бүл, амьдрах орон суул нь ижил ойролцоо байсан ч гэсэн). Тиймээс, сурьеэтэй шинэ өвчтений тоо ижил түвшинд бүртгэгдэг орон нутаг байлаа гэж бодвол, халдварт авах эгзэг нь хүн амын нягтрал ихтэй газар нь өндөр байна.

Ам бүл

Энэ зуунд аж үйлдвэр хөгжсөн орнуудын айл өрхийн ам бүлийн тоо ихээр өөрчлөгдсөн. Жишээ нь, 1900 онд Швед улсын айл өрх дунджаар 2 хүүхэдтэй байдаг байсан бол, 1990 он гэхэд нэг хүүхэдтэй болж буурсан байна [8]. Дээрхи нөхцөл байдлаас үзэхэд халдварт өртөх хүүхдийн тоо цөөрч буурах ёстой, харин тухайн хүүхдүүдийн энэг эхийн халдварт өртөх боломж нэгэн хэвэндээ үлдэх болно. Ирээдүйд нийгэм дэх айл өрхийн төлөвлөлт зохицуулалт чухал ач холбогдолтой байх болно.

Цаг агаар, уур амьсгалын онцлог

Хойд Европын урт өвөлтөй улс орнуудыг бодвол дулаан уур амьсгалтай улс оронд нийгмийг бүхэлд нь хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахад илүү хялбар юм. Сурьеэгийн савханцар гадаад орчинд харьцангуй тэсвэр муутай, нарны шууд туяаны (хэт ягаан туяа) нөлөөнд маш богино хугацаанд устаж үхнэ. Үүний эсрэгээр агааржуулалт муутай битүү байр өрөөнд сурьеэгийн савханцар удаан хугацаагаар хадгалагдаж халдвартархах шалтгаан болно. Ийм байр өрөөнд халдвартын эх уурхай хүн нян агуулсан шүлсний дуслуудыг ялгаруулчихаад, өрөөнөөс явсан байхад тус өрөөнд орсон эрүүл хүн халдвартын нөлөөлөлд өртөх болно. Хүйтэн уур амьсгалтай орон нутагт хүмүүс ольноороо нэг байранд цуглардаг, хэрэв тухайн бүлэг хүмүүс дотор сурьеэгийн халдвартараагч оршиж байвал, сурьеэгийн савханцарын нөлөөлөлд өртөх эгзэгийг нэмэгдүүлнэ. Харин дулаан уур амьсгалтай орон нутагт цонхыг онгойлгож агааржуулалтыг нэмэгдүүлэх хугацаа нь урт байдаг тул битүү агааржилт муутай байдлыг бууруулж агааржуулалтыг сайжруулах нөхцөл нь хүйтэн уур амьсгалтай орон нутагийнхаас илүү юм.


Халдвартын эх уурхайн нас

Халдвартын эх уурхай болсон хүний гэр бүлийн гишүүд, мөн түүнтэй хангалттай урт хугацаанд хамт нэг өрөөнд байдаг хүмүүс халдварт авах эгзэг хамгийн өндөр их байна. Аж үйлдвэр хөгжсөн орнуудад өвөө эмээгээс нь илүүтэйгээр энэг эхчүүд нь хүүхдүүдээ халдвартараадаг байна, яагаад гэвэл эдгээр орнуудад өвөө эмээ нар нь ач зээ нартайгаа хамт амьдрах явдал маш ховор юм. Аж үйлдвэр хөгжсөн орнуудад сүүлийн хэдэн арван жилд дундаж насны хүмүүсийн өвчлөл эрс нэмэгдсэн бөгөөд үүнээс ахимаг насныхны өвчлөл илүү их байна. Зураг 3-т үүнийг тодорхой дүрсэлсэн байна [9]. Финланди

улсын хүн амын дундач нас болох 30–40 насныханыг авч үзвэл, 30 наснаас эхлэн сурьеэгийн өвчлөлийн тохиолдлын тоо нэмэгдэж эхэлсэн, энэ нь удам үе дамжин эцэг эхчүүдээс нь өвөг эмэгийн үерүү чиглэжээ.

Нийгмийн оролцооны загвар нь халдвартархах хэв маягийн түлхүүр суурь нь болж өгнө [10,11]. Энэ үзлийг ойлгоход хялбар, ямарч хүн өөрийн насанд тохирсон нийгмийн давхрагт хамаарна, жишээ нь нас тогтсон хүн шилжилтийн насны хүүхдүүдтэй хамт бүхижт орон гүйж явбал билэнд их содон хараглах билээ. Онцгой тэмдэглэх зүйл бол эцэг эхчүүд болон бага насны хүүхдийн харьцаа юм. Энэ хоёр үе удам маш ойрхон харьцаж байна; нийгмийн харьцааны цаана гэр бүлийн харьцаа орших ба хүүхдүүдийн найз нөхөд нь ихэвчлэн найзынхаа эцэг эхтэй сайн холбоо харьцаатай байдаг.

Үнэн хэрэгтээ, энэ нь сурьеэгийн халдвартас эгзэг наснаас их хамаардгийг [12] баталж байгаа бөгөөд маш чухал ажиглалтаар халдварт үеэс үед дамжиж байна гэсэн одоогоор төгс батлагдаагүй ч тэгсгөлийн зөвшөөрөгдсөн онол болж байна. Нэг үеийн хүүхдүүд өсөх явцад үеийнхний дотороо болон бусад үеийнхэнтэй хавьтах явдал чухал ач холбогдолтой, тэгээд эцэг эхийн хяналтаас тухайн хүүхдүүд гарах үед энэ насны когорт төрөлттэй (эхлэлтэй) харьцаа ихээр нэмэгдэх ба бусад үеийнхэнтэй хавьтах хавьтлын хувь давамгайлах болно. Европ тив дэх сурьеэгийн тархвар зүйн өвчлөлийг авч үзвэл дунд насныхны өвчлөл маш огцом өссөн байв.



Зураг 3. Финланди улсад 1954–1995 онуудад шинээр бүртгэгдсэн уушигны хэлбэрийн сурьеэгийн өвчлөлийн насны median, насны бутцээр нийт хүн амд харьцуулсан байдал, [9]-вэс эх материалыг авав.

Шинээр бүртгэгдэх сүрьеэгийн тохиолдлын тоо ижил байсан хэдийч, залуу үед халдвар тархах эгзэг гарцаагүй буурах ёстой юм, энэ нь настай хөгшчүүл багачуудын хүмүүжил бойжуулалтанд оролцоого болж, энэ үүрэг залуу энэг эхчүүдэд очсонтой холбоотой. АНУ-ын Арканзас мужид орших асрамжийн газрын хөгшчүүлд хийсэн судалгаагаар [13], настайчуудын дунд сүрьеэгийн халдварын эгзэг өндөр хадгалагдаж үлдсэн хэвээр байхад, залуу үеийнхний дунд сүрьеэ өвчин устахгүй байх хоёр шалтгаан байна. Нэгд, халдвар ихэвчлэн үеэс үед дамждаг, хоёрт, халдвартай сүрьеэ дамжин хөгжих боломж нь хүний амьдралын үлдэгдэл (тухайн хүн ирээдүйд хэдэн жил амьд байх) хугацаатай хамт буурах болно.

Xүйсний ялгаа

Хүйсний ялгаа нийгэм бүрт харилцан ижил биш байна. Зарим нийгэмд эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байж нийгмийн амьдралд идэвхитэй оролцож байгаа бол зарим оронд эмэгтэйчүүдийн амьдрал нийгмээс тусгаарлагдсан эрх нь хаагдсан байдаг. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн халдварт өртөх боломж нь халдвартай хүн гэрт нь буюу гэрээс нь гадна байгаа хоёроос шалтгаалах болно.

БҮЛЭГ ХОЁР

СҮРЬЕЭГИЙН САВХАНЦРЫН ХАЛДВАР

Үүсгэгчийн холбогдлыг судлах тархвар судлал: нөлөөлөлд өртсөний дараагаар халдварт авах эгзэг

Мусобacterium tuberculosis-ын халдварт авахад ялангуяа, агаарын эзлэхүүний нэгжид орших халварыг агуулсан дуслын тоо (халдвартай хэсгүүдийн нягтрал) болон энэ агаараар мэдрэг хувь хүн амьсгалах хугацаа чухал ач холбогдолтой.

Халварыг агуулсан цөмтэй дусалтай агаараар халдвартархан дамжих

Хүрээлэн буй орчноос сурьеэгийн савханцарын халварыг авах эгзэг их юм (*M.tuberculosis*-ын бүрдэл, үүнд *M.tuberculosis*, *M.bovis* болон *M.africanum* хамарна).


Сүрьеэ өвчний шалтгааныг сурьеэгийн савханцар болохыг Koch нээж сурьеэгийн халдварт нь агаараар дамжидаг гэдэг таамаглалыг дэвшүүлжээ [14,15]. Яагаад гэвэл ихэнхи тохиолдолд амьсгалын замын эрхтэн гэмтэдгийг тэр тэмдэглэж, дараах дүгнэлтийг хийжээ “...савханцар ихэвчлэн агаартай хамт амьсгалагдана”[15]. Гэвч арваад жилийн дараа л үүнийг туршилтаар баталжээ [16].

Харвардын Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн Уэлсийн-ийн туршилт судалгаа нь агаар дуслын замаар дамжих халдвартын ойлголтыг хөгжүүлэхэд том тулхэц болсон [16]. Халдварт дамжуулагч хучин зүйл агаараар дамжихын тулд агаарт тогтох хөвөх чадвартай байх ёстой. Дуслын доош газарт унах хурд нь дуслын гардын талбай буюу дуслын талбайн квадрат эзрэгээс хамаарна. Чийгтэй агаарт орших маш жижиг хэмжээний дусал нь 2 метрийн өндөрөөс 10 секундээс бага хугацаанд газарт унах болно (зураг 4) [17]. Том хэмжээний дусал нь маш богино хугацаанд агаарт байх учир мэдрэг хувь хүн энэ дуслыг амьсгаалах эгзэг бага байна. Бас нэг чухал үзүүлэлт бол дуслын


шингэний уурших шинж юм. Дуслын шингэнийг ууршуулах хүчин зүйл нөлөөлснөөс дуслын хэмжээ хурдан хугацаанд багасна. Дуслууд агаарт нягтграх хугацаа нь дуслын голчийн талбайн квадрат зэрэгтэй эсрэг хамааралтай. Тэгэхээр жижиг дуслуудад энэ хугацаа маш богино байна, тэдэнд ууршуулах ямар нэгэн хүчин зүйл нөлөөлөгүй байхад 2 метр өндөрөөс унахад тохирох хугацаанаас бага хугацаа шаардагдана. Зураг 5-д нягтрал багатай агаарт янз бурийн хэмжээтэй дуслуудын уурших хугацааг дунджаар харуулсан байна [17].

Маш жижиг дуслууд маш удаан доош тунах ба маш хурдан ууршидаг, харин том хэмжээтэй дуслууд хурдан хугацаанд доош тунан унаж ууршуулах хүчин зүйлс түүнд нөлөөлж амждагтүй байна. Well борооны дусалын жишээг дурьджээ, борооны дуслын хэмжээ нь үүлийн газрын хөрс хүртэл хангалттай том хэмжээтгэй байна, харин үүний эсрэгээр ямар нэгэн үйлдвэрлэл аж ахуйд маш жижиг хэмжээний дуслуудыг шүршиж ашигладаг. Well -ийн номпол ухагдахууныг зураг 6-д схемчлэн харуулсан [17]. Уурших болон тунах хугацааны муруй (нягтрал багатай агаарт 2 метрийн өндөрөөс тунах) маш төстэй хэлбэртэй харагдах боловч эсрэг чиглэлтэй байна. 0,1 мм ба 0,2 – ийн хооронд байрлах хэмжээтэй дусал хаана ч байсан 2 метрийн зайлгтуулахаас өмнө ууршиж газар хөрсөнд хүрэхгүй байна.


5 болон 6-р зурагт тодорхой хэмжээтэй дуслуудын газарт унах тунах хугацааг үзүүлсэн байна. Тэгэхдээ ууршилт нь дуслуудын хэмжээг багасгаж, дуслын цөмийг бий болгох магадлалтай. Well дусал ууршиж цөм үлдэх хугацаа дуслын гадрын талбай буюу дуслын голчийн дөрөв дүгээр зэрэгтэй шууд хамааралтайг тодорхойлон үзүүлсэн [17].



Зураг 4. Нягтрал ихтэй чийгтэй агаарт дуслын туналт. Эх баримтыг [17]-оос авав.



Зураг 5. 18 хэмийн дулаанд нягтрал багатай агаарт дуслын шингэний уршилт. Эх баримтыг [17]-оос авав.



Зураг 6. Дуслын голчийн хэмжээнээс хамаарч дусал тунах болон уурших хугацаа. Зургийг American Journal of Epidemiology сэтгүүлийн зөвшөөрөлтэйгээр хэвлэв.

Агаарын хэм болон агаарын чийгшилийг мөн харгалзан үзэх хэрэгтэй. Их чийгтэй агаарт ууршилт мэдээж чийг багатай газрынхаас бага байна, жижиг хэмжээний дуслууд нь чийгтэй агаарт хуурай агаарт байдлаас илүү няятарч хөвөх болно. Агаарын хэм болон чийгшилтийн хүчин зүйлс нь тухах хурдал хүчтэй нөлөөлөх боловч дуслын гадарт бага нөлөөлнө. Тиймээс, дуслын хэмжээний бага зэргийн өөрчлөлт нь атмосферийн их хэмжээний өөрчлөлтөөс илүү чухал ач холбогдолтой юм.

Сүрьеэ өвчнөөр өвчилсөн хүн сүрьеэгийн савханшарыг агуулсан дуслуудыг ялгаруулж болох юм. Маш бага хэмжээний дуслуудад сүрьеэгийн савханшарууд агуулагдаж байж болно. Ийм дуслуудын шингэн ууршиж 1-ээс 2 сүрьеэгийн савханшарыг агуулсан цөм болох бөгөөд, энэ нь хүрээлэн буй агаарт удаан хугацаанд хөвж орших болно. Ийм дуслын цөм нь *M.tuberculosis* дамжин халдвартлах хамгийн чухал эх үндэс болно.

Ярих, ханиах, найтаах ба дуулах үед ийм дусалтай цөмүүд гадагш ялгарна. London, Robert нарын хийсэн туршилт судалгаа нь *M.tuberculosis* дамжин халдвартлах механизмыг ойлгоход чухал ач холбогдолтой байсан [18]. Тэд нэг ханиалга нь таван минут чанга ярихад ялгарахтай тэнцүү тооны дусалтай цөмүүд ялгаруулдагийг тогтоож энэ дуслын цөмүүд нь агаарт ханиалгаснаас хойш 30 минут хөвөн тогтоож байдгийг баталжээ.

Дээрхи физикийн онцлог шинжүүдийг мэдэх нь чухал юм, яагаад гэвэл *M.tuberculosis* нь ихэвлэн агаар дуслын замаар халдвартладаг, санамсаргүйгээр халдвартай материал тарьснаас халдварт авах явдлаас тусдаа оршино [19-22]. Агаарт орших сүрьеэгийн савханшар агуулсан дусалтай цөмийг амьсгаалж, энэ цөмийн хэмжээ нь ушигны захын цуцландаа хүрч чадахуйц бага хэмжээтэй байж чадвал халдварталт жинхэнэ утгаараа явагдлаа гэж үзнэ. Дээрхи үйл явдал тус агаарт хэдэн шагийн туршид байсан тохиолдолд өрнөж болох юм. Том хэмжээтэй дуслууд нь ихэвчлэн хурдан доош тунан унана, харин хэрэв амьсгаалгдвал гуурсан хоолойн мукоцилиар салст системийн үйлчилгээгээр шүүлстэй хамт гадагшлагдаж цэвэрлэгдэх буюу заалгигддаг байна. Sōnkin -ын судалснаар дуслуудын 5мм-ээс том голчтойнууд нь хамарт үлдэж, 0,1 мм-ээс бага голчтой нь ушигны цуцлан хүрэх боломжтой байдаг байна [23]. Тиймээс халдварт авахад хамгийн чухал нөлөөтэй зүйл бол дуслын хэмжээ юм. Дуслуудын голч хэмжээ нь ихэвчлэн 1-5 мм-ийн хооронд хэлбэлзэнэ.


Riley ба хамтран зүтгэгчид нь хэд хэдэн туршилт судалгаагаараа агаараар халдвартладаг сүрьеэг судалжээ [16,24]. Сүрьеэтэй өвчтөнүүдийн тасгийг нарийн хяналттай хаалттай эргэлттэй агааржуулалтын хоолойгоор эрүүл усан гахайнууд орших том танхимтай холбожээ. Эдгээр амьтдыг хянан, нядалж эрхтэнүүдийг нь судалсны үндэс дээр, халдварт авахад агаарт байх халдвартай дуслын тоо хэмжээг тодорхойлжээ. 340 куб метр агаарт дунджаар нэг халдвартай дусал оногдож байв. Тус тасгийн өвчтөнүүдийг сувилсан сувилагчийн тухайн агаараар амьсгалсан хугацааг төоцоолжээ.

Халдвартыг дунджааар (туберкулины сорил сөрөгөөс эзэрт шилжиснээр) нэг жилд нэг [25] эсвэл хагас жилд нэг [26] байна гэсэн тооцоог гаргажээ.

Халдвартай өвчтөний тодорхойлолт

Халдварт агуулсан дуслуудыг ушигны халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөн агаарт ялгаруулаж, цацаж халдвартараана. Тэгэхдээ амьсгалын замын сүрьеэтэй өвчтөн тэр бүр халдвартараах чадвартай биш байдаг.

Цэргийн сорьсонд агуулагдах савханцарын тоо халдвартараах боломжтой шууд хамааралтай байдаг. 1 мл цэрэнд 5000 сүрьеийн савханцар байвал цэргийн шинжилгээний эзэр дун янз бүрийн шалтгааны улмаас өөрчлөгджэй болно [27]. Харин цэрэнд 10000 савханцар байгаа тохиолдолд 95 хувьд нь эзэр хариуг илрүүлэх боломжтой юм [28]. Тийм учраас халдвартай хэлбэрийн сүрьеэг илрүүлэхэд чухал үүрэгтэй шинжилгээний тоонд цэргийн бичил харуурын шинжилгээ орно, гэвч энэ аргаар бүх хэлбэрийн сүрьеэг оношлоход мэдрэг биш юм.




Зураг 7. Нян судлалын шинжилгээний дүнгээс хамаарч ушигны сүрьеэгийн тохиолдолуудын халдвартуулах онцлог. T+/θ+-цэргийн түрхэц болон өсгөвөр зерэг; T-/θ+- цэргийн түрхэц сэрэг, өсгөвөр зерэг; T-/θ- цэргийн түрхэц болон өсгөвөр сэрэг. Эх баримтыг [29-31]-аас авав.


Хэд хэдэн судалгаагаар цэрний түрхэц-эерэг, цэрний түрхэц-сөрөг, зөвхөн өсгөвөр-эерэг ба өсгөвөр-сөрөг сурьеэг халдвартараах боломжтойн холбож судалжээ [29-31]. Эдгээр судалгаагаар цэрний түрхэц-эерэг өвчтөн нь цэрний түрхэц-сөрөг өсгөвөр-эерэг өвчтөнтэй харьцуулахад маш ихээр халдвартараадаг болохыг баталжээ (зураг 7). Үүнийг ойрын хавьтал болох сурьеэгийн сорил-эерэг хүүхдүүдийн харьцаагаар тодорхойлсон (зураг8). Эдгээр гурван судалгаануудад халдвартархалтын дүн нь их зереөтэй гарсныг халдвартархалтын үндэс болон хавьтлын тодорхойлолтыг ялгаатай авсантай холбоотой гэж тайлбарласан байна. Цэрний түрхэц-эерэг, цэрний түрхэц-сөрөг мөн зөвхөн өсгөвөр-эерэг халдвартархалтын нөлөөллийг хүүхдүүдийн дунд судалсан нь их чухал юм. Энэ нөлөөлөл нь хоорондоо их ялгаатай байсан бөгөөд дээрхи гурван судалгаанд бүгд ижил байв. Үүнээс үндэслэн зөвхөн өсгөвөр нь эерэг өвчтөнүүд, цэрний түрхэц болон өсгөвөр нь хоёулаа серег өвчтөнүүд нь хяналтын хэсгийн хүмүүсээс илүүтэйгээр халдвартараадаггүй болохыг нь тогтоожээ. Эдгээр судалгаануудад үндэслэн цэрний түрхэц-эерэг сурьеэтэй өвчтөнүүд нийгэмд чүйтэй халдвартархалтын эх уурхай болдгийт нотолжээ.

Финланди улсад хийгдсэн судалгаагаар цэрний түрхэц-эерэг мөн түрхэц-сөрөг (өсгөвөөр батлагдсан) өвчтөнүүдийн хавьтлыг хоёр жилийн турш тандан судлалсан байна [32]. 134 сурьеэгийн тохиолдлын 609 хавьтлыг судалгаанд хамруулсан, судалгааны явцад хавьтлуудаас 4 хүнд сурьеэ өвчин илэрсэн, тохиоллтуудын 69 нь хүнд хэлбэрийн цэрний түрхэц-эерэг сурьеэтэй байсныг тэмдэглэх хэрэгтэй. Тэгсэн ч, энэ судалгаанаас үндэслэн бичил харуурын шууд шинжилгээгээр цэрний түрхэц-сөрөг байсан өвчтөнүүд бүгдээрээ халдвартараах чадваргүй гэсэн дүгнэлт хийж болохгүй юм. АНУ-ын Сан Франциско, Калифорни мужид молекулын fingerprinting техник ашиглаж явуулсан судалгаагаар нийт халдвартархалтын 17 %-ийг түрхэц-сөрөг оноштой хүнээс авсан байсан нь тогтоогдсон, түрхэц-сөрөг халдварталтыг түрхэц-эерэг сурьеэтэй харьцуулаж үзэхэд 0,22 байсан, өөрөөр хэлбэл халдварталтын тавын нэг нь түрхэц-сөрөгөөс байна [33].

Халдвартай хэлбэрийн сурьеэтэй өвчтөнөөс хавьтал нь халдвартавах эгзэг, индекс тохиолдолтой хавьтах хүний тоо буурахтай зэрэг буурна [34], ойрын хавьтлын үнэн тоог гаргахад хавьтлын хүмүүс зарим тохиолдолд гаднаас халдвартавч болохыг анхаарах хэрэгтэй, үүнийг тооцоолохгүй бол ойрын хавьтлын тоог хэтрүүлэн тогтоох халгаатай. Ойрын хавьтлын үнэн тоог хол давсан нийт тохиолдлын тоо дээрхи тохиолдолд буртгэгдэх болно. Үүний талаар 9-р зурагт дүрсэлсэн байна, ойрын хавьтал халдвартавах магадлал хамгийн их 10-т гурав (доторхи дугуй), дараагийн дугуйд 20-д гурав; санамсаргүй хавьталаад дээрхи хоёр дугуй доторхоос хамаагүй бага байна.



Зураг 8. Нян судлалын шинжилгээний дүн болон эх уурхайтай хэр ойрхон байснаас хамаарч халдвартархсан байдал.[30]-вас эх баримтыг авч хэвлэв.



Зураг 9. Ойрын (дотор дугуй), дунд завсрыйн (гаднах дугуй) болон санамсаргүй хавьтлын халдвартавах эгзэгийн жишээ. Халдвартын эх уурхай хас тэмдэгээр, халдвартавах харлуулсан дугуй, халдвартавах хавьталаан хоосон дугуйгаар дүрслэгдсэн.

Агаарын эргэлт солилцоо ба агааржуулалт

Тодорхой хэмжээний сурьеэгийн савханцар агаарт цацагдаж байж мэдрэг хувь хүн энэ агаараар амьсгалснаар халдварт авах болно. Дуслын цөм нь агаарт маш богино хугацаанд цацагдан өрөөний бүх хэсэгт тархах ба мөн агаартай хамт хaa ч хурч чадна [35].

Сурьеэ өвчний халдвартыг бусад агаар дуслын замаар халдвартладаг өвчнүүдтэй харьцуулахад тийм ч амар халдвартладаг өвчин биш юм [36]. Химиэмчилгээ нэвтрэхээс өмнөх үед, сувилагч оюутанууд дунджаар 12-18 сар халдвартай хэлбэрийн сурьеэтэй хүнтэй хамт байж халдварт өртдөг байсныг Relyey-ийн тооцоолжээ [25-26].

Сурьеэ өвчний дэгдэлт гархад агаарын эргэлт солилцоо, агааржуулалт ямар их холбогдолтой болохыг АНУ-ын тэнгэсийн цэргийн усан онгоц дээр хийсэн судалгааны дүн харуулсан [37,38]. Энэ усан онгоц дээр байсан 308 хүний 139-д нь урьд нь туберкулины сорил сөрөг байсан бөгөөд тэд нар бүгд нэг эх уурхайгаас сурьеэгийн халдварт авсан нь тогтоогдижээ. Сорилын дүн сөргөөс зэрэгт шилжсэн хувь хамгийн өндөр байсан хүмүүсийн өрөөг зааглан ялгаж үзжээ. Гэвч эх уурхайгаас хол орших өрөөнд амьдардаг болон эх уурхайтай хамт ойрхон ажилладагтүй хүмүүс халдварт авсан байв, тэгэхдээ эдгээр өрөөнүүд хоорондоо агааржуулах хоолойгоор холбогдсон байсныг тэмдэглэх хэрэгтэй. Харин өрөөнүүд нь агааржуулах хоолойгоор холбогдоогүй боловч ижил хэмжээний нөлөөлөлд өртсөн эрэгтэй хүмүүсийн сорилын сөргөөс зэрэгт шилжих нь хамаагүй цөөхөн байсан байна. Халдвартын эх уурхайг тусгаарласны дараа удаан хугацаанд сөргөөс зэрэгт шилжих үзэгдэл үргэлжилж байсан ба энэ нь битуу хаалттай эргэлтэнд халдвартай дуслын цөмүүд хадгалагдаж үлдсэнтэй холбоотой байх магадлалтай.

Агааржуулалт халдвартай дуслын цөмийн нэгж эзлэхүүн дэх тоог бууруулж шингэлж байдаг. Тэгэхлээр, эмнэлгийн тасгуудад ханиалтыг өдөөх эмчилгээ үйлчилгээний үед болон дараа, цонхыг тогтмол онгойлгож агааржуулах нь халдвартын дамжих нөлөөллийг бууруулах, таслахад нөлөөлөх хамгийн гол биш юмаа гэхэд чухал хүчин зүйлүүдийн нэг юм.

Мэс засалчидад зориулсан амны хаалт нь ам хамарыг хоёуланг тагладагтүйгээс гадна 5 мм-ээс бага хэмжээний голчтой хэсгийг шүүж чаддагтүй учраас сурьеэгийн халдварт өртөж болох хүмүүсийг хамгаалах үр нөлөө багаатай. Аж үйлдвэр хөгжсөн орнуудад олон эмэнд дасалтай сурьеэ бий болж байна, тийм учраас эмнэлгийн ажилтнуудад нь тусгай –high efficiency particulate air– filter respirator- амны хаалт хэрэглэх зөвлөмж гарсан [39]. Энэ амны хаалт нь 1-5мм-ийн голчтой хэсгийг шүүх чадвартай. Үүний үнэ нь мэс заслынхаас хэд дахин их, гэвч арьс амны хаалт хоёрын завсраар дуслын цөм нэвтрэхээс хэрхэн сэргийлдэг талаар баримт мэдээ ховор байна. Энэ амны хаалтыг нэвтрүүлэхэд санхүүгийн хүндрэлтэй.

Халдвартын эх уурхайн халдвар ялгаруулахыг таслан зогсоох

Халдвартын эх уурхайн халдвартай дуслыг ялгаруулахгүй болгох нь халдвар тархах замд нөлөөлөх хамгийн үр дүнтэй арга юм. Ханиалгах үедээ амаа (хамараа ч бас) дарж хаах нь агаарт цацагдаж тархах халдвартай дуслын тоог бууруулахад ихээр нөлөөлөх нэг хүчин зүйл болно. Халдварыг таслан зогсооход хамгийн чухал нь өвчтөнийг эмчлэх явдал бөгөөд ингэснээр халдварыг тарааж буй цэрийн түрхэц-эерэг өвчтөнийг хэдхэн долоон хоногийн дотор халдвар тараадаггүй болгоно [4,41-44].

Хүний биеийн дархлалын тогтолцоо

Хувь хүн халдвар авах эгзэгт хүрээлэн буй орчны олон хүчин зүйлс нөлөөлдөг тухай дээр дурьдсан. Үүнээс харахад сүрьеэгийн савханцар ушигтын цулцанд наалдах нь сүрьеэгийн халдвар авах ганц суурь болдог мэт ойлголт төрж болно. Гэвч энэ нь тийм биш бөгөөд үнэн хэрэгтээ үнэмшилгүй юм. Сүрьеэгийн савханцар ушигтын цулцангийн хананд наалдан сууснаар хоёр үр дүн гарна: нууц хэлбэрийн сүрьеэгийн суурь болох, эсвэл ингэх боломжгүй бол устаж алга болно. Цулцангийн макрофаг эсэд залгигдаж, сүрьеэгийн савханшаруд нь фагосом болон гадны биетийг устахаа фагосом-лизосомын хайлтуулах үйлчлэлд өртөж хүчил төрөгчийн радикал, идэвхитэй азотын завсрлын бүтээгдэхүүн болон задарна [45]. Хүн бүрийн макрофагийн үйл ажиллагаа нь янз бүрийн нөхцөл байдалаас хамаарч ялгаатай байна. Тийм учраас хүний биеийн эсэргүүцэл дархлалын байдал нь сүрьеэгийн савханцар биед нэвтрэн суурьшиж, сүрьеэгийн халдварын суурь тавигдах эгзэгийг тодорхойлогч болдог нь илэрхий юм.

Халдвар дамжих замын бусад хэлбэр: *M.bovis*

Сүү, маш олон оронд үндэсэн хүнс нь болдог. Өнгөрсөн хэдэн зууны турш олон тооны нярай болон бага насны хүүхдүүдийн нас барагтын шалтгаан болж байсан *M. bovis* нь сүрьеэ өвчний шалтгаан болдог ихээр анхаарал татдаг эмгэг төрөгч юм [46].

1846 оны үеэр үнээний сүү хөхдөг хүүхдүүдэд захын тунгалагын булчирхайн сүрьеэ өвчин эхийн хөхөөр бойждог хүүхдүүдтэй харьцуулахад илүү ихээр тохиолдог нь ажиглагджээ [47]. Үхрийн сүрьеэгийн савханцар хүнд өвчин үүсгэдэг гэсэн ойлголтыг 20-р зууны эхээр Koch үгүйсгэснээр өөрийгөө эрдэмтдийн хүрээнээс улам ихээр тусгаарлах үл ойлголшлыг үүсгэсэн [47,48]. Тэгэхэд 20-р зууны эхний арван жилийн малын эмч нар, ялангуяа АНУ-д сүүний фермийн малд сүрьеэгийн сорил тавыж халдвар авсан малыг нядалж устгадаг хөтөлбөр хэрэгжүүлэж эхэлсэн байжээ. Европын үхрийн сүрьеэтэй тэмцэх ажил арай хожуу эхэлжээ. Их Британид 1932 оны байдлаар нийт малын 40% нь сүрьеэгээр өвчилсөн байсан ба саалийн үнээний 0,5 % нь

сүрьеэгийн савханцарыг сүүтэйгээ ялгаруулж байжээ [47]. 1935 оноос нийт малдаа сүрьеэгийн сорил тавьж, халдварт авсан байсан малыг няллан устгадаг ажил тогтмол хийгддэг болжээ [47]. 1965 он гэхэд нийт мал сүргийн 1% нь халдвартлагдсан хэвээр үлдэжээ[47]. Малын сүрьеэз байрлалын хувьд ихэнхи тохиолдолд цээжний эрхтэнд (80-90%), үлдсэн хувьд нь элэг, бөөр, дэлүү, давсагт, харин дэлэнд 1-2 %- д бүртгэгдсэн байна. Дэлэнгийн үрэвсэл (мастит)-тэй саалийн үнээний сүрьеэгийн савханцартай сүүг ариутган хэрэглээгүйгээс хүнд ухрийн сүрьеэгийн халдварт дамжих нөхцөл бүрдэнэ.

Халдвартлагдсан сүрэг болон хүний сүрьеэгийн давтамж уялдаа холбоог Дани улсын Magnus маш өргөн дэлгэрэнгүй судалжээ [49-51]. Энэ улсад 1937 онд саалийн үнээний 50% нь сүрьеэгийн савханцараар халдвартлагдсан байснаа 1950 он гэхэд 0,3% болглоо маш эрчимтэй буурчээ (зураг 10)[49]. Энэ зурагт малын сүрьеэгийн тархалт нэг улсын дуургүүдэд ялгаатай байдгийг харуулжээ. Халдвартлагдсан мал болон сүрьеэгийн сорилд урвал өгөх хүн хоёрын тоо шууд хүчтэй харьцаатай болохыг баталжээ (зураг 11)[50]. Тийм учраас *M.bovis* нь нийт сүрьеэгийн халдвартын тархалтанд их нөлөөтэй хүчин зүйл болно.


Харин үүнээс ялгаатай нь хонь, ямаа, адлуу, зэрэг мал нь *M.tuberculosis*-ын халдвартыг авч болох боловч сүрьеэз өвчин нь зөвхөн өөрслөөр нь хязгаарлагддаг байна [28,58].

M.tuberculosis-той харьцуулахад *M.bovis* хүнээс хүнд халдварлах нь маш ховор гэдэг нь бүрэн нотлогдсон [53,54].


Бичиглэлийн тархвар судлал: халдвартын шинэ тохиолдол болон тархалт

Халдвартыг хэмжих арга зүй

Koch, анх сүрьеэгийн үхсэн савханцарын ялгаруулдаг эсрэг биеийн холимог болох, туберкулиныг гаргаж авч, үүнийгээ сүрьеэз өвчинийг эмчлэх өвөрмөц эмчилгээ нээчихлээ гэж бодсон [55,56]. Тэр туберкулиныг мөн оношлогоонд ашиглах боломжтой болохыг танин мэджээ [56]. Сүрьеэз өвчиний эмчилгээнд туберкулиныг хэрэглэж, үр дунд хүрэх найдлага удахгүй үгүй болсон ч, туберкулин нь *M.tuberculosis*-ын халдвартыг ялган оношлоход чухал хэрэгслэл болон хэвээр үлдсэн юм. Орчин үед ч туберкулины сорил нь сүрьеэгийн халдвартыг ялган оношлох боломжтой ганц хэрэгслэл хэвээр байна. Нийгэмд сүрьеэгийн эпидеми тархах хэв загварыг ойлгоход сүрьеэгийн халдвартыг судлах нь чухал учир, цаашид энэ асуудлыг дэлгэрэнгүй хэлэлцэн өгүүлэх болно.



Зураг 10. Дани улсын 2 дүүргийн малын сүрьеэгийн ёвчлэл, 1937–1950 [49]. Зургийг [49]-ээс хэвлэв.



Зураг 11. Сүрьеэтэй малын эзлэх хувь (1937–1939 он) болон хүн амын туберкулины мэдрэг байдлын хувийн (1950–1952 он) уялдаа холбоо, Дани улс. ДЭМБ-ийн зөвшөөрөлтэйгээр [50]-аас зургийг хэвлэв.

Туберкулины сорилын түүхийг гурван том хэсэгт хувааж болно. Энэ зууны эхэнд эхэлсэн нэгдүгээр үед энэ сорилын мэдрэг чанарыг судлахад төвлөрч байсан. Хоёрдугаар үед эрэл хайгууль уг сорилын өвөрмөц байдалд чиглэн төвлөрсөн байсан, харин орчин үед судалгаа энэ хоёр шинж чанарт үндэслэн халдварын тархалтыг тогтоох ажиглах, мөн янз бүрийн нөхцөл байдалд яаж өөрчлөгдж болох таамаглалыг судлаж байна. Халдвар ба өвчин хоёрыг ялгах чадвартай шинэ арга хэрэгслэлийг гарган авах оролдлогууд өдий хүртэл бүтэлгүй байна.

Туберкулины сорилын мэдрэг чанарын үнэлгээ

Сорилын шинжилгээний мэдрэг чанар нь онош нь тодорхой хүмүүсийг хэр үнэн зөв ялгаж байгаа харьцаагаар тодорхойлогдоно (хүснэгт 1)[57]. Мэдрэг чанар өндөр байх нь онцгой чухал юм. Жишээ нь, цус шилжүүлэх юулэхэд халдвар дамжуулагч хүчин зүйлсийг тодорхойлдог шинжилгээ нь маш өндөр мэдрэг чанартай байхыг шаарддаг.

Энэ зууны эхэн үед von Pirquet туберкулины сорилыг арьсан дээр тавих аргыг нэвтрүүлсэн [58]. Ариутгасан арьсыг бага зэрэг зуран урж, түүн дээр туберкулиныг дусаах аргаар энэ сорилыг тавьдаг байсан. Хүнд хэлбэрийн сурьеэд энэ сорилийн мэдрэг чанар 100% -иас доошгүй байсныг тэр тэмдэглэсэн.

Мөн удахгүй үүний дараа Mogo, арай хялбар арга болох арьсанд туберкулиныг урж түрхэх аргыг нэвтрүүлсэн, энэ аргын мэдрэг байдлын үр дүн нь von Pirquet-ийн аргын үр дүнтэй дүйцэхүйц байсныг тогтоосон [59].

Mendel [60] болон Mantoux [61] нар энэ үед нэгэн зэрэг тариурын тусламжтайгаар туберкулины тодорхой тунг арьсан дотор тарих арга техникийг нэвтрүүлсэн.

Сорил тарих олон арга техник байдаг ч орчин үед дэлхий нийт арьсан дотор тарих арга техникийг сонгон шилж байна. Тархварын судалгаа хийхэд туберкулиныг зөвхөн арьсан дотор тарих аргаар тавьж хэрэглэх албан ёсны зөвлөмж байдаг [62-66].

Мал эмнэлэгт туберкулины сорилын өвөрмөц чанартай холбоотой учирч буй хүндрэлүүд

Сорилын шинжилгээний өвөрмөц чанар нь өвчтөний онош тодорхой биш байхад хэрхэн зөв ялангтан оношилж байгаа харьцаагаар тодорхойлогдоно [57]. Хэрэв хэн нэгэн тодорхой нөхцөл байдлын талаар эргэлзээгүй мэдэх шаардлагатай болвол сорилын өвөрмөц чанар нь их өндөр байх хэрэгтэй юм. Жишээ нь, өвчтөнд Хүний Дархал Хомсдын Вирусын (ХДХВ) халдвар авсныг нь мэдээлэхийн өмнө, шинжилгээний дун нь баталгаатай зөв байж, өвчтөн үнэхээр халдвар авсан нь үнэн байх ёстой. Энэ нь шинжилгээний

Хүснэгт 1. Сорилын шинжилгээг тодорхойлогч шинж чанарууд

Сорилын дун	Шинж тэмдэг байгаа эсэх талаархи мэдээлэл		
	Байгаа	Байхгүй	Бүгд
Эерэг	a	b	a+b
Сөрөг	c	d	c+d
Бүгд	a+c	b+d	N=a+b+c+d
a/(a+c):	сорилын мэдрэг байдал (шинж тэмдэгтэй хүмүүсийг зөв ялгасан хувь)		
d/(b+d):	сорилын өвөрмөсийн байдал (шинж тэмдэгтгүй хүмүүсийг зөв ялгасан хувь)		
(a+c)/N:	шинж тэмдэгийн тархалт		
a/(a+b):	эерэг сорилын таамаглах хэмжигдэхүүн		
d/(c+d):	сөрөг сорилын таамаглах хэмжигдэхүүн		
b/(a+b):	эерэг дун доторхи хуурамч эерэгийн харьцаа (харьцангуй хуурамч эерэг)		
b/(b+d):	шинж тэмдэгтгүй тохиолдлууд хуурамч эерэгийн харьцаа (абсолют хуурамч эерэг)		
c/(c+d):	сөрөг дун доторхи хуурамч сөрөгийн харьцаа (харьцангуй хуурамч сөрөг)		
c/(a+c):	шинж тэмдэгтэй тохиолдлууд хуурамч сөрөгийн харьцаа		

алдаатай дунзээс болж өвчтөнд үхэлд хүргэдэг өвчинөөр өвдсөн байна гэж худлаа мэдээлэхээс сэргийлж сэтгэл санааны хямралаас хамгаалах болно.

Мал сурэгт сурьеэгийн халдварт хэр их хор уршигтай болохыг АНУ-д хамгийн эрт танин мэдэж, халдварт авсан малыг устгах хатуу чанд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Эерэг туберкулины сорилын дунд үндэслэн няллах малыг ялгаж байсан байна. Туберкулины сорилоор оношлон нялалсан мал сурьеэгийн улмаас үүсэлтэй ямар нэгэн гэмтэл илрээгүй байжээ [67-69]. Эдгээр ажиглалт нь сорилын эерэг дүнтэй эрт анхааран таамаглан хэмжих нь тодорхой нэхцэлийн тархлалтыг тогтоож болдгийг нээсэн: Hastings сурьеэгийн улмаас ямар нэгэн гэмтэлгүй урвал өгөгчдийн тоо өсөхтэй хамт сорилын урвалд хариу өгөгчдийн тархалд буурах болохыг тогтоожээ (зураг 12)[68]. Үүнийг хүрээлэн буй орчин дахь mycobacterium-ын нөлөөллийн үр дун гэж тайлбарлаж болно.


Хүнд тохируулж туберкулиныг стандартчлах болон тунг тохируулах

Хүнд арьсан дотор сорил тарихад мал эмнэлэгт гарсан бэрхшээлүүд мөн адил давтагдсаныг нэлээд хожуу ч гэсэн хүлээн зөвшөөрсөн. Сорилын мэдрэг чанарыг сайжруулахын тулд туберкулиныг цэвэрлэх ороллогууд хийгдсэн, ягаад гэвэл хэрэглэж байсан туберкулинд (Хуучин Туберкулин) боловсруулан гаргаж авсан аргаас нь хамаарч маш олон тооны төрөл бурийн уураг агуулдаг байжээ. Florence Seibert-ын туберкулиныг цэвэршуулэх арга олны сайшаалыг хүлээж, олон улсын стандартыг бий болгох үндэс суурийг тавьсан [70-72]. Түүний боловсруулан гаргаж авсан туберкулиныг 1951 онд ДЭМБ олон улсын стандарт болгон баталсан [73]. Энэ нь 49608 серийн дугаартай Purified Protein Derivative (PPD-уургаас цэвэрлэн гаргаж авсан гэсэн уг) туберкулин юм. Энэ туберкулиныг PPD-S ("S-standart") буюу PPD-M("Mammalian") гэж нэрэлдэг [74].


Олон улсын туберкулины нэгжд 0,000028 мг стандарт биологийн идэвхит бодис агуулагдана, 49608 серийн дугаартай PPD-д 0,00002 мг PPD дээр 0,000008 мг давс нэмэгдсэн байдаг. Үндсэн бодисын дээж Дани улсын Копенгаген хотод Statens Serum Institute-д хадгалагдаж, 500 000 нэгжийг агуулсан хатаасан хэлбэрээр тараагдлаг. Шинээр үйлдвэрлэгдсэн бүх туберкулин усан гахай дээр туршигдаж стандарт нь баталгаажсны дараа худалдагдах ёстой.

Мэдрэг ба өвөрмөц чанаарууд нь хоорондоо харилцан уялдаатай, мэдрэг чанарыг нэмэгдүүлэхээр өвөрмөц чанар нь буурах эсвэл эсрэгээрээ байдаг учир, тарих техник (арьсан дотор тарих арга техник) болон стандартчилсан PPD туберкулинд тохирох тунг тодорхойлох шаардлагатай байсан. Хавьтальтай болон хавьтальгүй байсан хоёр бүлэг хүмүүсийг сонгон авч дэс дараатайгаар тун нь нэмэгдэх туберкулиныг тарьж, хариу урвалыг өгсөн нийлбэр харьцааг тодорхойлсон (зураг 13)[75]. Хавьтальтай байсан хүмүүс туберкулины бага тунд урвал өгж байсан ба энэ тун өгөгдсөний дараагаар тэдний урвалын өсөлт ач холбогдол бүхий байж чадахгүй байна. Харин үүний эсрэгээр хавьтальгүй байсан хүмүүс бага тунд урвал өгж байсан боловч тунг нэмэхлээр урвалын хэмжээ нэмэгдэж байсан байна.

Магадгүй хамгийн итгэлтэй жишээ бол эрүүл хүүхдийн урвалын давтамжийг сурьеэтэй өвчтөнийхтэй харьцуулсан явдал юм [75]. Хүүхдүүдийг АНУ-ын Огайо муж дахь асрамжийн газраас сонгож авчээ. Эдгээр хүүхдүүдийн хүрээлэн байсан гадаад орчиндоо халдварт авах боломж маш өчүүхэн байв [76]. Сурьеэтэй өвчтөнүүдийн булэг нь онош нь батлагдсан сурьеэтэй өвчтөнөөс бүрдсэн байсан бөгөөд тэдэн дотор өвчний явц хүндэрсэн хүн байгаагүй байна. Мянганы арваны нэг мг PPD-S туберкулинд бүгд сурьеэтэй өвчтөнүүд урвал өгчээ. Харин сурьеэгийн нөлөөлөлд өртөж байгаагүй хүүхдүүдийн 20%-д нь урвал илэрчээ, энэ нь ямар нэгэн санамсаргүй



Зураг 12. Туберкулин-эрэг малын тархалт болон задлангаар оношлогдсон тохиолдлуудын давтамж. Эх баримтыг [68]-аас авч хэвлэв.




Зураг 13. Сурьеэтэй өвчтөнтэй хавьталтай байсан эсэхээс нь хамаарч, туберкулины нэмэгдэх тунд хариу урвал өгсөн сорилын нийт давтамж. Эх баримтыг [75]-аас авав.


тохиолдоор *Mycobacterium* ховор байдаг орчноос нөлөөлөлд нь өртж халдвартыг авсан байж болох юм (зураг 14)[75].

Үүнтэй ижил үр дун өөр нэг судалгаанд батлагдсан [77], хавьтлын түүхтэй байсан өвчтөнүүд стандарт тун болох 5 ТН (туберкулины нэгж) PPD-д хариу урвал өгөх харьцангуй эгзэг (relative risk) нь, хавьтлын түүхгүй өвчтөнүүдийнхээс өндөр байсан (зураг 15). Эдгээр судалгаануудаас үндэслэн 5 ТН PPD-S мэдрэг ба өвөрмөц чанарыг хамгийн тохиромжтойгоор тэнцивэржүүлдэг тун гэж дүгнэсэн.


1955 онд НҮБ-ийн хүсэлтийг хүлээн авч Дани улсын Statens Serum Institute-д Tuberculin PPD RT 23 нэртэй их хэмжээний туберкулиныг үйлдвэрлэсэн [78, 79]. Твин 80 сорбитен монолеитын бутгээгдхүүн болох полиоксиэтиленийт тогтвортжуулагч болгон туберкулинд нэмжээ. Энэ нь хүчийг нь нэмэгдүүлж дунджаар 2 PPD-S-тэй тэнцэхүйц болсон байна. АНУ-д 5TH PPD-S-г, PPD RT-23-ийн [80] олон янзын тунтай харьцуулсан судалгаа хийгджээ. Энэ судалгааны дунд 2TH PPD RT 23 ба 5TH PPD-S туберкулинууд сурьеэгийн тархалт ихтэй нутгийн эрүүл эскимос хуухдуудийн арьсан дээрхи урвал сурьеэгийн тархалт бага нутгийн хуухдуудийнхтэй ижил байсныг тогтоожээ (зураг 16). Энэ 2 тунгийн дээрхтэй адил тархалтыг АНУ-ын тэнгэсийн шинэ цэргүүдийн дунд илрүүлжээ.



Зураг 14. Эрүүл хүүхдүүд болон сүрьеэтэй өвчтөнүүдээс туберкулины тунг өсгөх өгөхэд хариу урвал үзүүлсэн нийлбэр давтамж. Эх баримтыг [75]-аас авч хэвлэв.



Зураг 15. Хавьтлын байдлаас хамааран стандарттаас дээш тунд хариу урвалын харьцангуй эгзэг. [77]-оос эх баримтыг авав.



Зураг 16. Эскимос хүүхдүүд болон АНУ-ын тэнгэсийн шинэ цэргүүдийн доторхи 5 TU tuberculin PPD-S (тод шугам) болон 2 TU tuberculin PPD RT23 (цэгчилсэн шугам) –нд хариу урвалаар үүссэн гүвдрүүний хэмжээний тархалт, давтамж. ДЭМБ-ын зөвшөөрөлтэй [80]-аас эх баримтыг авав.

Гэвч судлаачдын тэмдэглэснээр 2 ТН PPD RT 23 туберкулин завсарын эргэлзээтэй (бмм ба дээш) урвалтай (40%) хүмүүсийг зүүн өмнөд бүсээс ирсэн шинэ цэргүүдэд ялгаж чадсан боловч, *Mycobacterium*-ын халдварт тархалт өндөр орон нутагт PPD RT 23 туберкулины өвөрмөц чанар сул байжээ [80].


Стандарт тунтай туберкулины сорилын мэдрэг чанарын хэлбэлзэл

Стандарчилсан тарих арга ба стандарчилсан тун (5 ТН PPD-Stэй тэнцэх) байвч урвалын олон янзын хэмжээ илрэй нэг орон нутаг дотор тархдагийг ажиглаж болно [81]. Үүнийг АНУ-ын Минессота болон Өмнөд Каролина мужийн жишээн дээр харж болно (зураг 17)[82]. Минессота мужийн халдварт авсан хүмүүсийг халдварт аваагүйгээс нь настын ангилалаар амархан ялгаж болж байсан бол харин үүнийг Өмнөд Каролина мужид хийхэд илүүтэй хэцүү байжээ.


1958-1965 онуудад АНУ-ын тэнгэсийн шинэ цэрэг нарын дунд туберкулины хамгийн том судалгаа хийгдсэн. Үүнд бараг 700000 шинэ цэргийг хамруулсан байна [76]. Мөн судалгааны нэг хэсэг болгон 5544 сурьеэтэй өвчтөнд 5 ТН PPD туберкулинээр сорил тавьсан. Элгээр өвчтөнүүдэд илэрсэн урвал нь хэвийн урвалын дүнтэй их ойролцоо байсан ба хамгийн өндөр урвалын давтамж 16-17 мм орчим байв (зураг 18). Сурьеэтэй өвчтөнүүдэд хэвийн урвал илэрсэн, үүнтэй ижил үр дүнтэй судалгааг өмнө нь ДЭМБ-аас хийсэн байжээ [83]. Сурьеэтэй өвчтөнтэй хавьталатай байсан эсэхийг нь тодоттон асуулга авчээ. Асуулгын дагуу хуваасан бүлгүүдийн туберкулины сорилын дунг зураг 19 дээр харуулсан байна [76]. Урьд нь сурьеэтэй өвчтөнтэй хавьталатай байгаагүй шинэ цэргүүдийн тоо дунджаар 400000, харин хавьталатай шинэ цэргүүдийн тоо 10000-аад байжээ. Судалгааны явцад хавьталатай байсан эсэх талаар мэдэхгүй цэргүүдийг, халдварт авсныг халдварт аваагүйгээс ялгаж үнэлэх боломжгүй байв.

Мөн энэ хөтөлбөрийн нэгэн хэсэг болгож тодорхой нэг дүүрэгт (АНУ 3000 дүүрэгтэй) насан туршид амьдарч байгаад цэрэгт татагдсан цагаан арьстай 300000 шинэ цэргүүдэд PPD-B туберкулины сорил тавьж шинжилсэн байна. Энэ нь анх АНУ-ын Жеоржия мужийн Роме хотын Battey hospital-д *M.intracellularare*-г тусгаарлан ялгаж авсаны үр дунд, *M.intracellularare*-ээс гаргаж авсан эсрэг биеийн “*sensitín*” агуулсан бүрдэлийн бэлдмэл юм [84-88]. Хүрээлэн буй орчны *Mycobacterium*-аас гаргаж авсан *sensitín* агуулсан туберкулинд үзүүлсэн хариу урвалын хэмжээний давтамж, газар зүйн байрлалын хоорондох ялгааг зааглан харуулж байна (зураг 20)[76].

Нөлөөлөгч хүчин зүйлээс хамаарч, ижил голчтой туберкулины сорилын дун сурьеэгийн халдварталтын ялгаатай магадлалыг илтгэж чадна. Rust Thomas нар АНУ-ын тэнгэсийн шинэ цэргүүдийн судалгааны баримтууд дээр үндэслэн үүний жишээний загварыг хөгжүүлсэн [89]. Сурьеэгийн халдварт




Зураг 17. Миннесота болон Өмнөд Каролина дахь туберкулины сорилын үр дүнгийн тархалт насны булгээр. Зурагийг European Respiratory Society Journals-аас зөвшөөрөл авч хэвлэв [82].




Зураг 18. Туберкулины сорилын (5 ТН PPD-S) үр дүнгийн тархалт 5544 сурьеэтэй өвчтөнүүд дотор. Зурагийг American Thoracic Society/American Lung Association-ны зөвшөөрөлтэйгээр [76]-аас авч хэвлэв.

авсан байх магадлал нь сүрьеэгийн хавьтаттай байсан хүмүүсийнх хавьтатгүй хүмүүсийнхтэй харьцуулахад илүү өндөр их байв (зураг 21). Жишээ нь, сүрьеэгийн хавьтаттай байсан хүмүүсийн 70% -д гувдрүүний хэмжээ 10 мм байхад, сүрьеэгийн хавьтатгүй хүмүүсийн 10%-д ийм урвал илэрсэн байна. Энэ судалгаагаар сорилын шинжилгээний өвөрмөц шинж чанар ба нөхцөлийн тархалт бага их доогуур байгаа тохиолдолд зерэг дүн өгөх сорилын тоог таамаглах хэмжигдэхүүнээр хязгаарлаж болохыг тогтоосон. Хавьтаттай байсан хүмүүсл сорил тавьж, тодорхойлогдож болох халдварын тархалтыг нь хавьтатгүй хүмүүсийнхтэй харьцуулна. Энэ нь зерэг сорилын дунгийн таамаглалын хэмжигдэхүүнийг өсгөнө (халдвартлагдсан халдвартлагдаагүй хумуусийг зөв ялгаж салгасны дараа үүнийг тодорхойлох боломжтой юм).


Дэлхийн янз бүрийн нутаг дэвсгэрт сүрьеэгийн туберкулины сорилын мэдрэг байдлыг таамаглан тогтоох нь хүрээлэн буй орчны *mycobacteria*-ийн тархалтын онцлогогоос хамаараан боломжтүй юм, *mycobacteria*-ийн тархалт их хэлбэлзэлтгэйгээр илэрнэ хэрээс урвалыг (cross-reaction) бий болгоно.



Зураг 19. АНУ-ын тэнгэсийн шинэ цэргүүдийн дундах сурьеэ өвчний хавьтлтай (тасархай шугам) болон хавьтлгүй (цэгчилсэн шугам) цэргүүдийн туберкулины сорилын (5 TU PPD-S) үр дүнгийн түгэлт. Үргэлжлсэн бутзан шугам нь хоёр булгийн ялгааг харуулна. Зургийг American Thoracic Society/American Lung Association-ны зөвшөөрөлтэйгээр [76]-аас авч хэвлэв.




Зураг 20. Нэг дүүрэгт амьдарсан АНУ-ын тэнгэсийн цагаан арьстай шинэ цэргүүдийн дундах PPD-B туберкулины сорилын үр дунгийн тархалт. Зургийг American Thoracic Society/American Lung Association-ны зөвшөөрөлтэйгээр [76]-аас авч хэвлэв.




Зураг 21. Сорилын урвалын гүвдрүүний хэмжээнээс хамааран *M.tuberculosis*-ын халдварт авах боломж. [89]-ээс баримтыг авав.


Джибоути улсад, жишээ нь PPD туберкулинд үссэн хэрээс урвал бараг угүй байна (зураг 22). Тийм учир энэ тохиолдолд судалгааны алдаа маш бага байна. Тэгэхдээ 0мм-ээс дээш хэмжээтэй урвал нь M.tuberculosis-ын халдварт авсныг илтгэнэ. Үүний эсрэгээр Танзаний хийгдсэн судалгааны дун 10мм-ээс бага хэмжээний гувдруу нь сүрьеэгийн далд халдвартын илрэл болохыг тодорхойлсон [90]. Гэвч гэнэт Солонгос улсад 1975 онд завсрлын зураг гарч ирсэн [91]. 10-14 насны эрэгтэйчүүдийн дунд урвалын хэмжээ түүштэй нэмэгдсэнийг харж байна (зураг 23)[91]. 5мм 9мм-ийн урвалын хэсгүүдийн хоорондох ялгаа харьцангуй бага ч, 10мм болон түүнээс дээш урвалтайг нь халдвартлагдсан гэж үздэг нь буруу ангилал болно. Халдварт авсан хүнийг халдварт аваагүй хүнээс ялгах боломж нь туберкулины сорилд ихэвчлэн бага урвал өгдөг хүрээлэн буй орчны mycobacteria-ийн халдвартын тархалт болон өндөр урвал өгдөг M. tuberculosis-ын халдвартын тархалтын харьцаанаас хамаарна. Энэ харьцаа нь яваандaa өөрчлөгдөн халдвартлагдсан болон халдвартлагдаагүй ялан тогтоохыг хөнгөвчлөх буюу бүр хүндрэлтэй болгоно. Солонгос улсад 1965 болон 1995 онуудад хийсэн судалгаануудаас үүнийг харж болно (зураг 24)[92-94].



Зураг 22. 2 ТИ PPD RT23 туберкулины сорилын урвалын хэмжээний түгэлт харьцуулан үзүүлсэн байдал. Джибоути болон Танзани улсад хийсэн судалгаанууд. Омм-ийн урвалтай байсан хүнийг тодорхой харуулахыг зорив. Танзани улсад хийсэн судалгааны эх баримтыг [90]-ээс авав. Джибоути-ийн баримтыг ОУСҮӨТХ-оос Төвисц хэвлэхийг зелдгээр зөвшөөрөв.




Зураг 23. 1 TU PPD RT23 туберкулины сорилын урвалын хэмжээний түгэлт. Солонгос улс, 1975 он. Омм-ийн урвалтай байсан хүнийг тодорхой харуулахыг зорив. Эх баримтыг [91]-ээс авч хэвлэв.



Зураг 24. 1 TU PPD RT23 туберкулины сорилын урвалын хэмжээний тархац. Солонгос улс, 1965 болон 1995 онуудад хийсэн хоёр судалгааны дун. Омм-ийн урвалтай байсан хүнийг тодорхой харуулахыг зорив. Эх баримтыг [93,94]-ээс авав.

1965 онд *M.tuberculosis*-оор халдвартагдсан халдвартагдаагүйг шууд ялган харж байсан. Харин 1995 онд сүрьеэгийн *M.tuberculosis*-ын халдвартын тархалт мэдэгдэхүйц буурсан тохиолдолд, энэ ялгааг тогтоох хүндрэлтэй болсон, яагаад гэвэл их хэсгийг хамарсан саарал хүрээ гарч ирсэн.

Bacille Calmette-Guerin (BCG) вакцинжуулалт хийх явдал нь туберкулины мэдрэх чадварыг яңз бүрийн түвшинд нэмэгдүүлнэ [95]. BCG-тэй холбоотой хамгийн том туршилт Энэтхэг улсын Чинглепут хийгдсэн[96]. Энэ судалгааны үр дүнд вакцинжуулалтын дараа үүсэх туберкулинд мэдрэг чанар ямар байх талаар мэдээлэлтэй болсон. Зураг 25д 5 хүртлэх наасны хүүхдүүдэд вакцин тарьсны дараа 2,5 сар ба 4дэх жилд туберкулины хариу урвалын хэмжээ ямар байсныг харуулжээ. Вакцинжуулалтын дараа үүсэх урвалыг *M.tuberculosis*-ын халдвартын урвалаас ялгах боломжгүй байсан. Хэдэн жилийн дотор энэ муруй зүүн тийш хазайсан боловч, анхаарал татам олон хүүхдүүдэд хувь нь өндөр урвал үзүүлсэн хэвээр байсан. BCG вакцины туберкулины сорилын дунд нөлөөлөх нөлөөлөл нь, вакцин тариулснаас хойш өнгөрөх хугацаатай холбоотой нь тодорхой.




Зураг 25. BCG вакцин тарьсны дараа 2,5 сар ба 4дэх жилд туберкулины хариу урвалын хэмжээний тархац, Чинглепут, Энэтхэг улс; мөн вакцинжуулалтаас хойш 4-5 жилийн дараа, Пуэрто Рико. Зургийг Энэтхэгийн Эрүүл Мэндийн Судалгааны Консулын зөвшөөрөлтэй гээр [96]-аас авав, мөн Америкийн Нийгмийн Эрүүл Мэндийн Асошиацийн зөвшөөрөлтэйгээр [97]-оос авч хэвлэв.

Вакшин хийлгэснээс хойш 4-еес 5 жилийн дараа урвалын хэмжээ буурдагийг Пуэрто Рикод тодорхойлсон (зураг 25) [97]. Хүүхдүүдийн нас 1-18 -ын (18-ийг оруулаад) хооронд байсан. Чинглепутд BCG131 (франци омог) болон 1173Р (Копенгаген омог) хоёр хэрэглэгдэжээ, Пуэрто Рикод Бирхауж-Албани омог хэрэглэгджээ. Дээрхи судалгаануудын дунд үндэслэн вакшины дараах туберкулинд өгөх урвал нь зөвхөн вакцины омогоос биш [95], харин вакцинжуулсан нас, вакшин тарьснаас хойш өнгөрсөн хугацаанаас мөн хамаардгийг баталжээ [96].

Хүрээлэн буй орчны тусcobacteria-ийн хэрээс харилцан нөлөөлөх урвал байгаа тохиолдолд сүрьеэгийн тархалтыг тодорхойлох аргууд

Хүрээлэн буй орчны тусcobacteria-ийн харилцан нөлөөлөх урвал байгаа тохиолдолд сүрьеэгийн тархалтыг тодорхойлоход гарах бэрэхшээлүүдийг зураг 26д нэгтэн харуулсан байна [98]. Сонгон авсан бүлэгт шижлэгдсэн хүмүүсийн тодорхой хувь нь ямар ч үед алдаатай ангилагдсан байдаг. Бага узүүлэлт рүү зүүн тийш хазайх нь шинж тэмдэгтэй хүмүүсийн дундах хурамч серөг дуний харьцааг бууруулснаар мэдрэг чанар нь нэмэгддэг, харин өвөрмөц чанарыг нь шинж тэмдэгтүй хүмүүсийн дунд хурамч зэрэг дүнийн харьцааг өсгөснөөр бууруулдаг.



Зураг 26. Туберкулины сорилын хариу урвалын хэмжээний нийлмэл тархацын загвар. Нийлмэл тархацыг (бүтэн хистограм) гурван хэсгээс бүтэж байна: M.tuberculosis-ээр халдварт авсан хүмүүсийн тархац (бүтэн шугам), M.tuberculosis-ээс бусад тусcobacteria-ийн халдварт авсан хүмүүсийн тархац (цэгтасархайтай шугам mode нь 6мм—ээс 7мм хүртэл), хоёулангийн халдвартыг авсан хүмүүс (тасархайтай шугам Омм—ээс 2 мм хүртэл). Зургийн Churchill Livingstone-ийн зөвшөөрөлтэй [98]-аас авав.


Баруун тийш хазайх нь эсрэг үр дүнг өгнө. Сорилын шинжилгээний мэдрэг болон өвөрмөц чанар тодорхой цагт л зөвхөн, халдвартыг тархалтыг тодорхойлох боломжтой юм. Гэвч сорилын мэдрэг чанарыг хангалттай хэмжээгээр тодорхойлоход өвөрмөц чанар нь мөн л тодорхой бус үлддэг байна.

Халдвартай байгаа эсэхийг тодорхойлоход 10мм, 14мм эсвэл 18мм гэх мэтээр хязгаар хэмжээг тогтоох нь зарим үед л хэрэгтэй болохоос бусад ихэнхи үед хэрэгцээгүй байдаг.

Туберкулины сорилын шинжилгээний судалгааг 1957 онд Танзани улсад хийсэн, энэ улсын зүүн өмнөд хэсэгт өвөрмөц бус мэдрэг байдлын давтамж бусад хэсгүүдээсээ анхаарал татахуйц ялгаатай байсан [99]. Тэгэхдээ өвөрмөц бус урвалын хэмжээ нь 14мм-ээс ихгүй гэж таамагласан. Энэ таамаглалаас үндэслэн (хэрээс урвал багатай орон нутагт суурилж) мэдрэг чанарыг 82% гэж авсан, тэгэхлээр халдвартай авсан байсан хүмүүсийн 18%ийг нь орхигдуулсан байна. Тиймээс халдвартыг тооцоолон бодохдоо 14мм-ээс их урвал өгсөн хүмүүсийн тоог 0,82-т хувааж тодорхойлсон. Энэ аргыг хэрэглэн дээрхи дүгнэлтийг гаргахдаа тухайн хэсгийн өвөрмөц чанар 100% байсан гэдэгт үндэслэгдсэн, энэ Танзаний судалгаанаас өөр дүгнэлт хийсэн үүнтэй дүйцэхүйц судалгаа одоогоор байхгүй байна [90].

Туберкулины сорилын мэдрэг чанарыг тодорхойлох нь өвөрмөц чанарыг тодорхойлооос олон дахин хялбар юм. Яагаад гэвэл хүрээлэн буй орчны mycobacteria бага тархсан орон нутагт сурьеэгээр өвчилсөн [76,83] болон эрүүл хүмүүсийн туберкулинд өгөх урвалын хэмжээ хэвийн урвалтай ижил байсанд оршино (Джибуутийн судалгаа). Урвалын mode 16мм-ээс 19мм-ийн хооронд байсан [81]. Энэ нь цаашид тольны тусгал гэж нэрлэгддэг арга техникийг сонгож авахад хүргэсэн [100]. Энэ аргаар таамаглан тооцоолоход дээрхи хэмжээнээс их урвалтай хүмүүсийн тоо энэ хэмжээнээс бага урвалтай хүмүүсийн тоотой тэнцидэг гэсэн дүгнэлтэнд хүргэсэн. Mode-аас их урвал өгсөн тоог хоёр дахин авч үүн дээр энэ mode-нд хамрагдаж байгаа урвалыг тоог нэмж халдвартлагдсан хүмүүсийн тоог бодож гаргасан. Энэ хэмжээний мэдрэг чанар 100% гэсэн таамаглалыг дахин дэвшүүлсэн, энэ нь таамаглал 14 мм-эй харьцуулвал илүү зөв юм. Гэвч энэ аргатай холбоотой хэд хэдэн бэрэхшээлтэй асуудлууд байна. Нэгдүгээрт, их хэмжээний баримт гээгдсэн. Хоёрдугаарт, Танзани улсын жишээнээс харахад, mode-ийг тодорхойлох нь тэр бүр амар биш байна. Гэвч mode-ийн байрлалыг зөв тогтоох нь шийдвэрлэх чухал ач холбогдолтой, mode-ийн байрлал нь халдвартыг тархалтыг тооцоолоход маш мэдрэг байна [98].

Зарим тохиолдолд халдвартыг тархалтыг тодохойлох нь давшгүй боломжгүй байдаг байхад, өөр тохиолдолд ийм бэрхшээл бага байна. Дүн бүртгэлийн эмч нар нийлмэл тархалтыг хоёр заагтай тархалт болгон ялган үнэлэхэд холимог анализ нэргэй аргыг санал болгосон [101]. Туберкулины сорилын судалгаанд хавсруулсан холимог (applymixture) дүн шинжилгээ хийх ороллогуудыг урьд нь хийж байсан. Танзаний судалгааны жишээг зураг 27-д



Зураг 27. Танзаний туберкулины судалгаанаас гарсан холимог загвар [90]. Хистограмм нь гүвдрүүний хэмжээнүүдийн дүрслэл. Хүрээлэн буй орчны тусобактериаийн тархалт (хоосон дугуйтай шугам) болон M.tuberculosis-ын халдвар (харлуулсан дугуйтай шугам) –ын тархалтыг мэдэрсний үр дунд үүссэн сорилийн дүнгийн түгэлт.

харуулсан байна (Neuenschwander BE, Zwahlen M, Rieder HL-нарын хэвлэлд нийтлэгдэж байгаагүй баримт). Энэ арга дун бүртгэл болон тооцооны эрэлт хэрэгцээтэй байх ба, хүрээлэн буй орчны тусобактериа болон BCG вакцины туберкулины сорилын дунд нөлөөлөж байгаа чухал нөлөөллийг дүгнэхэд хүрэлцэхүйц мэдээллийг шаардах болно.


Халдварын тархалт

Нас хүйснээс хамаарсан халдварын тархалт.


Туберкулины сорилын шинжилгээгээр маш их мэдээллийг авч болох боловч, энэ их мэдээг нягтлан дүгнэж зөв тайлбарлах хэрэгтэй. Туберкулины сорилын таамаглах хэмжигдэхүүн халдварын тархалт өндөр тохиолдолд

хамаагүй ихээр сайжирдаг, үүнийг дүгнэх нь их ач холбогдолтой болох нь аж үйлдвэрлэл хөгжсөн орнуудад өмнө эрт хийгдэж байсан судалгаа болон өнөө үед ч халдварын тархалт өндөр байгаа орнуудад хийсэн судалгаанаас харагдсан.


Анхны насаар ангилан тодорхойлох халдварын тархалтын судалгааг Mantoux Парист эрүүл хүүхдүүдээс хуучны туберкулины арьсан дотор тарих техникийг ашиглан нэвтрүүлжээ [61]. Зураг 28-аас бил 5-аас дээш насын хүүхдийн тал хувь нь *M.tuberculosis*-ийн халдварыг авчихсан байсныг харж байна. Зураг 29- болон 30 дээр Дани [100] ба Энэтхэг [103] улсад хүйсээр ялгаж насын хамааралтай халдварын тархалтыг судалжээ. Эдгээр оронуудад хоёуланд нь хүүхэд насанда халдварын тархалт хүйсний ялгаа үгүй бараг ижил байж, насанда хүрсэн хүмүүсийн дотор эрэгтэйчүүдийн дундах халдварын тархалт эмэгтэйчүүдийнхээс илүү ихээр нэмэгдсэн нь ажиглагдаж байна. Мөн тухайн хоёр улсын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундах халдварын тархалтыг харьцуулахад Дани улсынх анхаарал татахуйц байхад, Энэтхэг улсын эрэгтэйчүүдийн дундах халдварын тархалт илүү өндөр байна. Халдварын тархалтанд эр, эмийн хүйсний харьцаа болон насын хамаарлыг харуулсан хамгийн сайн судалгааны жишээ бол дээрх 2 судалгаа юм (зураг 31) [102] [103].



Зураг 28. Хүүхдүүдийн насын хамаарсан сурьеэгийн халдварын тархалт, Парис, Франци улс. [61]-ээс эх баримтыг авч хэвлэв.



Зураг 29. Нас болон хүйснээс хамаарсан сүрьеэгийн халдвартын тархалт, Дани улс, 1950–1952. [102]-ээс эх баримтыг авч хэвлэв.



Зураг 30. Нас болон хүйснээс хамаарсан сүрьеэгийн халдвартын тархалт, Энэтхэг улс, 1961–1962. Эх баримтыг [103]-ээс ашиглав.


Наснаас хамаарах халдварын тархалт энэ зууны турш аж үйлдвэрлэл хөгжсөн орнуудад аажимдаа буурч ирсэн байна, үүнийг Швейцар улсын жишээн дээрээс харж болно (зураг 32) [104, 107]. 1920 оны байдлаар 20-иос дээш насны хумуусийн ихэнх нь M.tuberculosis-ийн халдварыг авсан байсан байна. 1978 он гэхэд 20 насныхан дунд халдварын тархалт 10%-иар буурсан байв. Үүний ижил Солонгос улсын хүн амын дунд 10 мм болон түүнээс дээш урвалтай хүний тоо 1965-1995 онуудад хурдаштай буурсан байна (зураг 33) [91, 93, 94, 108, 109].

Халдварын тархалт болон хүн амын нягтрал


Хот болон хөдөө орон нутгийн хүн амын нягтрал ялгаатай бөгөөд халдвар авах эгзэг нь өөр байна. Хотын хүн амын халдвар авах эгзэг нь хөдөө орон нутгийн хүн амынхаас ялгаатай байх нь гайхах зүйл биш юм. Хотын хүн амын дундах халдварын тархалт, хөдөө орон нутгийн хүн амын халдварын тархалгаас их байгаагийн жишээг Солонгос (зураг 34) [93] улсын жишээн дээр харж болно, мөн дээр дурьдсаны тод жишээ Занзибар улсад тодорхойлогддог (зураг 35) [110].

Сүрьеэ өвчиний халдвар болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлс


Халдварын тархалт нь зөвхөн нас хүйснээс хамаараад зогсохгүй мөн тухайн хүн нийгмийн ямар давхаргад амьдардгаас шалтгаална. Нийгэм эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөллийг судалсан судалгаанууд анх 20-р зууны эхэнд хийгджээ. Норвегийн Тронхейм, Германы Хейделберг болон Вьетнамын Хуе хотуудад хийгдсэн 3 судалгааг D'Arcy Hart нэгтгэн дүгнэжээ




Зураг 31. Дани болон Энэтхэг улс, насны хамааралтай сүрьеэгийн халдварын тархалт дахь эр эмийн хүйсний харьцаа.




Зураг 32. Швейцар улс, насны хамааралтай сүрьеэгийн халдвартын тархалт 1920–1993 онуудад [104,104–107]-аас эх баримтыг ашиглав.



Зураг 33. Насны хамааралтай сүрьеэгийн халдвартын тархалт, Солонгос улсад 1965–1995 онуудад [91,93,94,108,109]-аас эх баримтыг ашиглан хэвлэв.



Зураг 34. Солонгос улсын хот болон хөдөө орон нутагт дахь насны хамааралтай сүрьеэгийн халдвартын тархалт (туберкулины сорилын урвалын хэмжээ ≥ 10 мм), 1965. [93]-оос эх баримтыг ашиглав.




Зураг 35. Занзибар улсын хот болон хөдөө орон нутагт дахь насны хамааралтай сүрьеэгийн халдвартын тархалт (туберкулины сорилын урвалын зөвхөн ≥ 16 мм хэмжээтэйг нь сонгон авсан). 1961. [110]-оос эх баримтыг авч хэвлэв.

(зураг 36) [111]. Насны хамааралтай халдвартын тархалт нь чинээлгэй баян хүмүүс болон ядуучуудын дунд өөр байв. Энэ ялгаа нь их анхаарал татах ёстой, яагаад гэвэл дээрх хоёр ялгаа нь улс хоорондын ялгаанаас хамаагүй өндөр байв.


Кuemmerer ба Comstock нар АНУ-ын Вашингтоны оюутнуудын дунд халдвартын тархалтын судалгаа хийжээ. Судалгаандаа оюутнуудын эцэг эхийн боловсрол, ам бүл, амьдралын нэхцэл хэв маягийг нь судалжээ (зураг 37) [112]. Ам бүл олонтой гэр бүлд амьдрах нь туберкулины урвал өндөр гарахад чухал нэхцэл болж байна гэж дүгнэжээ.

Таамаглах халдварт судлал – халдварт авах эгзгийн загварчлал

Жил бурийн шинээр *M.tuberculosis*-ээр халдварт авах тохиолдлыг чухамдаа хэзээ ч тодорхойлж хэмжих боломжгүй юм. Хэмжиж тодорхойлохын тулд маш их олон тооны хүнд, богино хугацаанд давтан сорил тавих хэрэгтэй болно [113]. Мөн үүний эзрэгцээ сорил тавих техникээс үр дүн нь их шалтгаална. Тийм учраас, зөвхөн өгөгдсөн наасанд тодорхой тооны аргаар ойролцоогоор жилд хэдэн хүн халдварт авч болохыг (жилийн дундаж



Зураг 36. Гурван улс дах насны хамаарлтай сүрьеэгийн халдвярын тархалт. Судалгааг 1910-аас 1920 онуудад Хейделберг (Герман улс), Трондхейм (Норвеги улс) мөн Хуе (Вьетнам улс) хотуудад нийгэм эдийн засгийн байдалтай нь ялган гаргажээ. Эх баримтыг [111]-ээс British Medical Research Council-ийн зөвшөөрөлтэйгээр авав.



Зураг 37. Вашингтоны сюутнуудад оюутнуудын эцэг эхийн боловсрол, ам бул, амьдралын нэхцэлөөс шалтгаалан туберкулины сорилын урвал өндөр гарсан давтамж, АНУ. [112]-оос эх баримтыг ашиглав.

халдварын эгзэгийг) тодорхойлсноор тархалтыг дүгнэдэг байна. Жилийн дундаж халдварын эгзгийг тооцоолоход өрөнхийдөө хялбар юм.

Энэ тооцоо нь жилд дундажаар хэдэн хүн халдвар авахгүй үлдэх вэ гэдэгт үндэслэгдэнэ. Халдвар авах эгзэгийг халдварын тархалтаас яаж тооцоолох талаар товч 2-р хүснэгтэнд үзүүлсэн байна. Жишээ нь: Халдварын эгзэг жил бүр 10 хувь байдаг гэж үзвэл, үлдсэн 90%-д нь ноогдох хүүхдүүд амьдралынхаа нэгдэх жилд халдвар авахгүй байна. Тэгэхлээр 90%-ийн дараагийн 90% гэхээр, ө.х. 81% нь 2 дахь жилдээ халдвар авахгүй байх байна. Мөн 81%-ийн 90% гэхээр 72.9% нь төрснөөсөө хойш 3 дахь жилийн төгсгөлдөө халдвар авахгүй байх байна, г.м. Цаашил, халдварын эгзгийг халдварын тархалтаас тодорхойлоход мөрдөх зарчмуудын талаар дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Халдварын тархалтаас халдварын эгзгийг тодорхойлох

M.tuberculosis-ын халдварын тархалтыг үнэхээр зөв тодорхойлж дүгнэсэн гэдэг итгэл нь жилийн дундаж халдварын эгзгийг туберкулины сорилын судалгаагаар тогтоож шинжлэн дүгнэлт өгсөнд оршино. Жилийн халдварлалтын эгзэг нь тодорхой хуанлийн хугацаанд тодорхойлогдсон эрсдэл $b + x$, b нь когортоор төрсөн хуанлийн хугацааг илтгэнэ, x нь 0 болон а хоорондох тоог илтгэнэ, а нь $b+a$ когорт хуанлийн хугацааны настай тэншэнэ, энэ нь судалгаа эхэлсэн хугацаа юм. Энэ хугацааг яг тодорхой мэдэх боломжгүй юм, яагаад гэвэл хуанлийн хугацаанд тухайн эрсдэлийг дэс

дараатай цуврал судалгааны дүгнэлт дээр л үндэслэж гаргалаг учир [118, 119]. Халдварын эгзэг нь хуанлийн хугацааны туршид өөрчлөгдж болно. Хэрвээ зөвхөн нэг судалгааны мэдээлэл дээр үндэслэвэл х нь когорт эхэлсэн жил болон судалгаа өрнөсөн жилийн дундах зайд дөхөж очих болно [119, 120]:

$$R_{b+a/2} \approx 1 - (1-P_{b+a})^{1/a}$$

$R_{b+a/2}$ нь когорт төрсөн жил болон судалгааны жил хоорондох жилийн халдварталтын эгзэтгэй тэнцэх хуанлийн хугацааны дундах орон зайд юм.

P_{b+a} судалгааны хугацаанд тодорхойлсон халдварын тархалт, энэ тохиолдолд эгзэг болон тархалт хэсэгчилэн илэрхийлэгдсэн байна. Ингэхлээр 10.5 насын хүүхдүүдийн дундах халдварын тархалт судалгааны дундах орон зайд 10% гж тодорхойлогдсон бол (1997 оны 6-р сарын төгсгөл, өх. 1997.5) халдважилтийн эгзэг нь $R_{1992.25} \approx 1 - (1-0.1)^{1/10.5} = 0.010$ өөрөөр хэлбэл 1992 оны 3-р сарын төгсгөл нь ойролцоогоор хуанлийн хугацааны 1% болно.

Бие биенээсээ тусдаа хийгдсэн дараагийн хэдэн жилүүдийн судалгаа нь ч халдварталтын эрсдэлийг өөрчлөх зайлшгүй мэдээгээр хангаж чадахгүй юм. Хэрэв эхний судалгаа нь 1988 эхэлсэн бол, жишээ нь жилийн дундаж

Хүснэгт 2. Жилийн дундаж халдварын эгзэгийг тодорхойлох

Тэмдэглэл:

b	=	когорт төрөлтийн хуанлийн жил
a	=	хуанлийгаар судалгааны үеийн когорт нас
P_{a+b}	=	когорт судалгааны үеийн халдварын тархалт
R	=	хуанлийн хугацаа b болон хуанлийн хугацаа $b+a$ хоорондох жилийн дундаж халдварын эгзэг

Бүгд тооцоонууд халвар авахгүй үлдэх боломж дээр үндэслэгдэх ёстой!

Төрсний дараа:	$1-P_b$	= 1
$Hac = 1:$	$1-P_{b+1}$	= $1 - (1-R)_1$
$Hac = 2:$	$1-P_{b+2}$	= $1 - (1-R)_1 (1-R)_2$
...		
$Hac = a:$	$1-P_{b+a}$	= $1 - (1-R)_1 (1-R)_2 \dots (1-R)_a$
	$1-P_{b+a}$	= $(1-R)^a$
	$(1-P_{b+a})^{1/a}$	= $(1 - R)$
	R	= $1 - (1-P_{b+a})^{1/a}$

халдварын эгзэг нь 1% гэж дүгнэгдсэн мэдээгээр хангагдсан байна, (ойролцоогоор хуанлийн хугацаа нь 1983), 2-р судалгаа 1997 онд хийгдэхэд халдварын эгзэг нь хуанлийн хугацаанд өөрчлөгдөөгүй байх албагүй юм.


Энэ нь халдварын эрдэл 2 дахь когорт судалгаа эхэлсэн эхний жилүүдэл буурч байгаа тохиолдолд магадгүй сайн юм, жишээ нь дээрх үзэгдэл халдварт хэлбэрийн тохиолдлуудыг илрүүлэх эмчлэх чадмаг үр дүнтэй хетөлбер нэвтрүүлсэнтэй холбоотой гарч болох юм. Гэвч цаашид халдвартай хэлбэрийн тохиолдлууд ихэсч тоо нь нэмэгдэж болох юм. Яагаад гэвэл сүрьеэгийн халдвар авсан ХДХВ халдвартай хүмүүсийн тархалт нэмэгдэж байна. Эдгээр хүмүүс нь халдвар тараагчдын тоог нэмэгдүүлснээр нийт хүн амын дундах халдвар авах эгзэг өснө. Эхний судалгааны явцад илэрсэн бууралтыг дараагийн судалгааны өсөлт дагах учир энэ 2 судалгаанд халдварын тархалт нь ойролцоо хэмжигдэхүүн гарах магадлалтай. Зөвхөн дэс дараатай дүгнэлт нь үнэн зөв чигийг гаргахад шийдвэрлэх нөлөөтэй. Туберкулины судалгаа нь хүн амын дундах халдварын эгзгийн өөрчлөлтийг богино хугацаанд тодорхойлох чадваргүй юм, тэгэхдээ судалгаа хоорондох завсар нь неец боломжкоо хэмнэх зорилготойгоос шалтгаалан аль болох их байх хэрэгтэй.

Цаг хугацаа болон халдварын эгзэгийн чиг хандлага


Дээр дурьласан халдварын эгзэг нь тодорхой хугацаан дахь халдварын эгзэг юм (таслах saatuuлах параметр). Энэ нь хугацааны явцад өөрчлөгддэг (намуу параметр) хэмжигдэхүүнээс ач холбогдлын хувьд бага юм. Өөрчлөгддэг хэмжигдэхүүний тусламжтайгаар эпидем эхэлж байгаа эсэхийг харж болно, жишээ нь Европд үзэгдсэн өөрчлөлтөнд дүгнэлт хийснээс харж болно. Европ дахь халдварын эгзэгийн хандлагыг анх Styblo, Швейцарь болон Сүрьеэгийн Тандалт Судалгааны Холбооны судлаачид хамтран дүгнэж тооцоолжээ [118, 119, 121].

Сүрьеэ өвчний эпидемийн хэв маягийг тодорхойлоход хуанлийн халдварын эгзэгийн өөрчлөлтийг анхааралдаа авдаггүй байсныг Стибло тэмдэглэжээ. Эхний халдварын эгзэг нь өндөр байсан ч, дараа дараагийн когорт бууралтанда хүргэхийн тулд их хүч хөрөнгө шаардагдах болно. Когорт бууралт үр дүн гэж юуг хэлэх вэ гэвэл - өгөгдсөн хуанлийн жилд төрсөн бүлэг хүмүүс амьдралынхаа туршид хамгийн бага халдвар авах эгзэгтэй байж, харин үүний зэрэгцээ эртний когорт төрөлттэй хөгшчүүл нас барж байх болно (эртний когорт төрөлттэй хүмүүс нь халдварын тархалт өндөр үед амьдарч халдвар авсан байдал). Жил бурийн дундаж бууралт 5% байвал, халдвар авах эгзэг 10 жилийн төгсгөлд эхний хэмжээнээс 60% хүртэл буурах болно, ингэхэлээр шинээр төрөх үеийн хүмүүс халдвар авах эгзэг бага байна. Өөр үгээр хэлбэл үр дүн нь харьцуулж болохуйц байх ёстой бөгөөд хэрэв халдварын эгзэг нь ихсэх хандлагатай бол өөр чиг баримжааг сонгох хэрэгтэй.

Нидерланд улсын жишээн дээр, Стибло Нидерландын мэдээ мэдээллийг ашиглаж урьд үеийн халдварын когорт онцлогт тархалтыг



Зураг 38. Зарим Европын улс орнууд дах жилийн халдвартын эгзгийн чиг хандлага.[107,118,121-125]-аас эх баримтыг ашиглав.




Зураг 39. Дэлхийн янз бүрийн бус улс орнууд дах жилийн халдвартын эгзэг саяахны тооцоогоор.ДЭМБ-ын зөвшөөрөлтэйгөөр [120]-оос авч хэвлэв.


тооцоолсны үнлсэн дээр ирээдүйн халдвартын тархалтыг тооцоолох боломжтой болжээ [122]. Үүгээрээ Нидерланд улсын сурьеэгийн тархалтанд нэг их өөрчлөлт гарагхгүй болохыг илрүүлжээ. Халдвартын эгзэг нь буурач эхэлбэл халдвартын тархалтанд гарах өөрчлөлтүүд хурдан эхэлгийг харуулж байна [122]. Гэвч энэ нь маш удаан байх болно.

Энэ зуны эхэн үед халдвартын эгзэг нь их өндөр байсан, тэгэхлээр ямар нэгэн хүн насанд хүртлээ халдварт авахгүй байна гэдэг нь үнэмшилгүй юм. Нидерланд улсад халдвартын эгзэг нь 10% болон түүнээс өндөр байсан нь, ихэнх Европын орнуудын түвшингэй ижил байв (зураг 38) [107, 118, 121-125].


Мурийны налуу нь бух орнуудад параллель байна. Мөн жилийн дундаж бууралт нь 10-12%-тай байна, 15-20 жилийн дараах хүртэл хугацаанд тухайн орнууд дахь ижил түвшин нь орон бүрт харилсан адилгүй өөрчлөгдөх нь,



Зураг 40. ДЭМБ-ын Африкийн бүсийн жилийн халдвартын эгзэгийн чиг хандлага. Тод хэр тэмдэг болон шугам нь нийт хүн амд буюу нийт хүн амынхаа ихэнх хэсгийг хамруулан тооцоолсон эгзэгийн илэрхийлэл, тод тэмдэг болон шугам нь нийт хүн амын тодорхой нэг нэгж хэсэгт тооцоолсон эгзэгийн илэрхийлэл, шулуун шугам нь ижил хүн амд ойрхон хийсэн судалгаануудыг холбоно, тасархай шугам нь ижил хүн амд ойролцоо хийгдсэн судалгаануудыг холбосон. ДЭМБ-ийн зөвшөөрөлтэйгээр [120]-аас эх баримтыг авч хэвлэв.



Зураг 41. ДЭМБ-ын Газрын Дундад Тэнгисийн бүсийн жилийн халдвартын эзээгийн чиг хандлага. Тод хар тэмдэг болон шугам нь нийт хүн амд буюу нийт хүн амынхаа ихэнх хэсгийг хамруулан тооцоолсон эзээгийн илэрхийлэл, тод тэмдэг болон шугам нь нийт хүн амын тодорхой нэг нэгж хэсэгт тооцоолсон эзээгийн илэрхийлэл, шулуун шугам нь ижил хүн амд ойрхон хийсэн судалгаануудыг холбоно. Тасархай шугам нь ижил хүн амд ойролцоо хийгдсэн судалгаануудыг холбосон. ДЭМБ-ийн зөвшөөрөлтэйгээр [120]-оос эх баримтыг авч хэвлэв.



Зураг 42. ДЭМБ-ын Зүүн Өмнөд Азийн бүсийн жилийн халдвартын эзээгийн чиг хандлага. Тод хар тэмдэг болон шугам нь нийт хүн амд буюу нийт хүн амынхаа ихэнх хэсгийг хамруулан тооцоолсон эзээгийн илэрхийлэл. Тод тэмдэг болон шугам нь нийт хүн амын тодорхой нэг нэгж хэсэгт тооцоолсон эзээгийн илэрхийлэл. Шулуун шугам нь ижил хүн амд ойрхон хийсэн судалгаануудыг холбоно. Тасархай шугам нь ижил хүн амд ойролцоо хийгдсэн судалгаануудыг холбосон. ДЭМБ-ийн зөвшөөрөлтэйгээр [120]-оос эх баримтыг авч хэвлэв.

бууралтын хувьтай харьцуулахад ач холбогдол багатай юм. Жишээ нь, Нидерландад жилийн халдвартын эгзэг 1910 онд 100-д 10 тохиолдол байснаа, 1990 онд 100.000 хүн амд 10-аас бага тохиолдол байх болжээ.

Cauthen болон судлаачид халдвартын эгзэгийн хандлагыг зарим буурай хөгжилтэй орнуудад судалжээ. Энэ судалгаагаараа халдвартын эгзэг бус нутаг, зарим улс орнуудын хооронд маш их ялгаатай байгааг тогтоожээ (зураг 39) [120].


Дээрх судалгааны жишээг дүгнэлтийн хамт зураг 40д ДЭМБ-ын Африкийн бус, зураг 41д ДЭМБ-ын Газрын Дундад Тэнгисийн бус, зурагт 42д ДЭМБ-ын Зүүн Өмнөд Азийн бүсийн орнуудыг харуулжээ. ДЭМБ-ын Африкийн бүсийн орнуудад жилийн бууралт нь 5%-иас бага байв, энэ тоог авах боломжтой л орнуудаас цуглуулжээ. Газар Дундад Тэнгисийн бүсийн орнуудад жилийн бууралт нь 5-10%-ийн дунд байв, Зүүн Өмнөд Азийн бүсийн жилийн бууралтыг нягтлах боломжгүй байсан бөгөөд жилийн бууралт нь 5%-иас бага байх хандлагатай байв.

Үүнээс харахад дэлхийн олон бус нутгуудад жилийн халдвартын эгзэг нь маш их ялгаатай юм. Одооны байдлаар, энэ зууны эхэн үед Европ тивд байсан шиг өндөр эгзэгтэй улс орон байхгүй байна. Гэвч халдвартай авах эгзэгийн бууралт зарим оронд маш бага удаан байгаа нь цаашид ойрын ирээдүйд халдвартын эгзэг буурах нь их бага байхыг илтгэж байна. Цаашилбал, халдвартай хэлбэрийн тохиолдлуудын өсөлт олон орнуудад ажиглагдаж байгаа нь ялангуяа Сахарын Африкал халдвартай авах эгзэг болон түүний цаг хугацааны явцад өөрчлөгдхөн нь халдвартын тархалтанд нөлөөлөх болно, халдвартын эгзэгийн бууралтын хурд нь цаашидын дэлхийн янз бүрийн бүсийн сурьеэгийн өвчлөлийн чиг хандлагад ач холбогдол бүхий нөлөөтэй. Халдвартын эгзэгийг бууруулахын тулд одооныхоос илүү эрчимтэй шийдвэртэй арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.[126]


Тоо баримтыг түшиглэн нааснаас хамааралтай халдвартын тархалтаас халдвартын эгзэгийг урьдчилсан тооцоолох

Зарим судалгааны үр дүнд нааснаас хамааралтай халдвартын тархалтыг тэр бүр тодорхойлох боломжгүй байдаг. Гэвч үүнийг мэдэх нь маш чухал юм. Үүнийг тодорхойжих мэдснээр бид тухайн орны хүн амын аль хэсэг нь илүү ихээр халдвартлагдаж байгааг мэдэх болно (Gerard ten Dam-ын баримтыг, 1990, ДЭМБ, Mario C Ravellingion-ны тусламжтайгаар авав).

Cauthen болон бусад судлаачдын судалгааны үр дүнг ашиглан ten Dam дэлхийн янз бүрийн орон нутгийн нааснаас хамраалт халдвартын тархалтыг буцаж-тооцоолж гаргажээ. Жишээ нь: Баруун Европд одоо болтол 60-аас дээш насынхан халдвартлагдснаараа үлдсэн байна (зураг 43). Энэ нь эдгээр хүмүүсийн когортын төрсөн хугацаа нь халдвартын эгзэг их өндөр байх үед тохирч байгаатай холбоотой. Мөн эдгээр хүмүүс нь халдвартай авалгүй байх боломжгүй байхаар олон наасалсан байна, өөрөөр хэлбэл халдвартай авах эрсдэл ихтэй байжээ. Харин шинэ залуу үеийнхэн сурьеэгийн халдвартай авах боломж бараг угүй байна, тэдний халдвартай авах эгзэг маш өчүүхэн юм. Дээрх хандлага хадгалагдвал зураг 43т



Зураг 43. Баруун Европ дахь насны хамааралтай сүрьеэгийн халдвартыг тооцоолон гаргасан тархалт, 1990. Баримтыг хэвлэхийг ten Dam HG элдэгээр зөвшөөрөв, 1990.




Зураг 44. Сахарын Африк дахь насны хамааралтай сүрьеэгийн халдвартыг тооцоолон гаргасан тархалт, 1990. Баримтыг хэвлэхийг ten Dam HG, 1990.

байгаа харлуулсан хэсэг хэлбэрэлтгүй доод шугам, баруун хэсэг рүү шилжих болно.

Африкийн Сахард байдал тэр чигээрээ эсрэг байна (зураг 44). Нэгд, хүн амын насын байдлыг авч үзвэл залуу бага насыхан ихэнх хувийг эзэлж байна, хүн амын бараг 50% нь 15 нааснаас бага насыхан байна. 15-49 насыхны тал нь буюу талаас нь их хувь сүрьеэгийн савханшарын халдварт авсан байна. Халдвартын бууралтын хувь удан байгаа болон зарим орон дахь халдвартын тархалт ёсч байгаа тул, ирээдүйн арваад жилүүдэд энэ дур зураг бүхэлдээ өөрчлөгднө гэж хэлэх боломжгүй юм.

Зүүн Өмнөд Ази дахь хүн амын дундах насын бүтэц Африкийн Сахарынхтай төстэй, тэгэхдээ бага насын хүүхлийн тоо арай бага байна (зураг 45). Энд 15-49 насыхны халдварталтын түвшин Сахарынхаас илүү өндөр байна. Энэ зургийг өөрчлөх ямар нэгэн хүчин зүйл нь цаашлын чиг хандлагыг тодорхойлох болно.

Эдгээр судалгаануудын дунд нь ХДХВ-ын халдвартын гүйцэтгэсэн үүргийг M.tuberculosis-ын тархалтын динамикт тусгаагүй байна. ХДХВ-ын халдвартын шинэ тохиолдол тархалт нэмэгдсэнтэй холбоотойгоор зарим орнуудад сүрьеэгийн халдвартын тархалт магадгүй нэмэгдэх болно. Энэ нь аюултай



Зураг 45. Зүүн Өмнөд Ази (Австрали, Шинэ Зенланди улсуудаас гадна) дахь насын хамааралт сүрьеэгийн халдвартын тооцоолон гаргасан тархалт, 1990. Эх баримтыг ten Dam HG, 1990.

орчныг үүсгэнэ. Сурьеэгийн халдварын тархалт их байх тусам сурьеэгийн халдвартай хэлбэрүүдээр өвдөх хүний тоо нэмэгдэх бөгөөд энэ нь халдварын тархалт улам нэмэгдэхэд нөлөөлнө. Сурьеэгийн халдварлалт их байх нь ХДХВ халдвартай хавсарч байвал цаашид байдал илүү муудах хандлагатай болно.

Халдварын эзгээс халдварын тархалтыг тодорхойлох элгээр завгарчилсан тооцоо үнэлгээ нь үүсгэгч шалтгаантай нь холбогдож тайлбарлагдах ёстой. Үүний талаар Sutherland [12] болон Nagelkerke [127] нар жишээн дээр үзүүлж тайлбарласан. Ганц л насын булгээс судалгаа хийж тогтоосон халдварын эзэг нь зөвхөн тухайн насын булгийн дундах халдварын тархалтыг илтгэнэ. Тийм учраас ганц л насын булэгт тодорхойлож тогтоосон халдварын эзэг нь алдаатай байдаг.

Дэлхийн нийт хүн амын гуравны нэг нь *M.tuberculosis*-ын халдвар авсан байгааг тогтоосон. Тэгэхдээ халдвар нь дэлхийн өндөг орон бурт ижил биш бөгөөд, насаар судалж дүгнэлт хийсэн судалгаануудын ач холбогдол маш их юм. Аж үйлдвэржсэн орнуудад сурьеэгийн халдвар ихэвчлэн настайчуудын дунд хадгалагдаж байлаг. Харин Латин Америк, Зүүн Өмнөд Ази болон Африкийн Сахарын орнуудад залуу хөдөлмөрийн насын хүмүүсийн дунд сурьеэгийн халдвар ихээр байна. Аж үйлдвэржсэн орнуудад сурьеэгийн халдварын тархалт хурдтай буурч байгаа тул сурьеэгийн халдварын асуудал нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалд тооцогдохгүй байх. Дэлхийн зарим оронд халдварын тархалт насандаа хүрсэн залуусын дунд өндөр байгаа нь ойрын ирээдүйд халдварын тархалт буурахгүй байх хандлагатай байна.


Халдвартай тохиолдлууд болон халдварын эзэг

Нийгэм хүн амын дотор байгаа халдварын эх уурхайн тооноос сурьеэгийн савханцарын халдварын тархалт хамаарах нь илт ойлгомжтой юм. Эмзэг бүлэг хүн амд, тодорхой хуанлийн хугацаанд халдвартай тохиолдлоос халдвар тархах тоо хэмжээ нь, тухайн хугацаан дахь нийгэм хүн ам доторх халдвар авах эзгийг тодорхойлно. Styblo-гийн тооцоолсноор химийн эмчилгээ нэвтрэхээс өмнөх үед нэг халдварын эх уурхай 2 жилийн дотор дундажаар 20 хүнийг халдварлуулдаг байжээ. Тэгээд энэ эх уурхай өөрөө аяндаа элгэрэх буюу халдваргүй болдог эсвэл нас бардаг байсан байна [122]. Цаашидын тавиланг таамаглавал амьдралын түршдаа халдвартай хэлбэрийн сурьеэз халдвартайгаараа байх нь 5% учир 2 халдвартай тохиолдол 1 шинэ тохиолдлыг жил бүр үүсгэх нь байна. Энэ шинэ тохиолдол цаашид жил бүр 10 хүнд халдвар тараах боломжтой. Тэгэхлээр халдвартай хэлбэрийн сурьеэтэй 100 өвчтөн 100 000 хүн амтай нийгэмд 1 жилд 1000 хүнийг халдварлуулах буюу нийт хүн амын 1% нь шинээр сурьеэгийн халдвар авна. Дээрх загвараас харахад тархалтын тал хувь нь шинэ тохиолдол илэрнэ. Дундажаар 50 шинэ халдвартай тохиолдолд 1%-ийн халдварын эзэг тохирч байна [128].


Гэхдээ заавал энэ загварын дагуу байх ёсгүй тул сурьеэгийн шинэ тохиолдлын тоог одооны халдварын эзгийн мэдлэгээс тооцоолон гаргах хэрэгтэй. Халдварын эзэг нь оношлогдоогүй, эмчлэгдээгүй, халдвартай

сурьеэтэй хүний тоо, халдвартай байх хугацааг илүү холбож өгдөг бөгөөд ингэснээрээ нийгэмд орших халдвартай хэлбэрийн сурьеэтэй хүний хүн хугацааг тогтооно. Халдвартай хэлбэрийн хүн хугацаа янз бүр байж болно, энэ хугацаа нь шинэ халдвартай тохиолдолтой холбоотой, тохиолдол бүр нийт тархалтанд тусгалаа олох болно. Хэрэв үр дунттай тодорхой үйл ажиллагаа явуулж арга хэмжээ яяралтай нэвтрүүлбэл, халдвартай байх хугацаа багасч, халварын тархалт буурах болно, ингэснээр тархалт болон шинэ тохиолдлын харьцаа холбоо алдагдана.

Үүнийг зураг 46 болон зураг 47-д тайлбарлан үзүүлэв. Эхний жишээн дээр тархалт (24 тохиолдол) шинэ тохиолдлооскоо (12 тохиолдол) 2 дахин их байна, мөн халварын хүн хугацаа буюу тархалтын хугацаа 1 жилд 288 хүн, сард 3 хүн байна. 2-р жишээн дээр, тохиолдол бурийн дундаж хугацаа нь зөвхөн 6 сар ба тархалтын хугацаа нь 1 жилд 72 хүн, сард 3 байна. Хэрвээ дээрх жишээнүүдэд халдвартай хэлбэрийн сурьеэ байсан гэж үзвэл, эхний тохиолдолд ямар нэгэн үйл ажиллагааг явуулаагүй байна, тэгэхэд 2 дахь тохиолдлын үед хөнгөнгийн оролцоо явагдсан тул халварын хугацааг бууруулсан байна. Тэгэхдээ энэ 2 жишээний шинэ тохиолдалуудын тоо нь ижил



Зураг 46. Сонгосон цаг хугацааны тархалт, энэ хугацааны мөчлөг болон шинэ тохиолдлын холбоог харуулсан схем. Энэ зурагт тархалтыг шинэ тохиолдлын тоог хоёр дахин ихэсгэсэнтэй тэнцүүгээр дүрсэлсэн байна. Налуу шулуун шугам шинэ тохиолдол ба түүний халдвэр тараах хугацааг илтгэнэ. Босоо шулуун шугам нь хуанлийн жилийн эхлэл ба төгсгөлийг илтгэнэ. Цэгчилсэн шулуун шугам нь судалгааны үед санамсаргүй сонгосон цаг хугацааны тархалт болох 3-р сарын 15-ны тархалтыг илтгэнэ.




Зураг 47. Тодорхой цаг хугацааны тархалт, энэ хугацааны мөчлөг болон шинэ тохиолдлын холбоог харуулсан схем. Энэ зурагт тархалтыг шинэ тохиолдлын тооны талтай тэнцүүгээр дурсэлсэн байна. Налуу шулуун шугам шинэ тохиолдол ба түүний хэлдвэр тараах хугацааг илтгэнэ. Босоо шулуун шугам нь хуанлийн жилийн эхлэл ба төгсгелийг илтгэнэ. Цэгчилсэн шулуун шугам нь судалгааны үед санамсаргүй сонгосон цаг хугацааны тархалт болох З-р сарын 15-ны тархалтыг илтгэнэ.

боловч халдвартай хэлбэрийн хугацаа нь үйл ажиллагаа явуулсанд нь үйл ажиллагаа явуулаагүйтэй нь харьцуулахад 1/4-тэй тэнцэхүйц байна. Тийм учраас ижил шинэ тохиолдлын тоотой ч 2-р жишигийн үед нийгэмд тараах халдвэр 1-р жишигийн харьцуулахад хамаагүй бага байна. Халдвартай хэлбэр болон халдварын эгзийн холбоо нь нэн түрүүнд шинэ халдвартай хэлбэрийн тохиолдлын тооноосоо илүү халдвартай хэлбэрийн байх хугацаанаас шалтгаална.

Дээрх загвар бол маш хялбарчилсан загвар юм. Халдвэр тараах хугацааг тогтмол тэмдэглэх хэрэгтэй боловч үүнийг харахад халдвэр тараалт тогтмол байдаг гэсэн сэтгэгдэл төрөм байна. Үүнийг яг шинэ сурьеэгийн өвчлөл тохиолдол дээр тогтоох боломжгүй юм, яагаад гэвэл халдвэр тараалт цаг ургэлж нэмэгдэж (зураг 48)[129], эсвэл савханцар ялгаруулалт тогтмол биш хоорондоо завсар зйтай байдагт оршино.

Сурьеэгийн тохиолдлыг хянах, эмчилгээ үйлчилгээг зохион байгуулах үйл ажиллагааг хангалтгүй явуулдаг улс оронд халдвартай хэлбэрийн



Зураг 48. Голчлон цэрний түрхэц зэрэг байсан ушигны сурьеэстэй ёвчнүүдэд сурьеэз ёвчний шинж тэмдэг анх илэрсний дараагаар цэрний түрхэц зэрэг байсан хувь, Швед, 1910–1911 болон 1934 он. [129]–ээс баримтлыг авав.

сүрьеэгийн тохиолдол, халдвартарааж эхлэнсээс хойш дундажаар 2 жилийн дараа нь оношлогдох боломжтой байна[130].

Цаашилбал, M.tuberculosis-ын халдвартай авах эзгээг нь нийт хүн амын дунд ялгаатай байна. Жишээ нь, ХДХВ-ын халдвартай авсан хүмүүс ихээр нэмэгдэж байгаа нь дархалын тогтолцоо сүлттай хүмүүсийн булэг ёсөж байна гэсэн уг юм. Ингэхлээр тархвар судлалын тэнцивр нь эзэн бие болон нянгийн хооронд ажиглагдана. Сурьеэгийн халдвартай хэлбэрээр ёвчилсэн хүмүүс нь сурьеэгийн халдвартай тарааж, ХДХВ-ын халдвартай авчихсан булэг амын дунд нэг буюу түүнээс дээш тоогоор сурьеэгийн халдвартай авсан хүний тоог нэмэгдүүлэх болно. Үүний эсрэгээр халдвартай тараах нөхчлийг цаг тухайд нь таслан зогсоодог улс оронд нэг халдвартай хэлбэрийн халдвартай тараах тоог буурах болно. Ингэхлээр жилийн халдварталтын эзгийг 1% болгоход, халдвартай тараах хүн хугацааг бууруулж, маш олон тооны шинэ тохиолдолыг цаг алдалгүй оношлож эмчилсэн байх шаардлагатай болно. Үүний жишээг ХДХВ-ын халдвартай их болохоос өмнөх уед АНУ-ын жишээн дээр ажиглаж болох байв. Жилийн халдвартай эзгийг 1% болгоход 100 000 хүн амд 400-аас их шинэ тохиолдол бүртгэгдэх болно [131].

БҮЛЭГ 3

СҮРЬЕЭ ӨВЧИН


Үүсгэгчийн холбогдлийг судлах тархвар судлал: халдварт өвчин болж даамжрахад нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлс

Сүрьеэ өвчинеөр өвчлөхөд нөлөөлөх гол эрсдэлт хүчин зүйл бол сүрьеэгийн савханцарын халдвартыг авах явдал юм. Сүрьеэгийн савханцар зайлшгүй байх ёстой боловч, сүрьеэ өвчинеөр өвчлөхөд хангалттай биш юм. Халдварт авах эгзэг нь халдвартын эх уурхай хүрээлэн буй орчныг хэр бохирдуулсан болон сүрьеэ өвчин үүсэх эгзэг нь халдварт авсны дараа дотоод хүчин зүйлс буюу эсийн дархлалын тогтолцооны хамгаалах чадвараас хамаарна.

Ихэнхи тохиолдолд сүрьеэгийн савханцар биед нэвтрэсний дараагаар тухайн хүн сүрьеэ өвчинеөр өвчлөх эсэхийг тодорхойлох боломжгүй юм. Нөгөө талаас маш олон хүчин зүйлийн улмаас *M. tuberculosis*-ын халдварт өвчин болж даамжирдагийг тогтоосон [132]. Эдгээр хүчин зүйлүүдийг нэгтгэн зураг 49-д үзүүлсэн байна. Эдгээрийн зарим нь хүчтэй нөлөөлөлтэй эрсдэлт хүчин зүйлийн тоонд орлог ба нийт хүн ам дотор ихээр тархсан байдаг. Зарим эрсдэлт хүчин зүйлүүд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг боловч тэдгээр нь маш ховор тохиолддог тул нийгмийн эрүүл мэндэд зөвхөн бага зэрэгийн ач холбогдолтой юм. Эдгээр хүчин зүйлсийн нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл нь нийгэмд үзүүлж байгаа шууд нөлөө болон эрсдэлт хүчин зүйлийн тархалтаас нь хамаарч тодорхойлогдоно.

Халдварт авснаас хойших хугацаа


Халдварт нь өвчин болж хөгжих нь хугацааны хамааралтай болохыг тогтоосон [133]. Анхдагч сүрьеэ (зураг 50) болон сүрьеэгийн менингит (зураг 51) үүсэх хугацааны-хамаарал их ялгаатай. Урьдчилан сэргийлэх хими эмчилгээний судалгааны үр дунд ойрын хавьталаас сүрьеэгээр өвчлөх эгзгийн талаар мэдээ баримтыг олж авсан. Энэ эгзэг нь эхний хэдэн жил их өндөр байх бөгөөд хурдан буурч бага тувшинд хүрэх боловч насан туршил нь хадгалагдах болно (зураг 52) [134].



Зураг 49. Сүрьеэгийн халдвэр нь сүрьеэ өвчин болоход нелөөлдөг эрсдэлт хүчин зүйлс. [134]-аас болон бусад эх үүсвэрээс баримтыг авав. Жишүү дервэн өнцөгт нь нелөөлөгч хүчин зүйлсийн жагсаалт (7-оос бага жилийн өмнө халдвэр авсныг харуулна), харлуулсан дугуй нь харьцангуй эрсдэл(нийт хүн амд үндэслэсэн судалгаанд сууринла), хоосон дугуй нь харьцангуй хувь(тохиолдол-хяналтын судалгаанд сууринла), мөн цэгчилсэн шугам нь ялгаатай судалгаануудын хэлбэлзлийг илтгэнэ.




Зураг 50. Халдвэрлын дараагаар анхдагч сүрьеэ өвчин үүсэн хөгжих. Churchill Livingstone-ийн зөвшөөрөлтэйгээр [133]-аас ашиглав.



Зураг 51. Халдвартын дараагаар сүрьеэгийн менингит үүсэн хөгжих. Churchill Livingstone-ийн зөвшөөрөлтөйгөөр [133]-аас ашиглав.

BCG вакцины судалгаан дах туберкулин-ээрэг плацебо хэсгээс авсан мэдээ баримтаар, дээрхийн адил сүрьеэ өвчнөөр өвчлөх эзэг нь халдвартын дараах эхний хэдэн жил хамгийн өндөр байж байгаад, дараан огцом буурч байжээ (зураг 52) [135]. 20 жил үргэлжилсэн British Medical Research Council-ийн BCG вакцины судалгааны явцад хянасан 140 тохиолдлын 64 (45.7%)-д эхний 2.5 жилд, 95 (67.9%)-д нь эхний 5 жилийн дотор өвчин үсчээ.



Зураг 52. Плацебо хэрэглэж байсан ойрын хавьтлын шинэ тохиолдлын тоог сүрьеэ өвчний эсрэг изониазидаар урьдчилан сэргийлэх хими эмчилгээ [134] хийлгэж байсан ойрын хавьтлын шинэ тохиолдлын тоотой харьцуулсан харьцаа, мөн Их Британий эмнэлгийн судалгаа эхэлснээс хойших хугацаанд вакцинжуулагдаагүй, туберкулины сорил өндөр урвалтай хүмүүсээс сүрьеэ өвчнөөр өвчилсөн хүмүүсийн тоо [135].

Гэвч энэ судалгаанд хамрагдсан хүмүүсийн яг хэзээ халдварт авсан нь тодорхой бус байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Сурьеэз өвчний шинэ тохиолдлын талаархи бүрэн төгс мэдээ баримтын чанар нь судалгааны төрөл болон судалгаа хийсэн хугацааны ялгаанаас хамаарч олон янз байна. Элгээр ялгаанууд нь анхдагч сурьеэз өвчний тодорхойлолтуудын ялгаа, халдварт авах хугацааны ялгаа, өвчтөний насын ялгаа болон бусад хүчин зүйлүүдтэй холбоотой юм. Шинээр халдварт авсан бага насын хүүхдүүдийн 10% нь [136] амьдралынхаа туршид сурьеэз өвчинөөр өвчлөх эгзэгтэй байж болно гэсэн эрхий хурууны дүрмийг ерөнхийдөө баримталдаг, энэ эгзгийн тал хувь нь халдварт авсны дараах эхний 5 жилийн ноогдоно. Бага насын хүүхдүүдэд гэж 1-3 насын хүүхдүүдийг хамааруулав. Хүний амьдралын үлдэгдэл хугацаа богино байх тусам халдварт авах нийлбэр эгзэг төдий чинээ бага байна. "Анхдагч сурьеэз өвчин" гэж халдварт авснаас хойших 5 жилийн хугацаанд үүсэж байгаа өвчнийг нэрлэх болсон [122.137]. 5 жилийг тасалж авсан нь дураар хамаагүй авсан хугацаа мэт харагдаж болох талтай боловч энэ хугацаа нь дунджаар хүүхдийн амьдралын нь туршид шаардлагдах эгзгийн median нийлбэр юм.

Халдварт авсны дараа богино хугацаанд сурьеэз өвчинеөр өвчлөх шалтгаан нь ихэвчлэн "шүүлтүүр"-ийн ажилгаатай холбоотой; унтаа нууц байдалд байгаа халдвараас хамгаалах чадвар буурсан байх нь маш богино хугацаанд сурьеэгээр өвчлөх шалтгаан болно. Халдварт авсны дараагаар тэр даруйдаа сурьеэз өвчинеөр өвчлөхгүй байгаа нь хамгаалах тогтолцоо сайн ажиллаж байгааг илтгэнэ.


Халдварт авснаас хойш өнгөрсөн хугацаа бол сурьеэз өвчин үүсэхэд нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг байж болох юм. Шинэ халдварт бол эрт өмнө авсан халдвараас 10 дахин ихээр өвчин болон даамжрах магадлалтай хүчтэй нөлөөлөгч хүчин зүйл юм. Үүнээс гадна сурьеэгийн халдвартай тохиолдол бүр шинэ халдварт тээгч төрүүлэх ба энэ нь цаашид дахин шинэ өвчний тохиолдол үүсэх шалтгаан болж болно. Нийгэм дэх сурьеэгийн нийт өвчлөлийн тоонд сурьеэгийн халдвараас үүсч байгаа шинэ сурьеэтэй өвчтөний тоо онцгой холбогдолтой бөгөөд энэ нь нийгмийн халдварт авах эгзэг болон сурьеэгийн халдвартархалтаас хамаарна. Шинээр авсан халдварт нь өвчин болон даамжрахад нөлөөлөгч хүчин зүйл болох талаар энд хязгаарлан харуулсан байна. Энэ зөвхөн нийт 5 жилийн хугацаанд тодорхойлсон анхдагч халдварт анхдагч сурьеэз өвчин болох жилийн дундаж эгзэгт хамаарна, өмнө эрт халдварт авсан тохиолдола (сүүлийн 5 жилээс өмнө) сурьеэз өвчин үүсэх нийлбэр эгзэг нь урт хугацаанд хянахад анхаарал татаж болох юм.

Хүний дархлал хомсдолын вирусын халдварт

Хар тамхи хэрэглэгчдийн дунд хийсэн проспектив судалгааны явцад ахнаасаа туберкулин-эерэг байсан хүмүүсээс сурьеэз өвчинеөр шинээр өвчлөх тоог урьдчилан тогтоосон [138]. Ажиглалт хийсэн хоёр жилийн хугацаанд

туберкулины сорил болон ХДХВ-ын ийлдэс-эерэг 49 хүний 7-д нь сурьеэ өвчин үүссээ (100 хүн жилд 7.9). Сурьеэгийн халдварт авчихсан байсан хүмүүсд сурьеэ өвчин үүсэх эгзэг анхаарал татхуйц өндөр байсан, яагаад гэвэл 49 хүний 13 нь урьдчилан сэргийлэх эмчилгээ хийлгэсэн тул сурьеэ өвчинеөр өвчлөөгүй байна. ХДХВ халдварт M. tuberculosis-ын халдварт авсан тохиолдолд сурьеэ өвчин үүсэхэд нөлөөлдөг их хүчтэй хүчин зүйл болохыг энэ судалгааны дунд харуулсан [132]. Заир улсад хийсэн эргэмж когорт судалгаанд [139], ХДХВ-ын ийлдэс-эерэг эмэгтэйчүүдийн сурьеэгийн харьцангуй эгзэгийг ийлдэс-сөрөг эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад харьцангуй эгзэг нь 26 байсан байна.

Сурьеэгийн халдварт авсан байсан хүнд сурьеэ өвчин үүсэх эгзэг нь ХДХВ халдварт тараах хурдтай тэнцүү байдаггүй. АНУ-ын Флорида мужид [140] мөн Нью-Йоркт [141] хийсэн судалгаануудын дунд сурьеэ өвчиний илрэл болон Дархлалын Олдмол Хомдол (DOX)-ын хам шинж тэмдгүүдийн илрэлд хугацааны хамааралт байгааг тогтоосон. Флоридын судалгаанд сурьеэ өвчиний шинж тэмдгүүд бусад оппортунист өвчинээс 1 сарын өмнө 50%д нь, 1 сар




Зураг 53. Сурьеэ ба DOX-ын оппортунист өвчинүүдийн хоорондох цаг хугацааны хамааралт холбоо, Флорида, АНУ. [140]-вэс American Medical Association-ны зөвшөөрөлтэйгээр авав.

дотор эсвэл хойно 30%д нь, оппортунист халдвартыг оношлогсоны дараагаар 1 сарын хойно 20%д нь илэрч байсан байна (зураг 53).

Нью-Йоркт [141] үүнтэй ижил сурьеэз өвчний шинж тэмдэг илрэх нь бусад оппортунист өвчин илрэхтэй хугацааны хамааралтай байсан ба median нь 2 сар байсан байна. Бусад оппортунист өвчинүүд оношлогдохоос өмнө сурьеэз өвчин илрэх давтамжийн өсөлт дунджаар 3 жил байна. Мөн бусад оппортунист халдвартыг оношлогдох хуртлэх хонх-хэлбэрт муруйн заагыг бууруулах давтамжтайгаар нэмэгдэнэ. Энэ нь биологийн үнэнийн хувьтай юм, яагаад гэвэл ХДХВ халдвартыг оношлогдох тогтолцоог дарангуйлан халдвартыг бууруулах давтамжтайгаар нэмэгдүүлдэг. Энэ нь сурьеэгийн савханцар болон хүний биеийн эсийн дархлал хоёрын хооронд аюултай харьцааг бий болгоно.

Туберкулины сорилын урвал нь 5 болон түнээс дээш мм-ийн хэмжээтэй ХДХВ-ын халдвартыг авсан хүмүүсийн дунд хийсэн Италийн проспектив судалгаанаас үзэхэд ХДХВ-ын халдвартыг авсан хүмүүсийн сурьеэз өвчинеэр өвчлөх эгзэг нь CD+4 лимфоцитын тоотой шууд холбоотой болохыг тогтоосон (зураг 54) [142]. De Cock дархлалын дарангуйлан ба сурьеэз өвчний илэрлийн харилцан холбооны талаар судалжээ [143]. ХДХВ-ын чиг хандлагас хамаарч ХДХВ-ын халдвартыг авсан хүнд сурьеэз өвчин эрт үүсвэл ихэвчлэн ушигны хэлбэрийн сурьеэз байна. Дархлалын тогтолцооны дарангуйлан ахих тусам булчирхайн сурьеэз, ушиг, үнхэлиг, хэвлэлийн шингэнтэй хувьтай юм.




Зураг 54. ХДХВ-ын халдвартай хүмүүс CD4+ лимфоцитын тоогоос хамааран сурьеэз өвчинеэр өвчлөх эгзэг (100 хүн жилд гарах тохиолдлын тоо)


хэлбэр нь сурьеэгийн менингит болж хүндэрнэ. CD+4 эсийн тоо бага байх тусам тархмал хэлбэрийн сурьеэ ўсэх онцлогтой (зураг 55).

Лүрийн амьттан дээр хийсэн дэс дараатай судалгаа мөн ийм үр дүнг гарган баталжээ [144]. Туулай бол үхрийн сурьеэд төрөлхийн мэдрэг байдаг. Ийм амьтдал хөнгийт хэлбэрийн сурьеэ өвчин ховор, харин булчирхайн болон тархмал хэлбэрийн сурьеэ өвчин үүсдэг нь анхаарал татахуйц байв. Үүнтэй ижил, хуухэд анхдагч хүрц хэлбэрийн сурьеэгээр өвчилбел энэ нь булчирхайн болон тархмал хэлбэрийн сурьеэ өвчин байх эгзэг ёндөр юм [145-146].


Сүрьеэгийн савханцарын халдварт дээр нэмж ХДХВ-ын халдварыг хавсруулан авсан тохиолдолд унтаа, нууш хэлбэрийн сүрьеэгийн халдварт хүрс сүрьеэ өвчин болох жилийн эгзэг нь 5-10%тай байна [138,139,147,148]. Яагаад гэвэл туберкулины сорилын 5-9мм-ийн хоорондох урвалын хэмжээ сүрьеэгийн халдварталтанд хангалтгүй юм. Сүрьеэ өвчинөөр өвчлөх эгзэг нь ХДХВ халдварт авсан хүнд 2 дахин их байна. Энэ байдал Итали улсад хийгдсэн өөр проспектив судалгаанд мөн ажиглагдсан юм (зураг 56) [149]. Дээрхи судалгаануудын үр дүнгээс нэгтгэн дүгнэхэд ХДХВ-ын халдварт авсан хүмүүс сүрьеэ өвчинөөр өвчлөх эгзэг нь, нэгдүгээрт, сүрьеэгийн халдварыг хавсруулан авсан байх, хоёрдугаарт, дархлалын тогтолцооны хамгаалах чадвар ямар түвшинд байгаагаас хамаарна. ХДХВ-ын халдварын дараагаар сүрьеэгийн савханцарын халдварт авах нь өвчлөх эгзгийг маш ихээр нэмэгдүүлдэг: Энэ тохиолдолд эзэн бие нь нэвтэрсэн үүсгэгчийн эсрэг тэмцэх бараг ямарч



Зураг 55. ХДХВ-ын халдварт хүн сурьеэз өвчнөөр өвчлөхэд эмнэл зүй болон дархлал эмгэг зүйн харилцан холбоо. Эх баримтыг [143]-аас American Medical Association-ны зөвшөөрөлтэйгээр хэвлэв.



Зураг 56. ХДХВ-ын халдвартай хүмүүс туберкулины сорилын урвалын хэмжээнээс хамааран сурьеэз өвчнөөр өвчлөх эгзэг. [149]-өөс эх баримтыг ашиглав.



Зураг 57. Эрсдэлт хүчин зүйлсийн онцлогоос хамаарч сурьеэгийн халдвер сурьеэз өвчин болох эгзэгийн жишээ.

чадваргүй байна. Иймээс хувь хүн бүр сурьеэгээр өвчлөх эгзэг нь маш их ялгаатай байна, үүнийг зураг 57д харуулжээ.

Фибринэн сорвижилттойгоор аяндаа эдгэрдэг сурьеэ өвчин

Сурьеэ өвчин эмчилгээгүйгээр өөрөө аяндаа эдгэрч болно. Гэвч, эмчилгээ хийлгээгүй тохиолдолд өвчин дахиж хүндэрсэн хэлбэрээр илэрнэ. Фибринэн сорвижилттойгоор (“фибринэн гэмтэл”) аяндаа эдгэрдэг сурьеэ өвчинеөр өвчилсөн хүнд сурьеэ өвчин дахиж үүсэх эгзэг өслег [150-152]. ОУСҮӨТХ-оос хийсэн 5 жилийн судалгаагаар урьдчилан сэргийлэх эмчилгээний үр дунд фибринэн сорвижилттой аяндаа эдгэрсэн сурьеэгээр өвчилсөн хүмүүсийн дунд шинээр сурьеэгээр өвчлөх мэдээ тоог гаргаж авсан [152]. 5 жилийн турш судалсан судалгаагаар эмчилгээ хийлгээгүй плацебо хэсэгт жилд өвчлөх тоо нь 1,000 хүнд жилд 2,9 байжээ. Энэ нь Falk болон Fuchs [151] нарын хийсэн судалгааны дүнтэй ижил байжээ. Тэдний тооцоогоор 1,000 хүн жилд 2 тохиолдол шинээр илрэх байжээ. Гэвч Edwards ба бусадын хийсэн гурван судалгаанд энэ шинэ тохиолдлын тоо анхаарал татахуйц хэлбэлзэлтэй байна (2,6 ; 4,0 ба 13,6 шинэ тохиолдол 1,000 хүн жилд)[150]. Аяндаа эдгэрсэн сурьеэ өвчин рентген зурган дээрхи фибринэн голомтын хэмжээ нь дахин сурьеэ өвчин идэвхижих эгзигийг тодорхойлох чухал тодорхойлогч хучин зүйл юм [152]. Фибринэн голомтот гэмтэл нь 2 см ба түүнээс дээш хэмжээний голчтой өвчтөнд, үнээс бага хэмжээтэй голомттой өвчтөнтэй харьцуулвал сурьеэ өвчин идэвхижих үүсэх нь хоёр дахин илүү байна.

Nas

Шинээр илрэх сурьеэ өвчинд насыны хамааралын ялгаа их байна. Онолын хувьд энэ ялгаа нь халдварт авах эгзэг буюу халдвартын тархалт, халдварт нь өвчин болох эгзэг буюу аль альнаас нь хамаарч болно. Нас ахих тусам шинэ тохиолдлын тоо нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь нэмэгдэж хуримтлагдах байдлаар сурьеэгийн халдвартын тархалт нэмэгддэгтэй холбоотой. Шилжилтийн насынхан болон заплууцудал нууц далд халдварт илүү нэмэгдэх хандлагатай байхад (зураг 58)[156], арваас доош насынханд энэ байдал бага ажиглагдана. Насанд хүрэгчид болон 60 хүртлэх насынханд шинээр илрэх сурьеэгийн хувь тогтмол ихэсдэг. Гэхдээ энэ нь 60 наснаас өмнө сурьеэгийн халдварт авах эгзэг ихсэж байглийг тодорхойлсон [153].

АНУ-д сурьеэтэй өвчинүүдийн дунд хийсэн судалгаагаар ушигны бус эрхтний сурьеэз нас, хүйс, арьсны өнгө ,яс үндэс угсаанаас хамаарч өөр байгаа асуудлыг анх нээсэн [145]. Сурьеэз өвчин ба насыны онцлогийн харилсан хамаарал нь нас ахих тусам булчирхайн сурьеэгээр өвчлөх магадлал буурах, нас ахих тусам шээс бэлэг эрхтний сурьеэз өвчин ихсэх магадлалтайг харуулна. Булчирхайн, ялангуяа, ушигны угийн булчирхайн сурьеэгээр өвчлөх нь , халдварт авсан хугацаа болон нас бие гүйцэх үе шатын хүчин зүйлүүдийн улмаас биеийн эсэргүүцэл буурсны [141,154] илрэл үр дүн юм. Үүний эсрэгээр,

шээс бэлэг эрхтний сурьеэ өвчин бол тухайн эрхтэний удаан хугашааны далд хэлбэрийн сурьеэгийн илрэл байдал байна [155]. Ушигтын гялтан хальсийг гэмтээсэн сурьеэ өвчин бага насы хүүхдэл бараг байдалгүй [156]. Ушигтын гялтан хальсны сурьеэ бол ихэвчлэн M.tuberculosis-ын эсрэг биед үзүүлж байгаа дархалын тогтолцооны хожуу хэт мэдрэг урвалын илрэл юм, үүний улмаас ушигны гялтангийн хөндийд Т лимфоцит хуримтлагдаж шүүрэл үүсэхэд нөлөөлнө [157]. Бага насы хүүхдэл сурьеэгийн ушигны гялтангийн үрэвсэл тохиолдлогтуй нь тэдний насынханд туберкулинд мэдрэг байдал бага байдалтай холбоотой.

Генетикийн хүчин зүйлс

Prophit-ын судалгааны дунг дахин эргэн судлаж төөрөлдүүлэгч хүчин зүйлсийн боломжийн ялгааг нягтлан үзэжэд, сурьеэ өвчнөөр өвчлөх эгзэг нь нэг эсийн ихрүүдэл хоёр эсийн ихрүүдийнхээс их байсан [158]. Энэ нь төрөлхийн сурьеэ өвчинд мэдрэг байх чанар нь сурьеэ өвчнөөр өвчлөх эгзэгт чухал нөлөөтэйг харуулсан.

Сурьеэ өвчнөөр өвчлөх эгзийг тодорхойлох маш олон тооны генетикийн хүчин зүйлс байх ба зарим нэгийн талаар энд дурыдах болно.


Xүйс

Эрэгтэй болон эмэгтэй хүмүүсд сурьеэгийн халдвэр авсны дараа сурьеэ өвчнөөр өвчлөх нь ялгаатай байх магадлалтай. Пуэрто-Рикогийн BCG вакцинжуулалтын судалгааны хүрээнд туберкулины сорил зэрэг урвалтай хүмүүсээс, эмэгтэйчүүдэд сурьеэ өвчин шинээр үүсэх магадлал 18%иар эрэгтэйчүүдийнхээс их байсан [136]. Данийн үндэсний судалгаанд [102], 15-40 насын халдвэр авсан эмэгтэйчүүдэд сурьеэ өвчнөөр өвчлөх эгзэг нь эрэгтэйчүүдийнхээсээ их байсан бол, 44-өөс дээш насынханд энэ эгзэг нь эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийнхээс бага байсан байна.


Тайланд улсын камбожийн дөрвөгсөдийн дунд хийсэн ушигны бус эрхтний сурьеэ өвчиний судалгаанд, эрэгтэй эмэгтэй хүүхдүүдийн дунд булчирхайн сурьеэ өвчиний давтамж ижил байсан бол насанд хурсэн эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийнхээс илүү ихээр тохиолдож байсан байна, энэ нь сурьеэ өвчнөөр өвчлөх нь генетик болон насын онцлогоос хамаардагийг илтгэж байна.

АНУ-д хийгдсэн ушигны бус эрхтний (УБЭ) сурьеэтэй хүмүүсийн дунд хийсэн судалгаагаар эрэгтэй болон эмэгтэй хүмүүсд УБЭ сурьеэ өвчин үүсэх магадлалын гайхалтай ялгааг тогтоосон [145]. УБЭ сурьеэ дотроос гялтан хальсыг гэмтээсэн сурьеэ өвчин аль аль хүйсэнд ижил хэмжээтэй тохиолдож байсан (нас, арьсны өнгө, яс угсааны нь тохируулан ангилж судлахад).

Бусад УБЭ сурьеэ (булчирхай, яс үе мөч, гэдэс, зүрхний хальс, менингит болон бусад ховор хэлбэр) эмэгтэй өвчтнүүдэд илүүтээгээр тохиолдож байжээ [160]. Судлаачийн тэмдэглэснээр, эмэгтэйчүүдийн давамгайлал 20-24



Зураг 58. Сурьеэз евчин анх оношлогдоход наснаас хамааран тубекулинд анх урвал егсан сурьеэгийн шинэ тохиолдлын тоо. Эх баримтыг [136]-аас American Journal of Epidemiology –ийн зөвшөөрөлтэйгээр хэвлэв.



Зураг 59. Камбожийн дервэгсэд дундах захын тунгалгын булчирхайн сурьеэз евчин, нас болон хүйсээр, Тайланд, 1981–1984. Эх баримтыг [159]-аас ашиглав.

насныханд харьцангуй байсан бэл 10-14 насныханд хамгийн их байжээ. Эдгээр баримтууд нь сурьеэгээр өвчлөх эгзэг болон түүний илрэлд нас болон дааврын хүчин зүйлүүд их нөлөөтэй болохыг илчилж байна.

Биеийн галбир бүтэц

Сурьеэ өвчинеөр өвчлөх нь хүний биеийн галбиртай шууд хамааралтай талаар анхаарал татахуйц баталгаа байна [161]. АНУ-ын тэнгисийн усан цэргийн шинэ цэргүүдийн дунд хийсэн болон ВСГ вакцины Алабама мужийн Жеоржия хотод хийсэн судалгаануудын баримтаас дүгнэнэ үзэхэд хэвийн биеийн жингээс бага жинтэй хүмүүсд, өндөртэйгээ харьцуулахад хэвийн жинтэй хүмүүсээс сурьеэ өвчиний шинэ тохиолдын тоо 2.2-ээс 4 дахин их байсан. Эдгээр судалгаануудад туберкулинд үзүүлэх хариу урвалаар нь тохируулалт хийгдсэн байжээ. Норвеги улсад Tverdal [165] 14-ээс дээш насны 1.2 сая хүмүүсийн дунд 8-19 жилийн хугацаатай биеийн жингийн индекс болон сурьеэгийн шинэ өвчлөлийн хооронд холбоог судалжээ. Биеийн жингийн индекс нэмэгдэхтэй холбоотойгоор ушигны хэлбэрийн сурьеэгийн тохиолдын тоо (УБЭ сурьеэ хамаарахгүй) логорифмийн дараалал бүхий овон товон шугамын хандлагатайгаар буурна. 30-49 насныханы биеийн жингийн индексээс хамааралтай үссэн халдвартай хэлбэрийн сурьеэгийн шинэ тохиолдын тоог хүйсээр ялган зураг 60-т дурсэлжээ [165].

Цагаан цогцосны эсрэг төрөгч (HLA) -ийн хэлбэр

Сурьеэ өвчинеөр өвчлөх нөлөөлдөг хүний генетикийн хүчин зүйлүүдийн дотроос human leukocyte antigen (HLA) буюу хүний цагаан цогцосны эсрэг төрөгчийн хэлбэрүүдийн талаар эрчимтэй судалсан. Зарим судалгааны үр дүнгээр HLA-ийн хэлбэрүүд дотроос A11-B15 болон DR2 нар нь сурьеэ өвчиний шинэ тохиолдын үүсэх боломж магадлалын хувийт 1.5-3.5-ын зэргээр ихэсгэж байсан байна [166-168]. HLA-ийн хэлбэр сурьеэ өвчин үүсэхэд нөлөөлөх холбоог нарийн тогтоогоогүй ч, Hawrikins at al. нар Гонконгийн хятадуудын дунд явуулсан судалгаагаар [169](256 ушигны хэлбэртэй тохиолдол болон 100 эрүүл хяналтын хэсгийн хүмүүс) статистикийн хувьд ач холбогдолгүй хамааралтай болохыг олж тогтоосон. Hawrikins at al. гэр бүлд нь сурьеэ өвчиний тохиолдол олон тохиолдож байсан 21 гэр булийн 93 хүүхэд болон 38 эцэг эхийн HLA-ийн хэлбэрийг тусгаарлан тогтоох судалгаа хийгээд ямар ч хамаарал олж тогтоогоогүй байна.

Цусны бүлэг

Overfield болон Klauber нарын [170] сурьеэгээр өвчилсөн эскимосуудын дунд хийсэн судалгаагаар AB эсвэл В бүлгийн цустай хүмүүсийн сурьеэ өвчинеөр өвчлөх эгзэг О буюу A бүлгийн цустай хүмүүсийнхээс их байсныг тогтоожээ.

Гемофили


Хүүхдийн эмнэлэгт гарсан сурьеэ өвчний дэгдэлтийн үед гемофилигээр өвчилсөн хүүхдүүд бусад өвчтэй хүүхдүүдтэй харьцуулахад илүүтэй сурьеэ өвчинеэр өвчлөх эгзэгтэй байсан [171, 172]. Энэ нөлөөлөлд өртсөн гемофилийтэй 16 хүүхдийн б-д нь сурьеэ өвчин үүссэн, харин бусад өвчтэй 75 хүүхдийн 3 нь сурьеэ өвчинеэр өвчилжээ. Хэрэв ХДХВ-ын халдвартай байсан 2 эрэгтэй хүүхдийг хасвал, харьцангуй эгзэг 7.1 байна. Нөлөөлөлд өртсөн гемофилийтэй хүүхдүүдтэй ижил нөхцөл байдал байсан лейкоми болон хорт хавдартай байсан хүүхдүүдэд гемофилийтэй хүүхдүүдийнхтэй төстэй дур зураг ажиглагдсан байна (нөлөөлөлд өртсөн 21 тохиолдлын 10-д).

Цэвэр хүн ам

Үрьд өмнө хэзээ ч сүрьеэ өвчинтэй учирч байгаагүй хүн ам халдвартасны дараагаар сүрьеэ өвчинөөр өвчлөх эгзэг маш их байдагийг дурьдах хэрэгтэй [173, 174].

Генетикийн бусад хүчин зүйлс

Дээр өгүүлсэн хүчин зүйлс халдварт, сүрьеэ өвчин болоход нөлөөлөхүйц хүчин зүйлс юм. Мөн сүрьеэ өвчний эмнэл зүйн илрэлд нөлөөлех зарим хүчин зүйлсийн талаар дурьдагдсан. Нэг гэр булийнхэн маш ховор тохиолдох арьсны сүрьеэ өвчинд их өртөмтхий байсан тухай мэдээлэл байна. Энэ гэр булд бусад хэлбэрийн сүрьеэ бараг үгүй байхад зөвхөн арьсны сүрьеэ өвчин илэрсэн байна (зураг 61) [175].




Зураг 60. Биөийн жингийн индекс болон хүйснээс хамаарсан сүрьеэгийн халдвартын шинэ тохиолдлын тоо, Норвеги улс. Эх баримтыг [165]-аас авав.

Баруун Африкийн Гамби улсад [176] хийсэн тохиолдол-хяналтын судалгаагаар сүрьеэгийн халдвэр өвчин болж хөгжихгүй байх төрөлхийн тэсвэртэй байдалыг бий болгодог ген макрофаг protein1 (nrampl1)-ийг нээж баталжээ. Гэвч энэ судалгааны үр дүн маргаантай байсан, яагаад гэвэл сүрьеэгийн халдвэр болон хүрээлэн буй орчны mycobacteria-ийн тархалтыг, судалгаа явуулсан улс оронд урьдчилан тогтоогоогүйтэй холбоотой [177]. Үүний дараагаар амьтан дээр хийсэн судалгаагаар nrampl1 бодис нь өөр зүйлийг хамгаалах харьяалалтай болохыг тогтоосон [178].

Хар арьстай Америк хүмүүс сүрьеэгийн халдвэр авсны дараагаар цагаан арьстай Америкчуудаас илүүтээгээр сүрьеэз өвчинд мэдрэг байх ёстой гэсэн үзэл өөрчлөгдсөн [181,182]. Арьсны өнгөний ялгаа ажиглагдсан өвчиний давтамжын ялгаанд ихэнхдээ тухайн хүн ам доторхи халдварын шинэ тохиолдол болон халдварын тархалт нөлөөлнө. Пуерто Рикогийн BCG вакцинжуулалтын судалгаанд оролцсон олон тооны оролцогчдыг даган судлахад хар цагаан арьстнуудын туберкулинд мэдрэг чанар нь хоорондоо их ялгаагүй байсныг тогтоосон [97,136]. АНУ-ын тэнгисийн усан цэргийн шинэ цэргүүдийн дунд хийсэн судалгаанд туберкулинд зэрэг хариу урвал өгсөн хар цагаан арьстын тохиолдлын хувь ижил байсан байна. Гэхдээ азиудын дунд (ихэнх нь Филиппины хүмүүс байсан) шинэ тохиолдлын тоо хар цагаан арьстангаас өндөр байсан нь ажиглагдсан [183].

АНУ дах хар болон цагаан арьстанууд халдварын дараагаар сүрьеэз өвчинеөр өвчлөх ялгаа нь маш бага юм. Арьсны өнгөнөөс хамаарч сүрьеэгийн шинэ тохиолдлын тоо удаан хугацааны явцад насанд хүрэгчдийн дунд буурах



Зураг 61. Нэг гэр бүлийн гишүүдэд илэрсэн арьсны сүрьеэз өвчний давтамж. Харлуулсан тэмдэг нь сүрьеэз өвчний улмаас нас барсан тохиолдлыг, хоёр босоо шугам нь тодруулаагүй тархалт, мөн дугуй нь хүйс нь тодорхой бус тохиолдол. [175]-аас зургийг Springer-Verlag GmbH-ийн зөвшөөрөлтэй ашиглав.

нь хар ба цагаан арьстануудын халдварт авах эгзгийн хувиас хамааралтай ялгаатай байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Гэвч анхаарал татахуйц ялгаа АНУ-д хийгдсэн УБЭ сүрьеэгийн судалгааны дүнгээс гарсан, арьсны өнгө , удам угсаанаас хамаарч УБЭ сүрьеэгийн байрлал ялгаатай байсныг тогтоосон[145]. Жишээ нь, хар арьстай сүрьеэтэй өвчтөнүүдэд испани-гаралгүй-цагаан арьстануудтай ижил байдлаар зөвхөн тал хувьд нь шээс бэлэг эрхтний сүрьеэз үүсэх магадлалтай байсан бол, хоёр дахин илүүтэйгээр тархмал сүрьеэз үүсэх магадлалтай байв. Америкийн индианчуудад бутчирихайн сүрьеэз өвчин үүсэх магадлал испани гаралгүй цагаан арьстануудынхтай ижил байсан бол, хэвлүүн сүрьеэз өвчин үүсэх магадлал 11 дахин их байсан. Эдгээр ялгаанууд тайлбаргүй үлдсэн боловч генийн эсвэл гадаад орчны хүчин зүйлүүдийн нөлөө өвчиний байрлалыг тодорхойлж байна гэсэн таамаглал байна.

Хүрээлэн буй орчны хүчин зүйлс

Гаж зуришил

Тамхи татах

Англид хийгдсэн хоёр судалгаанд тамхи татах болон сүрьеэз өвчинөөр өвчлөх эгзгийн уялдаа холбооны талаар тодорхойлсон [184,185]. Эдгээр тохиолдол-хяналтын судалгаагаар, татсан тамхины тоо нэмэгдэх тусам сүрьеэз өвчинөөр өвчлөх боломж магадлалын хувийг өсгөж байсан (зураг 62) [185].


Шанхайд хийсэн судалгаагаар тамхи татдаг хүмүүс дотор тамхи татдагтуй хүмүүстэй харьцуулахад сүрьеэз өвчиний өвчлөл илүү их байсан [186]. Энэ байдал нь нас, хүйс, ажилын төрөл, хавьталтай байсан эсэх болон амьдрах орчноосоо хамаarahгүй байсан байна.

Arхи хэтрүүлэн хэрэглэх

Клиничийн эмч нарын удаа дараа тэмдэглэснээр архини хэрэглээ ба сүрьеэгийн тохиолдлын хооронд харилцан уялдаа байна гэжээ. Хэдий ийм боловч шалтгаант холбооны тархвар судалалын дүгнэлт хийхэд дээрхи холбоо нь шийдвэрлэхүй биш юм. Энэ холбоо гадаад орчны нөлөөтэй хамааралтай (аж үйлдвэржсэн орнуудад маш бага) байх *M.tuberculosis*-ын халдварт, тархалтыг нэмэгдэхэд тулхэц болно. Гэвч архийг хэт ихээр хэрэглэх нь сүрьеэгийн эсрэг мэдрэг [187] байдлыг хангах дархлалын механизмуудыг гэмтээж сүрьеэз өвчинөөр өвчлөх эгзгийг ихээр нэмэгдүүлнэ.

Хар тамхичид

Reichman ба түүний хамтран ажиллагсад хар тамхи тарьж хэрэглэгчидийг хар тамхи хэрэглэдэгтүй хүмүүстэй харьцуулахад сүрьеэгийн халдварт авсны



Зураг 62. Тамхи татдаг ЗО-аас дээш насны эрэгтэй хүмүүсийн өдөрт татдаг тамхины тооноос хамаарч сурьеэ өвчнөөр өвчлөх харьцангуй боломж магадлалын хувь, Их Британи. [185]-аас BMJ Publishing Group-ийн зөвшөөрөлтэйгэр авав.

дараагаар сурьеэ өвчнөөр өвчлөх эгзэг нь маш их байдагийг батлан тогтоосон (ДОХ-ыг нээхээс 2 жилийн өмнө)[188]. Энэ нь methadone-maintenance хөтөлбөрт оролцогчдын туберкулинд мэдрэг байдал нь нийт хүн амтай харьцуулахад ялгаагүй байсан нь шинэ өвчлөлийн илрэлд нөлөөлнө гэсэнд үндэслэгдсэн байна.

Хоол тэжээл

Хоол тэжээлийн дутагдал

Хоол тэжээлийн дутагдал дархлалын тогтолцоонд серег нөлөөтэй болох нь тодорхой. Герман улсад Дэлхийн I-ээр дайны үед сурьеэ өвчний улмаас нас барагчдын тоо хурдацтай өссөн, дайны дараагаар энэ тоо буурсан боловч 1922-1923 онуудад мөнгөний ханш унаж юмны үнэ өсөж хоол хүнсний хури хомсдолд орсонтой холбоотойгоор дахин нэмэгджээ [189]. Нидерланд улсад Дэлхийн II дайн эхлэхтэй хамт сурьеэ өвчний улмаас нас барах тоо нэмэгдсэн боловч, үүнийг Германчууд импортын хүнсэнд хориг тавьж шаардлагатай тэжээл авахыг огцом гэнэт зогсоосонтой илүүтээгээр холбож тайлбарладаг байна [189]. Швейцар улс Дэлхийн II Дайнд бага өртсөн боловч хоол тэжээлийн дутагдалд орж сурьеэ өвчний улмаас нас барагчдын тоо нэмэгдсэн ч энэ нь Герман буюу Нидерландатай харьцуулахад бага боловч анхаарал татахуйц байсан юм [189].

Хоолны дэглэм

Хүнсэндээ мах хэрэглэдэгтүй (шагаан хоолтон. Редактор) хоолны дэглэм нь сурьеэ өвчиний эгзэтг хүчин зүйл гэж тогтоогдсон [190]. Тохиолдол-хяналтын судалгааны үхрийн мах буюу загасны мах хүнсэндээ хэрэглэхгүй байх нь энэ эгзгийг нэмэгдүүлэх хандлагатайг илрүүлсэн. Хамгийн өндөр боломж магадлалын хувь нь дан сүүн бүтээгдэхүүн хүнсэндээ хэрэглэгсэд байсан. Үүнтэй холбогдуулж, ялангуяа нарны туяаны нөлөөлөлд бага байдаг хүмүүсд хүнсэндээ Д витаминыг нэмэж хэрэглэх нь чухал гэсэн зөвлөмж гарсан [191]. Д витамины идэвхитэй задралын бүтээгдэхүүн болох 1.25-гидроокси-витамин ДЗ нь хүний мониш болон макрофагийн боловсролт идэвхжилийг дэмжих ба энэ нь сурьеэгийн савханцырын хуваагдлыг дараангуйлагч болгийг баталсан [192]. Их Британий шагаачлын дунд хийсэн судалгааны дун тэдний сурьеэ өвчинеэр өвчилсөн нь (ижэвчлэн УБЭ сурьеэ байсан) витамин Д-ийн дутагдалтай холбоотой гэсэн таамаглалыг дэвшүүлсэн байсан [193]. Гэвч төөрөлдүүлэгч үр нөлөөний тоо маш их байсан нь баттай дүгнэлт өгөх боломжгүй болгосон.

Эмнэлгийн нөхцөл байдлууд

Ушиг тоосжих буюу силикоз

Уурхайчил болон силикоз өвчтэй хүмүүсийн дунд сурьеэ өвчин элбэг байдаг нь эрт үес мэдэгддэг байсан [194]. Paul силикозтой уурхайчлын дунд, сурьеэгийн өвчлөл силикозгүй уурхайчилтай харьцуулахад 26 дахин их байсныг тогтоосон [195]. Westerholm et al. Шведийн Үндэсний Пнеумокониозын бүртгэлийн сурьеэгийн судалгааны дунг нийтэлсэн, энэ судалгаагаар силикозтой өвчтөнүүд сурьеэ өвчинеэр өвчлөх боломж магадлалыг нь хяналтын бүлэгтэй харьцуулахад 30 дахин илүү байжээ [196]. Урт хугацаанд дагаж судалсан Өмнөд Африкийн алтны уурхайчдын дунд хийсэн судалгаагаар силикозтой эрэгтэйчүүдийн сурьеэ өвчиний харьцангуй эгзэг нь силикозгүй эрэгтэйчүүдийнхтэй харьцуулвал 2.8 байжээ [197]. Эдгээр хүнд хэлбэрийн силикозтой хүмүүсийн зөвхөн 55 % нь дараагийн 7 жилийн сурьеэ өвчинеэр өвчлөөгүй үлдсэн байна, жилийн дундаж эгзэг нь 6.3% байжээ (зураг 63)[197]. Өмнөд Африкийн алтны уурхайчдын судалгааны эрсдэлт хүчин зүйлсийн эгзгийг нарийвчлан авч үзвэл уурхайчдын мэргэжлээс хамаарч байгаа чухал зүй тогтолыг тогтоосон [198]: дрильдэх нь, жишээ нь, тоос широонд бага өрттөг мэргэжилтэй хүмүүстэй нь харьцуулахад 2 дахин илүү сурьеэ өвчинеэр өвчлөх өндөр эгзэгтэй байсан.

Чихрийн шижин өвчин

Чихрийн шижин өвчин сурьеэ хоёрын харилцан холбооны талаар ойлголт эртнээс байсан ба энэ хоёр дандаа давхцан хавсарч явагдлаг гэсэн

оилголт давамгайлан зонхилж байсан. Гэсэн хэдий ч сахарын өвчтэй хүмүүсийн дундах сурьеэз өвчний өвчлөлийг хяналтын хэсэгтэй харьцуулан судалсан цөөн тооны том судалгаа байна. 1940-өөд оны дундуур Финланди улсад хийсэн судалгаагаар чихрийн шижин өвчтэй хүмүүс доторхи сурьеэгийн шинэ өвчлөл нь 8.4 %-тай байсан байхад чихрийн шижин өвчингүй ажилгүй хүмүүс доторхи сурьеэгийн шинэ өвчлөл нь 4.3 %-тай байсан байна [199]. Шведэл Silwer dg Oscarsson нарын тогтоосноор [200, 201] чихрийн шижин өвчтэй өвчтөнүүдийн дотор ушигны хэлбэрийн сурьеэз өвчин нь 3.6%-тай байсан байхад хяналтын хэсгийн хүн амд 0.88%-тай байжээ. Нас хүйсээр нь ялгасны дараагаар харьцангуй эгзэг 3.6 байжээ. Opsahl болон бусад судлаачдынхаар чихрийн шижин өвчтэй хүмүүсийн дундах шинэ сурьеэгийн тохиолдлын тоо нийт хүн амтай харьцуулахад 3 дахин их байсныг тогтоосон [202]. Эдгээр судалгаа нь чихрийн шижин өвчтэй хүмүүсийг сурьеэгийн халдвартыг тэсэж дааж чадлагтүй болохыг баталсан. Гэхдээ чихрийн шижин өвчтэй хүмүүс чихрийн шижин өвчингүй хүмүүсээс илүүтэйгээр сурьеэгийн халдвартыг авдаг гэсэн уг биш юм. Цаашид доорхи зүйлийг тэмдэглэх хэрэгтэй, чихрийн шижин өвчин нь сурьеэз өвчинтэй ээрэг шугэлцээтэй бөгөөд биеийн жингийн өсөлттэй сөрөг хамааралтай байна [162,165,203]. Үүнээс улбаалан биеийн жин нь тодорхойгүй чихрийн шижин өвчтэй хүмүүсд сурьеэгийн эгзигийг буруу үнэлж боломж гарч байна.

Хорт хавдрууд

Сурьеэз өвчний нас барагт хорт лимфоматай холбоотой байгаа нь анхаарал татсан [204]. Ушигны хорт хавдар, лимфосаркома, болон ясны хэмийн эсийн саркоматай өвчтөнүүдэл сурьеэгийн тохиолдол элбэг бүртгэгдэж мэдээлэгдсэн байдаг [205]. Feld болон бусад судлаачдынхаар хорт хавдарт шилждэг өвчтэй өвчтөнүүд дотор сурьеэз өвчинеэр өвчлөх явдал байдгийг тэмдэглээд, ялангуяа толгой хүзүүний карциноматай хүмүүсд онцгойлон сурьеэгийн өвчлөлийн давтамж өндөр байсныг олж нээсэн [206]. 10 шинэ сурьеэгийн тохиолдол нийт 1366 (1000 тутамд 7 тохиолдол) толгой хүзүүний squamous cell карциноматай өвчтөнд илэрсэн нь нийт хүн амын ижил насны (45-65 нас) жилийн тохиолдлын тоо 100 000-д 45 байгаатай харьцуулахад харьцангуй эгзэг нь 16 гэж бүртгүүлэх магадлалтай байна. Анхдагч хорт хавдрыг оношлосны дараагаар сурьеэз өвчин илэрч байсан боловч энэ хугацаа нь тодорхойгүй байжээ. Хэдий ийм боловч бусад хэлбэрийн хорт хавдруулттай хүмүүсд сурьеэз өвчин хамаагүй бага давтамжтай тохиолдож байсан нь, дээрхи үр нөлөө нь эмнэл зүйн-суурьтай судалгааны, үндэслэл муутай үр дунд тогтоогисон биш гэдэгт итгэлийт төрүүлж байна.

Бөөрний дутагдал

Бөөрний үйл ажиллагааны дутагдлын төгсгөлийн шатанд орсон, тогтмол гемодиализ хийлгэдэг өвчтөнүүдэд сурьеэз өвчинеэр өвчлөх эгзэг нь өндөр


[207-212]. Ийм өвчтөнүүлдэд шинэ өвчлөл бүртгэгдэх нь нийт хүн амтай харьцуулахад 10-аас 15 дахин их байдаг.

Улаан бурхан

Улаан бурхан өвчин нь туберкулинд мэдрэг чанарыг бууруулж багасгадаг [213,214]. Улаан бурхан өвчин сүрьеэгээр өвчлөх эзгийг мөн л нэмэгдүүлдэг гэсэн итгэл одоо хүртэл элбэг байна. Гэвч байгаа бололцоотой мэдээллийг судлан дүгнэхэд энэ таамаглалыг дэмжих баталгаа маш цөөн байна [215].

Гастроэктоми (ходоод тайрах)

Гастроэктоми нь сүрьеэгийн өвчлөл их өндөр байхтай холбоотой [216]. Олон тооны судалгаанд гастроэктомитэй өвчтөнүүд дунд нийт хүн амтай харьцуулахад шинэ сүрьеэгийн өвчлөл илүү их байна гэх боловч, хяналтын хэсэгтүй байсан нь их том дутагдал юм. Thorn болон бусад судлаачдынхаар дээрхи дутагдлыг хэсэгчлэн үгүй болгож өөрсдийн судалгаандаа гастроэктоми хийлгэсэн эрэгтэйчүүд шинээр сүрьеэ өвчнөөр өвчлөх нь энэ наасны ижил орон нутгийн эрэгтэйчүүдийнхаас 5 дахин их болохыг тогтоосон [217]. Гэсэн хэдий ч гастроэктоми бол өөрөө нөлөөлөгч хүчин зүйл болно, эсвэл ямар нэгэн өөр нөлөөлөгч хэвийн биеийн жин өөрчлөгдхөх, хавдар шархлаа дахих зэрэг хүчин зүйлүүдтэй хамтран хоёрдогчоор нөлөөлнө. Thorn болон бусад судлаачдын судалгаанд, жишээ нь, гастроэктоми хийлгэсэн өвчтөнүүдийн 85% нь биеийн хэвийн жингээс бага жинтэй байсан ба эдгээр өвчтөнүүдийн биеийн



Зураг 63. Өмнөд Африкийн силикоzтой алтны уурхайчдаас сүрьеэ өвчнөөс ангид улдсэн хувь. [197]-оос American Thoracic Society/ American Lung Association-ны зөвшөөрөлтэйгээр хэвлэв.

жинг өндөртэй нь хэвийн жинтэй хүмүүстэй харыулахад 14 дахин илүү сурьеэ өвчинеэр өвчлөх боломжтойг харуулсан [217].

Нарийн болон өлөн гэдэсний хагалгаа

Нарийн болон өлөн гэдэсний хагалгаа нь сурьеэ өвчин үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл болох талаар тодорхой хэмжээний баримт байна [218]. Ийм өвчтэй хүмүүсийн дотор өвчний тархалт өвчлөл их өндөр байсан гэж бүртгэгдсэн боловч [219,220] бүртгэгдсэн тохиолдлын тоо нь маш цөөн байв.

Кортикостероид эмчилгээ

Стероид эмчилгээ нь сурьеэ өвчин үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл гэдэг нь маргаантай асуудал юм. Lurie-ийн түүлэй дээр хийсэн хэд хэдэн туршилтаар глюокортикоидын их хэмжээний тун түүлайд нөлөөлж сурьеэгийн савханцарт тэсвэртэй байдлыг нь бууруулах нь маргаантай байна гэдгийг харуулсан [221]. Horne өөрийн илтгэлдээ кортикостероид эмчилгээ нь сурьеэ өвчин үүсэхэд нөлөөлөх нь маш бага гэж тэмдэглэсэн [222]. Үүнтэй ижил, Haanaes ба Bergmann нар Норвеги улсын сурьеэтэй өвчтөнүүдийн дунд хийсэн том хэмжээний судалгаандаа кортикостероидыг 10 мг буюу үүнээс бага тунгаар өдөр бүр урт хугацаагаар уух, эсвэл их тунг богино хугацаанд хэрэглэх нь сурьеэ өвчин идэвхижихэд маш бага нөлөөлнө гэж дүгнэсэн [223]. Smylie ба Connolly нар эмнэлэгт хэвтэж кортикостероидоор эмчлүүлж байсан 555 өвчтөнг, 499 эмчилгээ хийлгээтгүй хүмүүстэй харыуулан проспектив аргаар судалсан [225]. Даган судалсан хугацаанд 1.5-7 жил дотор кортикостероид хэрэглэж байсан өвчтөнүүдээс зөвхөн 1 сурьеэгийн тохиолдол харин хяналтын хэсгээс 2 сурьеэгийн тохиолдол илэрчээ. Гэвч лабораторийн дүгнэлт [221,226] болон хувь тохиолдлын бүртгэлээс харахад стероидын их тун, сурьеэ өвчин үүсэхэд серег нөлөө үзүүлж болох юм [227,228]. Үүнээс үүдээд энэ нөлөөлөгч хүчин зүйлээс сэргийлэх уйл ажиллагаа шаардлагатай гэдгийг ойлгох хэрэгтэй [229].


Жирэмслэлт

Сурьеэ өвчин үүсэн хөгжихэд жирэмслэлт хэр ач холбогдолтой болох талаар удаан хугацаанд маргаж ирсэн [230]. Snider өөрийн илтгэлдээ сурьеэ өвчин үүсэхэд жирэмслэлт серег нөлөөгүй гэсэн баттай дүгнэлтэнд хурч чадаагүй [230]. Гэвч жирэмслэлтийн сүүлийн саруудал сурьеэ өвчин идэвхижих магадлал их гэдэг нь тодорхой болсон [231]. Жирэмсний эхэнд болон сүүлийн 6 сард үссэн 65 сурьеэ өвчний тохиолдлын 37-д нь жирэмсний сүүлийн саруудал үүсжээ. Үүнээс үндэслэн жирэмслэлтийн нийт хугацаанаас сүүлийн хэсэгт сурьеэ идэвхижих эгзэг нь 2 дахин нэмэгдэх магадлалтай.

Шалтгааны хүчин зүйлстэй холбоотой нөлөөлогч хүчин зүйлс

Халдвартуулах тунгийн үр нөлөө

Ratcliffe ба Palladino нарын жижиг сүүн тэжээлтэн амьтан дээр хийсэн туршилт судалгаагаар, ихэвчлэн бүх сурьеэгийн савханцар нь гани биет байдлаар амьсгалагдаж уушигны цулсан хүрч тэндээ төвгөнцөр үүсгэдэг гэдгийн батлан харуулсан [232]. Үүнээс хараад халдвартуулсан тунгийн нөлөө сурьеэ өвчин үүсэхэд угүй мэт байна, ө.х. амьсгалагсан сурьеэгийн савханцрын тооноос өвчин үүсэх эсэх нь шалтгаалахгүй. Хэдий тийм боловч, Канададын Их Британий Колумби ба Саскатчеванд, Grzybowski болон бусад судлаачдын хийсэн судалгаагаар хэрэв халдвартын эх уурхай нь цэргийн түрхэц-ээрэг бол түүний халдвартуулах эгзэг нь цэргийн түрхэц-сөрөгөөс хамаагүй их байж энэ халдварт нь өвчин болох эгзэг мөн өндөр байх болно гэдгийг харуулсан [30]. Энэ хүчин зүйлийн нөлөө арьсны өнгө, хүйсээр ялгасан ч ямар ч өөрчилгүйгээр одоо хүртэл нэг хэвэндээ хадгалагдаж байна (зураг 64) [30, 132]. Тэгэхдээ энэ баримт мэдээг шалтгаант хүчин зүйлтэй нь уялдуулан авч үзэх хэрэгтэй. Энэ судалгаанаас хараад, гувдруүний голчийн хэмжээ 5мм-ээс дээш байхад туберкулины сорилыг зерэг гэж тооцсон юм шиг сэтгэгдэл төрүүлж байна. Үнэндээ сорилын шинжилгээний өвөрмөц чанар нь 100% хувь байх боломжгүй юм.



Зураг 64. Канад улсын Их Британий Колумби ба Саскатчеванд хийсэн судалгаагаар, эх уурхайн нян ялгаруулалтын байдал болон хавьтлын хэлбэрээс шалтгаалан, нян судлалаар батлагдсан хоёрдагчоор үссэн сурьеэ өвчиний хувь, 1966–1971; т+ цэргийн түрхэг зерэг болон т-цэргийн түрхэц сергийг илтгэнэ; е+ өсгөвөр зерэг, е- өсгөвөр сөрөгийг илтгэнэ. [30, 132]-оос эх баримтыг ашиглав.

Яагаад гэвэл сүрьеэгийн халдвартын тархалт ойрын хавьталаа тохиолдлын хавьтлынхаас их байна, биим ба түүнээс дээш гувдруүний таамаглах нэгжийн сүүлийн хэд нь нөгөө хэсгээс бага байна. Иймээс хариу урвал узүүллэгсэд дотроос сүүлийн хэсгийнхэд нь сүрьеэ өвчнөөр өвчлөх эзэг бага байна.

Омогийн хоруу чанар

Сүрьеэгийн савханцарын омогууд нь хоруу чанарын хувьд ялгаатай байдаг нь туршилтын амьтад дээр батлагдсан [234-239]. Саяхнаас, туршилтын амьтанд илүү хоруу чанартай омог нь хүнд мөн өндөр хоруу чанартай байдгийг батлан тогтоосон [240]. Үнэхээр их хоруу чанартай омог нь сүрьеэгийн менингитийн шалтгаан болох илүү их онигой хандлагатай нь харагдсан [241].

Изониазидэд өндөр тэсвэртэй каталаз сөрөг организмууд усан гахайд бага хоруу чанартай байдгийг тогтоожээ [242]. Гэвч хулгана дээр сүүлийн үеийн хийсэн судалгаагаар сүрьеэгийн савханцарын эмэнд дасалтай омогууд нь янз бурийн тувшигийн хоруу чанартай байгаа нь илэрсэн [239]. Хулгананд судсаар *mycobacteria catalase-peroxidase protein*-ийг (*katG*) тарихад изониазидэд тэсвэртэй *M. tuberculosis* устаж байсан ба сүрьеэгийн савханцраар халдвартлагдсан хулгананд дахин сэргээгдсэн *katG* нь *catalase-peroxidase protein*-ийг идэвхижүүлэн эд эсийн тэсвэртэй байдлыг нь нэмэгдүүлэх нелөө үзүүлж байсан байна [243]. Эдгээр судалгааны дун нь *katG* нь халдвартлагдсан эзэн эд эс доторхи *M. tuberculosis*-ын үргжилт амьдрах чадварыг ихэсгэгдгийг харуулж байна. Өөр нэг туршилт судалгаагаар усан гахайд *katG*-ийн ген байхгүй байхад *M. bovis*-ын омог хоруу чанартгүй байсан бол *katG*-г сэргээжэд удахгүй өндөр хоруу чанартай болж байсан байна [244].


Нью-Йорк хотод үр дүнтэй хэрэгжүүлсэн хэмжилт хяналтаар 1991-1992 1993-1994 онуудад сүрьеэгийн тохиолдлын тоо 19 хувиар буурсан нь тогтоогдсон [245]. Гэвч энэ хугацаанд олон эмэнд дасалтай тохиолдлын тоо 44 %-иар ихэссэн байна (наад зах нь изониазид ба рифамициннд тэсвэртэй байсан). Энэ байдал 1994 он хүртэл үргэлжилсэн [246]. Үүнээс үндэслэн олон эмэнд дасалтай мутант нь илүү халдвартуулах давуу талтай (эмчилгээ байхгүйгээс удаан хугацаанд халдвартараана) ба энэ шалтгаанаас болж хоёрдогч өвчлөлийн үед эмэнд дасалтай мутант харьцангуй их тохиолдоно гэсэн дүгнэлт таамаглалыг хийж болохгүй юм. Олон эмэнд дасалтай омогоор халдвартлагдсан өвчтөнг хэвийн мэдрэг өвчтөнтэй харьцуулвал дунджаар илүү урт хугацаанд халдвартараагч хэвээр үдлдэнэ, яагаад гэвэл хими эмчилгээний үр нелөө халдвартамжуулалтыг хурдан хугацаанд бууруулах боломжгүйтэй холбоотой.

Сүрьеэгийн савханцарын генийн мутац изониазидэд тэсвэртэй байдлыг бий болгохын сацуу түүний хоруу чанарыг бууруулдаг нь амьтад дээр хийсэн судалгаануудаар батлагдсан. Гэвч, янз бурийн мутац нь бие биенээсээ хамааралгүйгээр изониазидэд тэсвэртэй болгодогч [247], үүнээс үндэслэн бүгд


изониазидэл тэсвэртэй омогуудын хору чанар бага байдал гэсэн дүгнэлт хийж болохгүй юм.

M. bovis-ын халдвэр

Зураг 11-т үзүүлснээр хүний сүрьеэгийн халдвар болон мал сүрэг дэх сүрьеэгийн тархалт шууд холбоо хамааралтай болох нь харагдаж байна. Гэвч 1000 тохиолдолд үүсэх хариу урвалын тоо буурахад халдвар авсан мал сүргийн давтамж ихсэх хандлагатай (зураг 65)[50]. Энэ нь *M.bovis*-ын халдвар авсаны дараагаар сүрьеэ өвчинеэр өвчлөх эзэг *M.tuberculosis*-ын халдвартай харьцуулахад хамаагүй доогуур байхыг илтгэж байна. Magnus математикийн загварчлалыг ашиглан [50] үхрийн ба хүний омогийн халдварын дараа үүсэх өвчлөлийн ялгааг тооцоолсон (зураг 66). *M.tuberculosis*-ын халдвар авсаны дараагаар сүрьеэ өвчин үүсэх эзэг нь *M.bovis*-ын халдвартай харьцуулахад 12 тохиолдлын 7-д нь илүүтэйгээр их байна. Дээрхи баримт мэдээнээс үхрийн сүрьеэ нь халдварын тархалтанд хүчтэй нөлөөлөх боловч, *M.tuberculosis*-тэй харьцуулахад халдварын дараах өвчлөлд бага нөлөөтэй болох нь харагдаж байна (Koch хүнд *M.bovis* *M.tuberculosis*-ээс бага ач холбогдолтой гэж дүгнэсэн байсан нь тийм ч буруу зүйл байгаагүй байна).



Зураг 65. Мал сүргийн сурьеэ болон туберкулинд хариу урвал өгж байгаа хүний сурьеэзвчнөөр өвчлөх эзгийн хоорондох шүтэлцээ, Дани улс. ДЭМБ-ийн зөвшөөрөлтэйгээр [50]-аас авч хэвлэв.



Зураг 66. 20-оос 39 настай туберкулины сорилд хариу урвал үзүүлж буй зөвхөн үхрийн эх уурхайгаас халдвар авсан болон аль альнаас нь халдвар авсан хүмүүс, эсвэл зөвхөн хүний эх уурхайгаас халдвар авсан болон холимог бүлгийн өвчлөлийн тооцоо.[50]-аас эх баримтыг авав.

Халдвар давтан авах (re-infection)

1927 онд Норвегид анхны харьцуулах судалгааны нэг болох BCG вакцинаар вакцинжуулагдсан хэсгийг вакцинжуулагдаагүй хэсэгтэй харьцуулсан судалгаа хийгдсэн [248]. Энэ судалгааны явцад ажилд шинээр орохоосоо өмнө туберкулинд ээрэг сорилтой байсан сувилагч оюутнуудад сүрьеэ өвчин үүсэх эгзэг нь анхнаасаа сөрөг урвалтай байсан оюутнуудынхаас бага байсныг тэмдэглэсэн. Үүнээс үндэслэн өмнө авчихсан байсан халдвар нь дахин шинээр халдвар авахад ямар нэгэн хэмжээгээр нөлөөлдөг гэсэн дүгнэлт хийж болно. Гэвч зайлшгүй ийм байх албагүй, өмнө авчихсан байсан халдвар, өвчин болож даамжрахаас урьдчилан яг ямар үед хэн нь өвчнөөс ангил үлдсэнийг бил тогтоож чадахгүй, тийм учраас сүрьеэ өвчнөөр өвчлөхгүй байх нь илүүтэйгээр сайн дархалтай холбоотой байх магадлалтай. Иймээс халдвар давтан авсан тохиолдолд, урьд нь халдвар аваагүй байсантай харьцуулахад, өмнө авчихсан байсан халдвар нь илүү сайн хамгаалах механизмтай байх болно. Яагаад гэвэл анхнаасаа халдвар аваагүй байсан бөгөөд вакцин тариулсан сувилагчидад сүрьеэ өвчин үүсэх эгзэг урьд өмнө халдвар авчихсан байсан сувилагчдынхтай ижил, халдвар аваагүй вакцин хийлгээгүй сувилагч нарынхаас бага байсан байна. Үүнээс үндэслэн урьд өмнө халдвар авсан байх нь үнэн хэрэгтэй дахин халдвар аваахаас ямар нэгэн байдлаар хамгаалдаг гэсэн дүгнэлтийг хийж болно. Энэ дүгнэлт нь дархлал судлалын бүрэн үндэслэлтэй юм. Урьд өмнө нь халдвар авсан байсан хүний дархлалын тогтолцоо савханицын үргжил болон тархалтанд хариу

урвал өгөхөд бэлэн байдаг тул, бэлтгэлгүй эсийн дархалтай харьцуулахад илүү хурдан хариу урвал өгдөг онцлогтой байна.

Тэгэхдээ, давтан халдвэр авахаас хамгаалах хамгаалал нь бүрэн гүйцэд биш юм. Энд үүнийг батлахад хангалттай баталгаа байна. Давтан халдвараас өвчин үүсэх нь тухайн тохиолдлын омогийн мэдрэг байдал болон эмчилэгдэж байсан эсэхээс хамаарахыг тэмдэглэсэн байв. Эдгээр эмчилэгдэж байсан зарим өвчтөнүүдэд тэсвэртэй омгоор үүсгэгдсэн өвчин дахин үүссэн байна [249-253]. Анхны болон хоёрдах сурьеэ өвчиний хооронд омог нь өөр төрлийн батериофаг буюу өөр төрлийн Restriction Fragment Length Polymorphism (RFLP) pattern байдаг байна. Vypnusky болон түүний хамтран ажилласгад нь анхдагч халдвэр давтан халдвэр авахаас хамгаалдгийг математикийн загварт оруулан үнэлгээ өгсөн [258]. Англи болон Уэлсээс мэдээлсэн баримтыг үндэслэн тэд насанд хүрсэн хүмүүсл урлы нь авсан халдвэр нь давтан халдвэр авахаас хамгаалах нь ойролцоогор 40% тай тэнциэнэ гэж таамагласан. Энэ нь хамгаалах түвшин багатайг харуулж (зарим BCG вакцины судалгаан дахь ондөр зэргийн хамгаалах түвшин ажиглагдсантай харьцуулвал) тохиолдлуудын нэлзээд их хувь нь зээн бие дэх сурьеэгийн савханцар нь бүхэлдээ арилж устдаг гэсэн мэдээ баримт дээр үндэслэсэн байж болзошгүй [259]. Анхны халдварын сурьеэгийн савханцар бүрэн гүйцэд арилах хугацаа болон хоёрдах халдварыг авах хүртлих хугацааны зайд ихсэхтэй хамт дархалалын санамж хуучран муудаж болно, үүнтэй ижил загвар удаан хугацааны BCG вакцинжуулалтын судалгааны дунд ажиглагдсан. Энд мөн хугацаа холдох тусам хамгаалах чадвар буурч байсаныг тэмдэглэх хэрэгтэй.

Бичиглэлийн тархвар судлал: өвчлөл

Нийт хүн ам болон хүн амын ялгаатай хэсэг бүлгүүдэд сурьеэ өвчиний шинэ тохиолдлын тоо ялгаатай байдаг. Эдгээр ялгааны ихэнх нь M.tuberculosis-ын халдварын тархалт дотор орших ялгаанаас үүдэлтэй байх магадлалтай. Үүний зэрэгцээ, зарим ялгаа нь халдвэр авсны дараа сурьеэ өвчин үүсэхэд нөлөөлэх хүчин зүйлийн онцлогтой хамааралтай байх магадлалтай боловч, ихэнхи тохиолдолд шинэ тохиолдлын тоог ихэсгэж байгаа гол шалтгааныг олход бэрэхшээлтэй байдаг. Гэсэн хэдий ч, бичиглэлийн тархвар судлал нь тодорхой хэсэг болон бүлэг хүн ам дах онцгой анхаарал татаж буй өвчлөлийн шалтгаанаас хамаарахгүйгээр, үүний эсрэг үйл ажиллагаа төлөвлөхөд тусална.

Аж үйлдвэржсэн орнууд дах чиг хандлага

Аж үйлдвэржсэн орнуудад энэ зууны туршид сурьеэ өвчин хурдацтай буурч ирсэн. Нэгдсэн тайлан бүртгэлийн тогтолцоо АНУ-д 1953 онд шинээр нэвтэрсэн, энэ хугацаанаас эхлэн сурьеэ өвчин тогтмол, зарим жижиг зүйлийг үл тооцвол, 1985 он хүртэл буурч байсан (зураг 67)[260-263]. 1980 онд Энэтхэг Хятадаас олон тооны дүрвэгсэд орлогнол хүсэгчид орж ирсэн нь,


тууштай буурч байсан сурьеэгийн өвчлөлийг зөвхөн тур хугацаагаар зогсоосон юм [264]. 1985 онд жилийн дундаж бууралт 5.7% болж зогссон [265], тэгээд 1986 оноос цаашид зэрэг урвуу байдал ажиглагдсан [266].

1985 онд бага зэрэг өссөн сурьеэгийн тохиолдлын тоо тайлан мэдээгээр 1992 он хүртэл өссөөр байсан, харин 1997 оны дараагаар буурсан [263,267]. Энэ өсөлтөнд ,хэсэгчлэн, ХДХВ-ын халдвартын тархалт, орон гэргүй байдал, хар тамхи хэрэглэгчидийн тоо нэмэгдэх, болон сурьеэ өвчин элбэг улс орноос цагаачдын тоо нэмэгдэх; амьдралын нехшөл мудах болон амаржиж төрөх үед эрүүл мэндийн тусламжийн хомс байдал зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөнтэй хамааралтай гэж үзсэн [268,269]. Нью-Йорк хот дахь сурьеэ өвчиний өсөлт нь онцгой анхаарал татхуйц байсан, 1978 онд зогсонтийг байдалтай байснаа цаашид өсөлт нь тууштайгаар нэмэгдсэн [269]. Энэ өсөлтийг ХДХВ-ын халдвартай холбож ойлгож болохгүй нь ойлгомжтой юм, яагаад гэвэл энэ нь ХДХВ-ын халдвартын үйлчлэл мэдэгдэхүүц болохоос яг өмнө эхэлсэн юм.


АНУ-д 1992 оноос хойш сурьеэгийн тохиолдлын хувийг бууруулж эхэлсэн ганц хүчин зүйл нь бол тохирсон шаардалага хангахуйц сурьеэгийн хяналтыг олсон явдал юм. ХДХВ-ын халдварт, орон гэргүй байх, архи хар тамхи хэтрүүлэн хэрэглэх, цагаачлал, болон бусад хүчин зүйлсийг и зөвхөн зохих ёсоор нь үнэн зөв үнэлээгүй нь 1980-аад онуудын туршид сурьеэ өвчин дахин сэргж гарч ирсэн мэт сэргэгдэл төрүүлж, тулгамдсан асуудал болсон байна.

АНУ-тай төстөй байдал Европын 14 оронд ажиглагдсан, 1974-өөс 1991 он хүртэл сурьеэгийн тохиолдлын тоо (оловсруулаагүй баримт) нийтдээ буурч, жилийн дундаж бууралт 5.4% байсан (зураг 68)[270]. Эдгээр 14 орны бараг бүглэд нь ажиглалт хийсэн нийт хугацаанд энэ судалгааны төгсгөлд, сурьеэ өвчин буурсан (зураг 69). Гэхдээ бууралтын түвшин нь улс орон бүрт өөр байсан. Гол төлөв, эхний эхлэл түвшин нь өндөр байсан орнуудад сурьеэ өвчиний бууралт, эхлэл түвшин нь бага байсан оронтой харьцуулахад илүү хурдтай байсан байжээ. Зураг 69-д тайлан мэдээ өгөлт мөн тогтмол биш байсныг харуулж байна. Ялангуяа 2 оронд, тийм учраас мэдээлэгдсэн баримтыг тайлбарлан судлахдаа онцгой анхаарал болгоомжтой байх хэрэгтэй. Ямар нэгэн орны мэдээлэгдсэн баримтын цар хүрээ нь ажиглалт эхлэх үед өргөн байсан бол (1974 онд 100.000 хүн амд 7.8 байснаа 76.3 болох, бараг 10 дахин ялгаатай байна) хугацааны төгсгөлд энэ нь их бага болсон байв (1990 онд 100.000 хүн амд 6.6 байснаа 19.7 болох, гурав дахин ялгаатай байна). Эдгээр Европын орнуудаас мэдээлэгдсэн тоо баримтанд сурьеэ өвчиний өвчлөлийн түвшин ойрын жилүүдэд нь мэдэгдэхүйцээр буураагүй ба зарим нэгд нь өссөн байдал ажиглагдсан.


Härd, Финланди улсын сурьеэ өвчиний тоо баримтуудад дэлгэрэнгүй дун шинжилгээ хийж, сурьеэ өвчин нь цаг хугацаа өнгөрөхөд яаж өсөх талаар таамаглалыг дэвшүүлсэн [9,271]. Сурьеэ өвчиний эпидеми давшин дэвжихийг заагч нэг шинж нь бол өвчлөх хумүүсийн насын бүтлийн өөрчлөлт юм. Härd-д сурьеэ өвчиний тохиолдлыг насанд нь тохируулан median насыг тооцоолон гаргасан (зураг 3)[9,271]. Дундажаар 1975 он хүртэл эмэгтэй өвчтөнүүдийн




Зураг 67. АНУ-д бүртгэгдсэн сүрьеэз өвчний тохиолдлууд, 1953-1997. [260],[261],[262,263]ээс эх баримтуудыг ашиглав.



Зураг 68. Баруун Европын 14 улс орнуудаас мэдээлсэн сүрьеэз өвчний хандлага нийлмэл байдлаар, 1974-1991. Эх баримтыг [270]-аас ДЭМБ-ын зөвшөөрөлтэй авав.



Зураг 69. Баруун Европын 14 улс орнуудаас мэдээлсэн сүрьеэ өвчний хандлага, 1974-1991. [270]-аас эх баримтыг авав.



Зураг 70. Финландийн эрэгтэйчүүдийн насаар гаргасан сүрьеэ өвчний түвшин. Хөндлөн-зүсэлт судалгааны арга 1954-аас 1989 онууд. [271]-ээс баримтыг авав.

нас голшуу эрэгтэйгээсээ залуу байх хандлагатай байсан ба эрэгтэйчүүдийн дундач нас эмэгтэй өвчтөнгүүдийнхээс бага байв. Насыг meap-д шилжүүлэх нь магадгүй илүү сайн хэмжилт болж болох юм. Median нас нь ихэвчлэн ахмад настай бүлгийг тусгаж нийгэм дэх тулгамдсан асуудлыг багасгана [272]. Энэ нь сурьеэгийн савханцарын халдварт дамжих тархах явдал буурахыг илтгэнэ, харин энэ нь өсөж нэмэгдэвэл, шинэ өвчлөл нь олон жилийн өмнө халдварт авсан байсан хүмүүсээс үүсэн гарна гэлгийг заана. Шилжүүлэлт нь халдварт авах эгзэг өндөр байгаа үед когорт халдвартыг багасгасаар багасгасаар когорт төрөлтийг амжилттай шилжүүлэн байрлуулна гэдгийг илтгэнэ.

Хөндлөн-зүсэлт мэдээлэл нь ашигтай боловч удаа дараалсан когортод далд нуугдмал чиг хандлагатай байдаг. 1930 онд Andvord үе удам дотор нь сурьеэгийн судалгаа хийх санал гаргасан, ө.х. энэ нь төрөхийн когортыг хөгжүүлнэ [273-275]. Үүний талаар Frost-ын нийтэлсэн [276], когорт төрөлтийн дун шинжилгээ нь тархвар судлаачийн анхаарлыг татах болно [277].

Жилийн тайлан мэдээний тогтолцоогоор насаар өвчлөлийн зурагийг гаргаж болохуйц мэдээ цуглардаг. Ялгаатай насын бүлэгт байгаа өвчиний тохиолдлууд нь өөр өөр хуванлижилд төрсөн хүмүүс дунд оршино гэж мөн тооцогдоно (ө.х. хүмүүс өөр өөр когорт төрөлтөнд харьяалагдана гэсэн уг). Хэрэв хөндлөн-зүсэлт судалгаар насаар ялгах боломжтой бол, ө.х. хэрэв хөндлөн-зүсэлт судалгаа нь жишээ нь 10 жил бүр хийгдэх боломжтой байж, мөн судалгаа бурийн хугацаанд хэсэг бурийн насыг 10 жилийн хэсэгт мэдэх боломжтой байвал, когорт төрөлтийн жил бүрт өвчлөлийн тохиолдлыг тогтоож болно.


Жишээ нь, 1975, 1985 болон 1995 зэрэг онуудад шинээр өвчилсөн хүмүүсийн талаар мэдээлэлтэй байж тэдний дундаж нас нь 5жил (0-оос 9 жил нас), 15 жил, 25 жил г.м. байвал тандалт судалгааг хийх боломжтой. Энэ жишээгээр дундаж нас нь 25 жил хүнийг 1995 онд харьялуулбал когорт төрөх жил нь 1970 он болно, 1985 онд хийсэн тандалтаар, 1970 оны когорт төрөлт нь 15 настай байна, 1975 оны тандалтаар энэ нь 5 настай байна. Насны үр нөлөөний мэдээлэл дээр нэмж дээрхи дүн шинжилгээ нь одоо мөн когорт төрөлтийн үр нөлөөний талаархи мэдээллийг өгдөг. Энэ нь өвчлөлийг удаа дараалсан когорт төрөлтөнд шинжлэх боломжийг олгоно (дээрхи жишээнд халдварт эсвэл нас барагт тэнциүү ижил байдлаар хамааралтай). Хэрэв мэдээллийг хангальгайгаар олох боломжтой бол гурав дах хэсгийг нь шалган тогтоож болно. Нас ба когорт төрөлтийн үр нөлөө нь өвчлөл, тодорхой хугацааны заагт, жишээлбэл, дайн дажингийн үед өөрийн араас өвчлөлийн эзгийг онцгой өндөр болгож болно.

Hägö амьсгалын эрхтэний сурьеэгийн өвчлөлийг хөндлөн-зүсэлт аргаар ба когорт төрөлт дунд дүгнэн шинжилсэн [9,271]. Хөндлөн-зүсэлт ажиглалтанд, насын онцлогтой мэдээллийн хувь, сүүлийн жилүүдэд нь илүүтэйгүүр өссөн байна, энэ өсөлтийн оргил нь ахмад насыныхын бүлэгт байсан. Үүний талаар зураг 70-д эрэгтэйчүүдийн дундах жишээн дээр харуулжээ. Яагаад гэвэл насын-хамааралт мэдээллийн хувь болон мэдээлэгдсэн жилүүд нь давхцан зэрэгцэж чадна (5 жилээр хэсэг бүлэгт хуваасан), энэ нь насын-хамааралт мэдээллийн хувийг когорт төрөлт дотор


дүгнэж дүн шинжилгээ хийх бололцоотой болгосон (зураг 71). Когорт төрөлтийн удаа дараалсан судалгаанд амьсгалын эрхтэний сурьеэз өвчин залуу насанд хүрэгчид дунд хамгийн их байсан. Эдгээр байдал сурьеэгийн өвчлөл буурч байхад илэрч болно. Хөндлөн-зүсэлт ажиглалтын оргил нь настайчууд дунд зөвхөн үлдсэн нь өндөр өвчлөлтэй когорт тэднийг залуу байхад байсныг илтгэнэ. Үүнтэй ижил дүр зураг Нью-Йорк хотын байдлаас харагдсан (зураг 72)[278].

Газар зүйн онцлог ба өвчлөлийн давтамж


Сурьеэгийн шинэ өвчлөлийг олон улсын хооронд харьцуулахад бэрхшээлтэй. Яагаад гэвэл шинэ тохиолдлын тодорхойлтонд [279,280], мэдээлэх шалгуур [281] болон мэдээлэх журам ялгаатай байдал. Чухал ач холбогдолтой бэрхшээлийн харилцан уялдаатай ялгааг харьцуулах ганц шинжийг Канад болон АНУ шиг цагаач ихтэй улс орноос олж авч болно. Дэлхий дээрхи ялгаатай орон нутаг, ялгаатай хэсэг хүмүүсийн доторхи сурьеэгийн тохиолдлын түвшинг, нэг янзын тохиолдлын тодорхойлтонд үндэслэн гаргаж байж харьцуулах боломжтой болно. Enarson мэдээлэгдсэн өвчлөлийн түвшинг, Канад улсын янз бүрийн хэсэг хүн ам дотор шалгаж үзсэн, ингэхэд Канад улсад төрсөн болон галаад өөр оронд төрсөн өвчтөнүүдийн хооронд их том ялгаа байгаа нь илэрсэн (зураг 73)[283]. Өндөр



Зураг 71. Финландийн эрэгтэйчүүдийн дунд бүртгэгдсэн насавар ангилсан сурьеэз өвчний хувь. Хөндлөн-зүсэлт ажиглалт (цэгчилсэн болон дугуйтай шугам) 1954-өөс 1984 онуудад хийгдсэн ба когорт төрөлт нь (тод шугам) 1892-оос 1972 онуудад тохирно. [271]-ээс баримтыг авав.



Зураг 72. АНУ-ын эмэгтэйчүүдийн дунд бүртгэгдсэн насаар ангилсан сүрьеэз өвчний хувь. Хөндлөн-зүсэлт ажиглалт (цэгчилсэн болон дугуйтай шугам) 1940-аас 1944 болон 1970-аас 1974 онуудад хийж дүгнэсэн ба когорт төрөлт нь (тод шугам) 1900-аас 1950 онуудад тохирно. [278]-аас American Journal of Epidemiology-ийн зөвшөөрөлтэй баримтыг авав.



Зураг 73. Канадад-төрсөн болон гадаадад-төрсөн сүрьеэтэй өвчтөнүүдийг харьцуулсан сүрьеэз өвчний харьцангуй эзэг. [283]-аас баримтыг авав.

(Филиппинчүүд) ба бага (Дани, Бельги, Люксэмбург) эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн эрсдэлийн тооны харьцаа нь 30 дахин их байсан.

АНУ-д хийсэн судалгаагаараа McKenna дээрхитэй ижил үр дүнг мэдээлжээ, түүнийхээр сурьеэз өвчний тохиолдлын тэгш бус тархалт нь мөн төрсөн газрынхаа өвчлөлийн түвшингээс хамаарч байжээ (зураг 74)[284].


Асар их ялгаатайг нь ул харгалзан, Murray [285], Sudre [286,287], Raviglione [288], болон Dolin [289,290] нар бусад судлаачдын хамтаар шинэ тохиолдлын тоог нийт дэлхийн түвшинд таамаглан тооцоолж гаргахыг хичээсэн. Мэдээлэгдсэн баримтуудын ихэнхи нь чанартгүй байсныг харгалзан үзвэл, үүнийг хийх тийм ч амар биш байсан байна. Dolin болон бусад судлаачдынхаар нарийвчлан үзэж болох тооцоог энд харуулсан байна (зураг 75)[289]. Энэ зургаас харахад жилийн нийт өвчний тохиолдлын хамгийн их хувь нь, бараг тал хувь нь Зүүн Өмнөд Азиас үүсэл гаралтай байна. Гэхдээ шинэ тохиолдлын хувийг нь тооцоолоход Африкт хамгийн өндөр байж, аж үйлдвэржсэн хөгжилтэй орнуудад хамгийн бага байна. Шинэ тохиолдлын хоёр түйл хоорондоо 10 дахин ялгаатай байна.

Sudre [286,287] болон Dolin [289,290] болон бусад судлаачдын тооцоолсноор 1990 оны эхэн үеийн байдлаар жилд дунджаар 7,5аас-8 сая сурьеэгийн шинэ тохиолдол үүсэн гарах болно гэжээ.


Нийгэм дэх өвчлөлийн давтамжийн ялгаа

Nac


Нийгэм дэх насны бүлгүүдийг хооронд нь харьцуулан үзэхэд өвчний давтамжийн ялгаа нүдэнд үзэгдэхүйц тод байдаг. Цаашилбал, нэг улс орон



Зураг 74. АНУ-ын гадаадад-төрсөн сурьеэгийн өвчлөлийн шинэ тохиолдлын хувь.[284]-өөс баримтыг авав.



Зураг 75. Дэлхий дээрхи сурьеэгийн шинэ тохиолдлын тооцоо, 1995 оны байдлаар. [289]-ээс эх баримтыг авч хэвлэв.



Зураг 76. Норвеги улсын халдвартай хэлбэрийн сурьеэ өвчинтэй эмэгтэйчүүдийн насаар гаргасан өвчлөлийн түвшин, 1946 ба 1972 онууд. [291]-ээс European Respiratory Society Journal-ын зөвшөөрөлтэйгээр авав.

дотор сурьеэгийн шинэ тохиолдлын тоо насаар ялгаатай байх ба улс орон хооронд харьцуулахад ижил байж болно.


Дээр өгүүлсний дагуу, сурьеэгийн халдварт түвштай хурдан буурч байгаа улс оронд сурьеэтэй өвчтөний median нас нэмэгдэж, халдварт авсан байсан хүн амын хэсэг нь настайчуудын хэсэг рүү шилжиж байна [271]. Норвеги улсын Бжартвейтын халдвартай хэлбэрийн сурьеэтэй эмэгтэйчүүдийн насаар гаргасан өвчлөлийн түвшинг харьцуулан үзэхэд 1946 онд насандаа хүрсэн эмэгтэйчүүд хамгийн өндөр эзэгтэй байсан бол 1972 онд энэ нь бүрэн гүйцэд алга болсон байна (зураг 72)[291]. 1972 онд бүртгэгдсэн сурьеэгийн түвшинг 1946 оныхтой харьцуулахад маш бага байсан ба хүн амын настайчуудийн булэгт хамгийн өндөр түвшин нь илэрчээ.

Үүний эсрэгээр орчин үед ч буурай хөгжилтэй орнуудад сурьеэгийн бүртгэгдсэн өвчлөлийг түвшингийн оргил нь залуу насандаа хүрэгчид дунд байдаг. Үүнийг Сенегалын жишээнээс харж болно (зураг 77)[292].


Xүйс

Бараг бүгд улс оронд бүртгэгдсэн өвчлөлийн түвшин эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдийнхээсээ өндөр байдаг [293]. Өвчний бүртгэл мэдээлэл олон бүрэлдэхүүн хэсгийг нэгтгэсэн олон шатны үйл ажиллагааны үр дүн юм. Халдвартын тархалт, тухайн халдвараас өвчин үүсэх эзэг, өвчтөн оношлогдох болон эруул мэндийн байгууллагад мэдээлэгдэх журам орно. Насанд хүрэгчдийн дунд насын-хамааралтай халдвартын тархалт эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс илүү их тохиолдлог талаар өмнө өгүүлсэн (зураг 29-30), гэхдээ түвшин нь нөхцөл байдалас хамаарна. Халдварт даамжран өвчин болох эзэг нь мөн хүйсний ялгаатай ба нас бүртээ өөр байна. Хүйсний ялгааг ирээдүйд ажиглалтгаар ялгах төвөгтэй байх болно. Сурьеэз өвчтэй эрэгтэй болон эмэгтэй өвчтөнийг оношлож бүртгэх үйл ажиллагаанаас хамаарах тул үнэн зөв тархвар судлалын онцлогийг илрүүлэхэд хэцүү болно. Эмэгтэй болон эрэгтэй хүмүүс ижил түвшинд эмнэлгийн үйлчилгээ авдаг улс оронд тархвар судлалын бүрэлдхүүн хэсгийн нэг болох энэ үзүүлэлтийг тодорхойлох нь арай хялбар юм. Аж үйлдвэржсэн улс орнуудад сурьеэгийн шинэ тохиолдлын хоёрыг харьцах-нэг эрэгтэй-харьцах нь-эмэгтэй гэсэн хүйсний тооны харьцаа ажиглагддаг, жишээ нь АНУ-д [294], халдвартын тархалт эрэгтэйчүүд дунд илүүтэйгээр илэрсэн байна [295].

Сурьеэгийн тархалт өөрчлөгддэх, насын бүтэц өөрчлөгдхөхтэй холбоотойгоор эрэгтэй-харьцуулах нь-эмэгтэй гэсэн харьцаа мөн өөрчлөгддэх нэг улс орон дотор хэсэг хүн ам дотроо ялгаатай байж болно [102]. Үүнийг Дани улсад ажиглагдсан жишээнээс харч болно [102]. Копенгаген хотод 1920 оноос 1960 он хүртэл эрэгтэйчүүдийн дунд сурьеэгийн тохиолдлын түвшин тогтмол өндөр байсан, Дани улсын бусад муж нутагт энэ хугацаанд эсрэг харьцаа ажиглагдсан байна (зураг 78,79). Копенгагенаас бусад муж нутагт нь 1940 оны дунд хүртэл эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдийнхээс бага тархалттай байгаа нь тогтмол ажиглагдсан байна. Зөвхөн энэ хугацааны дараагаас эзэг нь ижил болж ирсэн бөгөөд ажиглалт хийсэн хугацааны төгсгөлд л эрэгтэйчүүдэд илүү өндөр эзэг үнэн хэрэгтээ ажиглагдах болжээ. Үүнээс үндэслэн сурьеэгийн халдвартын тархалт нь ерөнхийдөө эмэгтэй болон эрэгтэй



Зураг 77. Эмэгтэй ба эрэгтэй евчтөнүүдийн цэрний түрхэц-зөрэг сүрьеэгийн тохиолдлын насны-хамааралтай мэдээлэгдсэн түвшин, Сенегал, 1997 он. Эрэгтэйчүүдийн түвшинг илтгэх шугаман дээрхи тоо нь эрэгтэйчүүдийн насны-хамааралт евчлөлийг эмэгтэйчүүдийнхэд харьцуулсан харьцангуй эгзэг юм. [292]-оос зургийг авав.



Зураг 78. Дани улсын Копенгаген болон бусад бусүүд бүртгэгдсэн ушигны сүрьеэз евчиний шинэ тохиолдлын тоо, эмэгтэйчүүд (дугуйтай шугам) болон эрэгтэйчүүдийн (тэмдэггүй шугам) дунд, 1921–1957 онуудад. [102]-оос ДЭМБ-ын зөвшөөрөлтэй авав.

хүмүүсд ижил гэж бодож болно (зураг 29). Тэгэхдээ энэ зууны эхэн үед залуу эмэгтэйчүүдэл өвчин илэвхжин үүсэх эгзэг илүү өндөр байжээ. Тархвар зүйн нөхцөл байдал сайжрахтай хамтаар сурьеэгээр өвчлөх хүмүүсийн нас ахисан үед, халдварт даамжран өвчин болж идэвхижих эгзэг өөрчлөгдж, эрэгтэйчүүдэл илүү их болсон байна.

Нийгэм эдийн засгийн байдал

Ядуурал нь сурьеэгийн өвчлөлтэй шууд хамааралтай [296,297]. Дээрхи дүгнэлт нь экологийн судалгааны дунд бус мужийн тоо бүртгэл [296] эсвэл шуудангийн шифрыг [297] дүгнэлтийн нэгжээ болгосонд үндэслэгдсэн боловч энэ холбоонд итгэх ач холбогдол бүхий хүчтэй харьцаа хамаарал байна. АНУ-ын Upstate-д хийсэн судалгааны жишэнээс харахад хэд хэдэн өөр судалгааны дунд ижил зүйлийг олж тогтоожээ (зураг 80)[278]. Kuemmetereg ба Comstock-ийн тэмдэглэснээр [112], энэ тоо үзэгдэл нь наад зах нь хэсэгхэн булэгт сурьеэгийн халдвартын тархалтын анхаарал татахуйц ялгаатай байдлаас үүдэлтэй байна. Хэт олуулаа беөгнөрөн амьдардагаас сурьеэгийн савханцарыг дамжуулан халдвартуулах нөхцөл нэмэгдэж өвчний шинэ тохиолдолыг бий болгоно. Шинэ тохиолдлын тоо нэмэгдэснээр сурьеэгийн халдвартын тархалт энэ тувшинд гол төлөв тогтмол өндөр байх болно. Ядуурал, эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэх боломжийг мөн л буруулж [298] халдварт ялгаруулж байгаа өвчтөний халдвартараах хугацааг уртасгаж, түүний хавьтлуудыг халдварт авах эгзийг нэмэгдүүлэх болно.


Арьсны өнгө болон гарал угсаа

АНУ-д арьсны өнгө гарал угсаанаас хамаарч үүсэх эгзийн ялгааг судлах судалгааг хэсэгчилэн явуулжээ. Испани-биш цагаан арьстануудтай бусад арьсны өнгөтэй хүмүүсийн доторхи сурьеэгийн тохиолдлыг харьцуулахад, бусад арьсны өнгөтэй хүмүүс илүү өндөр өвчлөлтэй байсныг тэмдэглэжээ. Цагаан арьстай болон цагаан бус арьстай хүн амын дундах өвчлөлийн тэгш бус байдал, жил улирах тутам есөж байгаа бөгөөд энэ нь сурьеэгийн тархвар судлалд ХДХВ-ын халдвартын нөлөө эхлэхээс өмнө аль эрт тогтоогдсон байна (зураг 81). АНУ-д сурьеэгийн өвчлөлийн буураалт нь 5aас 14 наасны бүлгийнхэнд хамгийн их, мөн ихэнх наасны бүлгүүдэд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийнхээс их, цагаан арьстангуудад бусад насандаа хүрэгчдийнхээс их байсан байна (зураг 82)[266]. Гэсэн хэдий ч энэ баримт мэдээг шалтгаантай нь холбож тайлбарлах хэрэгтэй, яагаад гэвэл наад зах нь цагаан биш арьстай хүмүүсийн доторхи өвчлөлийн өсөлтийг Азиас цагаачлан ирж байгаа олон тооны цагаачдын тоо төөрөгдүүлж байж болно.

Хүүхдийн сурьеэ өвчин илэрч мэдэгдэх нь месөн уулын үзүүр орой мэт, нийт өвчтэй хүүхдүүдийн дөнгөж хэсэгхэн нь мэдэгдэж байгаагийн илрэл юм, бусад хүүхдүүд нь өвчиний хэд хэдэн шинж тэмдэгтэй байх боловч сурьеэ өвчин гэж илрэхгүй мэдэгдэхгүй явах болно. Хүүхдийн сурьеэгийн шинж тэмдэгтүй хэлбэр нь ирээдүйд илрэх сурьеэ өвчний тохиолдууд юм.



Зураг 79. Хүйсээр эр:эм харьцаа, Дани улс, Копенгаген хот болон Дани улсын бусад муж орон нутаг, 1921–1957 онууд. [102]-оос эх баримтыг авч ашиглав.




Зураг 80. Нийгэм эдийн засгийн давхаргаас хамаарч үүсэн сүрьеээ өвчний шинэтохиолдлын хувь, Нью-Йорк Upstate, 1973 он. [278]-аас American Journal of Epidemiology- ийн зөвшөөрөлтэй эх баримтыг авав.

АНУ-ын залуу насанд хүрэгчдийн дунд сүрьеэ өвчиний өвчлөл нэмэгдэх нь цаашдын тархвар зүйн байдалд хүчтэй нөлөөлөл үзүүлэх магадлалтай байна. Хүүхдийн сүрьеэ илрэх нь *M.tuberculosis*-ын халдвартыг саяхан авсан байгааг илтгэнэ, мөн энэ нь нийгмийн Эрүүл Мэндийн тогтолцоо нь эпидемийг бууруулахад хүрэлцэхүйцээр ажиллаж чадахгүй байгааг илтгэнэ [299]. 1992 онд АНУ-ын хүүхдүүдийн дундах сүрьеэгийн өвчлөл 1987-1990 онуудынхаас 1/3 дахин нэмэгдсэн байсныг мэдээлсэн [300]. Арьсны өнгөний ялгаанд дун шинжилгээ хийж үзвэл, цагаан (испани цагаан арьстнуудыг хамруулан) ба хар арьстани өвчлөлийн түвшингийн бууралт 1989 он хүртэл бараг ижил байжээ. Харин 1992 он хүртэл энэ түвшин хар арьстнуудын дунд ямар нэгэн өөрчлөлтүй байхад цагаан арьстнуудын дунд огшом нэмэгдсэн байна (зураг 83)[260,261]. Энэ нь АНУ-д уссэн халдвэр хэт их тархах аюултай байдал нь насанд хүрч байгаа цагаан арьстай хүүхдүүдэд нөлөөлсөн шигээ хүчтэй нөлөөлөөгүйг илтгэж байна.


Цагаачлал

АНУ-ын Зүүн Өмнөд Азийн дүрвэгсэл болон цагаачдын дундах шинэ өвчлөл өндөр байгааг нь тайлбарлаж болно [264,301]. Сүрьеэгийн халдвэр авах эгзэг өндөр өөрийн төрсөн нутагтаа тэл халдвэр авч [120], эдгээр нь цашид өвчиний тохиолдол болон гарч байгаа юм.


Сүрьеэгийн өвчлөл өндөр улс орноос өвчлөл bagatai улс оронтуу цагаачлан гарах явдал дэлхий даяар ихэссээр байна.



Зураг 81. Цагаан-цагаан бус арьсны өнгөтэй хүмүүсийн сүрьеэгийн тохиолдлын бүртгэгдсэн түвшин, АНУ, 1953-1987 онууд. [266]-аас American Medical Association-ны зөвлөөрөлтэйгээр эх баримтыг авав.



Зураг 82. Нас, хүйс, болон арьсны өнгөнөөс хамаарсан сүрьеэгийн өвчлөлийн жилийн дундаж бууралтын хувь, АНУ, 1963–1984 онууд. [266]-аас American Medical Association-ны зөвшөөрөлтэйгээр эх баримтыг авч хэвлэв.




Зураг 83. Цагаан ба хар арьстай хүүхдүүд дунд илрэх сүрьеэгийн тохиолдлын түвшин, АНУ, 1981–1992 онууд. [260,261]-ээс эх баримтыг авч хэвлэв.

Энэ нь хэд хэдэн аж үйлдвэржсэн улс орны сүрьеэгийн өвчлөлийг нэмэгдүүлж өсгөх үйлчилгээ үзүүлсэн, үүнийг Швед улсын жишээ нь дээр харж болно (зураг 84, Шведийн Institute of Infectious Disease Control-ийн Victoria Romanus-ын баримтыг, түүний зөвшөөрөлтэйгээр авав. 1997 оны 2-р сарын 4)[282]. Ажиглалт хийсэн хугацаанд Шведид-төрсөн хүн ам дахь өвчлөлийн тоо 1984-өөс 1993 онуудад тайлангаар тогтмол буурч байсан бол, зөвхөн 1995 онд бага зэрэг өссөн, харин гадаадад-төрсөн хүн амаас сүрьеэгээр өвчлөх тохиолдлын тоо хурдан ихэссэн. Үүний үр дүнд, нийт тохиолдлын тоо сүүлийн хэдэн жилийн тогтвортой нэг түвшинд байна. Үүнтэй ижил ажиглалтууд Европын бусад орнуудад хийгдсэн [302]. Сүрьеэ өвчинийг хянах тандах Европын төслийн хүрээнд, ДЭМБ-ын Европын бүсийн нийт 13 улс оронд бүртгэгдсэн 100-аас их сүрьеэгийн тохиолдлын талаар мэдээлж тэдгээр сүрьеэтэй өвчтөнийхөө төрсөн улс орны талаархи мэдээгээр баяжуулсан[282].


Улс орны үндсэн хүн ам дахь болон цагаачдын дундах сүрьеэгийн давтан эмчлэглэж байгаа тохиолдуул туйлын ба харынгуйгаар нэмэгдэж байгаа нь илт мэдэгдэж эхэлсэн. Гадаад-төрөгсөд болон уг улс орны үндсэн хүн ам дахь сүрьеэгийн тархвар зүйн давтамжинд сүрхий их ялгаа байна (зураг 86)[303].

Зураг 85-д 1996 оны байдлаар гадаадад-төрсөн сүрьеэ өвчиний тохиолдол тухайн орны өвчлөлд хэдэн хувийг эзэлж байгааг харуулсан байна, Чех улсад энэ хувь 0 байхад Израильд 83% -ийг эзэлсэн байна.

Уг улс орны үндсэн хүн ам дахь настайчуудад сүрьеэгийн шинэ өвчлөл их байхад, гадаадад-төрөгсдөд сүрьеэгийн тохиолдлын түвшин нь залуу



Зураг 84. 1984–1995 онуудад Швед улсад ба гадаадад төрснөөр нь ялгасан сүрьеэ өвчиний тохиолдол. [282]-оос Шведийн Institute of Infectious Disease Control-ийн Victoria Romanus-ын эх баримтыг, түүний зөвшөөрөлтэйгээр хэвлэв.



Зураг 85. ДЭМБ-ын Европын бүсийн 13 орон дах гадаадад-төрсөн сүрьеэс өвчний тохиолдол тухайн орны өвчлөлд хэдэн хувийг эзэлж байгааг харуулсан харьцаа, 1996. [282]-оос эх баримтыг ашиглав.




Зураг 86. 5-жил насны бүлэгт, Швейцар улсад болон гадаадад-төрсөн өвчтөнүүдийн тохиолдлын тоо, Швейцар улс, 1990. [303]-aac Swiss Federal Office of Public Health-ийн зөвшөөрөлтэй авав.

насныханд хамгийн их байна. Энэ нь тэдний төрсөн нутгийн нөхцөл байдалын тусгал болно.

Гадаадад-төрсөн хүн амын дундах сурьеэ өвчин уг үндсэн хүн амын тархвар зүйд мэдэгдэхүйцээр нөлөөлнө гэсэн цөөн хэдэн нотолгоо байна [304]. Гэвч энэ нөлөөлөл нь харьцангуй бага байна. Энэ нөлөөллийн үр дүнд сурьеэгийн өвчлөлийн хандлага нь, ихэнхи аж үйлдвэржсэн орны суурь хүн амд өвчний эсрэг чиглэсэн байсан. Монреаль хотод хийгдсэн нэгэн судалгаагаар Канадад-төрсөн сургуулийн сурагчдын дундах *M.tuberculosis*-ын халдвартын тархалт нь гадаад цагаачдын амьдардаг бусуудийн халдвартын тархалтаас ялгарахгүй байсан байна [305]. Цашилбал, АНУ-д, дэлхий дээр хамгийн их олон үндэстэн амьдардаг орны тоонд ордог, сурьеэгийн тархвар зүй дийлэнхи хүн амд болон янз бүрийн арьсны өнгөтэй хүмүүс, үндэстэн ястанд удаан хугацааны явцад маш ихээр ялгаатай байсаар байна [266]. Энэ нь ямар нэгэн хэсэг хүн ам дотор сурьеэгийн шинэ тохиолдол их байх нь бусдал зайлшгүй нөлөөлөхгүй байж болно гэсэн таамаглалыг төрүүлж байна. Их олон тооны ойрын болон бусад хавьтлын судалгаагаар нь сурьеэ өвчин нь тийм ч амархан дамжин халдвартладагтүй нь тод илрхий болсон. Мөн тэд мэдэгдээгүй халдвартын эх уурхайтай их ойрхон, халдварт авах өндөр эгзэгтэйгээр амьдарч байсныг судалгаануудад харуулсан [29-31]. Цагаачид, улс төрийн орогнол хүсэгчид, болон гадаад ажилчид тухайн орны үндсэн хүн амаас тэдний ажил хувийн амьдралаас нь ихэнхдээ салангид тусдаа байдаг. Зонхилох тохиолдолуудад тэд беөгнөрч чихшэлдсэн нөхцөлд амьдрах болдог учраас сурьеэгийн савханцарыг дамжин халдвартлах нөхцлийг бурдуулсанэ. Мөн эдгээр хүмүүсийн эруул мэндийн үйлчилгээ авахад ихээхэн саад бартаа байх ба энэ нь халдвартай хэлбэрийн сурьеэгийн оношлогоо хэтэрхий хожимдоход хүргэнэ.

Гадаадад-төрсөн хүн сурьеэгийн өвчлөл багатай улс оронд удаан хугацаагаар амьдрахад, цаг хугацаа өнгөрөх тутам сурьеэ өвчинеөр өвчлөх эгзэг багасна. Энэ нь Их Британий судалгаанаас харагдаж байна [306]. Их Британд цагаачлан орж ирээд 20-оос дээш жил амьдарч дахин хэзээ ч Ази руу яваагүй Ази хүмүүс дотор, Их Британд орж ирээд удаагүй байхад нь өвчин илэрсэн тохиолдлын тоо хамгийн их байжээ (зураг 87). Азид дахин очсон хүмүүсд сурьеэ өвчиний тархалт нэгэн жигд тогтвортой байв, харин Их Британд дахин орж ирсэн цагаачдын өвчлөлд дүн шинжилгээ хийж үзвэл, сурьеэ өвчиний тархалт нь хэзээ ч дахин Азид очоогүй хүмүүсийнхтэй ижил байв. Энэ дүн шинжилгээ нь хүрээлэн буй орчны халдвартын эгзэг нь багаас их рүү (мөн үүний эсрэгээр) шилжиж солигдох нь хэр ач холбогдолтойг харуулж байна, саяхан авсан халдварт эх нутагтадаа байсан хугацаа мөн их үүрэгтэй болохыг тогтоосон.

Өвчлөл өндөр орноос багатай орон руу цагаачлан ирэх үед нь л сурьеэ өвчинеөр өвчлөх эгзэг өндөр байдаг ч, энэ эгзэг тухайн үндсэн хүн амтай харьцуулахад удаан хугацааны турши ихэвчлэн өндөр хэвээр үлддэг байна [284, 306, 307]. Цагаачилсан хүн амд сурьеэгийн савханцарын урьд өмнө



Зураг 87. Их Британд цагаачлан орж ирээд хэзээ ч Ази руу явваагүй Ази хүмүүс болон Азиid дахин очсон хүмүүсийн дотор Лондонд бүртгэгдсэн сурьеэз. [306]-аас баримтыг авав.


нь авсан халдвартын тархалт өндөр байх нь мэдээж юм, энэ нь мөн давтан вакцинжуулалтын үр дүнтэй холбоотой байна.

Хүн амын нягтрал

Халдвартын тархалт насын-хамааралтай байдагтай адилгаар хот суурин газар болон хөдөө орон нутагийн халдвартын тархалтыг харьцуулвал хөдөө орон нутагт халдвартын тархалт бага байна, үүнээс үүдэлтэй сурьеэгийн шинэ өвчлөл мөн бага байна. Дани улсал явуулсан хоёр судалгаанд энэ талаар харуулсан байв [308,309]. Эхний 1950-1952 онуудад хийгдсэн, нэг хотын том дүүрэгтэй хөдөө орон нутгийн жижиг хотуудыг харьцуулсан судалгаагаар, хөдөө орон нутгийн жижиг хотуудад дах өвчлөлийн түвшин шинжлэгдсэн бүх насанд тогтвортой бага байсан юм (зураг 88)[308]. 1960-1968 онуудад хийгдсэн хоёр дах судалгаагаар нийслэл Копенгагений халдвартын тархалтыг хөдөөний дүүргүүдтэй харьцуулсан, тэгэхэд дээрхи ялгаа хэвээрээ үлсэн байв (зураг 89)[309].

Гэрлэлтийн байдал

Копенгаген хотод хийсэн судалгаагаар, өвчлөлийн давтамжинд гэрлэлтийн байдлаас хамаарч их чухал ялгаа байдгийг тогтоосон (зураг 90)[309,310]. Эхнэрээсээ салсан эрэгтэйчүүдийн дунд ушигны сурьеэгийн шинэ өвчлөл, гэр бүлтэй эрчүүдийнхээс их байсан. Ганц бие болон бэлэвсэн эрчүүд дээрхи хоёрын дундажтай тэнцэжүйч өвчлөлтэй байжээ. Дээрхи байдал



Зураг 88. Хөдөө орон нутгийн уушигны сурьеэтэй эрэгтэйчүүдийн шинэ өвчлелийг хотын дүүргийнхтэй харьцуулсан байдал, Дани улс, 1950–1952 он. [308]-вас эх баримтыг авав.


нь магадгүй эрэгтэйчүүдийн гэрлэлтийн байдалд нөлөөлөх нийгэм дэх олон төрлийн зан үйлтэй холбоотой байж энэ нь цаашид халдварт авах эгзэг мөн өвчлөх эгзэг нь бага буюу их байхад нөлөөлнө. Тэгсэн хэдий ч хагасал үзэх нь (бэлэвсэн эрчүүд) дархлалын тогтолцоонд нь серөг нөлөө үзүүлж болох тул, халдварт авсан байсан хүмүүсийн дунд өвчлөл нэмэгдэж болох юм.

Архи, хар тамхийг хэтрүүлэн хэрэглэх


Архи эсвэл янз бүрийн бодисыг хэтрүүлэн хэрэглэх нь сурьеэгийн өвчлөлтэй холбоотой байх талаар эрт дээр үеэс тэмдэглэж байгаа боловч энэ шалтгаант холбогог нотлох тархвар судалалын хангалттай баталгаа үгүй байна. Канадын архичидын өвчлөл нь сурьеэгийн шинэ өвчлөлтэй шууд хамааралтай байсан боловч, энэ нь нийгэм эдийн засгийн байдалтай нь мөн холбоотой байж төөрөлдсөн үр дун гарсан байж болох юм [296]: нийгэм эдийн засгийн хувьд хамгийн доод давхарга, архичдийн хамгийн их хувь, энэ 2 хоёулаа сурьеэгийн шинэ өвчлөлтэй эсрэг урвуу хамааралтай байсан. Бодис хэтрүүлэн хэрэглэгчдийг (архи ба бусад хар тамхи) нийт хүн амтай харьцуулахад сурьеэ өвчинөөр өвчлөх эгзэг тэдэн дунд хэтэрхий их байсныг ахин дахин тогтоожээ [311-314].

Бусад эмзэг бүлгийн хүмүүс

Эрүүл мэндийн салбарт ажиллагсад нь сурьеэ өвчинөөр өвчлөх эгзэг ихтэй бүлэг хүн амын тоонд ордог [315,316]. Гэвч АНУ-д хийсэн том судалгаагаар эрүүл мэндийн салбарт ажиллагсадын сурьеэ өвчинөөр өвчлөх эгзэг ийм



Зураг 89. Копенгагени хотын уушигны сурьеэтэй гэр бүлтэй эрчүүдийн шинэ өвчлөлийг хөдөө орон нутгийнхтай харьцуулсан байдал, Дани улс, 1960–1968 он. [309]-аас эх баримтыг авч хэвлэв.



Зураг 90. Копенгагени хотын уушигны сурьеэтэй эрчүүдийн гэрлэлтийн байдал, Дани улс, 1960–1968 он. [309]-аас эх баримтыг ашиглав.

мэргэжилээр ажиллаж байгаа хүн ам зүйн судалгаанд суурилсан хүлээгдсэн эзэгээс их биш байсан байна [317].

Яагаад гэвэл эрүүл мэндийн салбарт ажиллагсад нь бусад мэргэжлийн хүмүүстэй харьцуулахад, дундажаар, сурьеэтэй өвчтөний нөлөөлөлд илүү их давтамжтай өртөх боловч, энэ бүлэг хүмүүс сурьеэ өвчнөөр өвчлөх эзэг нь бага байна, энэ нь сурьеэтэй өвчтөнийг эмнэлгийн үйлчилгээгээр асар ч буй нөхцөл байлгаж байгаагаар тодорхойлогдно. Үүний эсрэгээр нийт хүн ам дотор сурьеэгийн өвчлөл ховор бүсэд хэрээс хэтэрсэн өвчлүүлэх эзэгийг таних нь хэцүү байж болно.

XДХВ-ын халдвартын үйлчилэл

ХДХВ нь сурьеэгийн тархвар зүйг гурван төрлийн замаар өөрчилж болно [318]:

- Урьд өмнө нь авсан байсан M.tuberculosis-ын халдвар дээр ХДХВ-ын халдварыг нэмж авснаар дотоод замаар сурьеэ өвчинийг идэвхижүүлэх.
- ХДХВ-ын халдварыг урьд өмнө нь авсан байсан хүн M.tuberculosis-ын халдварыг нэмж авснаар энэ халдвар нь шууд сурьеэ өвчин болж идэвхижих.
- ХДХВ-ын халдвартай сурьеэтэй өвчтөнүүд халдвар тарааснаас болж нийт хүн амд сурьеэгийн савханцарын тархалт явагдах.

АНУ-ын Флорида мужид хийсэн эргэмж (ретроспектив) судалгаагаар [140] шууд бус аргаар мөн Нью-Йорк [141] хотод хийсэн проспектив судалгаагаар дотоод замаар идэвхижсэн өвчиний тохиолдол ямар ч үед чухал ач холбогдолтой байнсныг тогтоосон. Эмнэлэгт сурьеэ өвчиний дэгдэлт гарахад эхлээд хэн нэгэнд нь сурьеэ өвчин идэвхжиж дараа нь бусад мэдрэг эмзэг биетэй хүмүүсд сурьеэгийн савханцарыг халдварлуулдаг тухай олон судалгаануудад сайн баримтжуулан тэмдэглэсэн байдал [319-326].

Итали улсын нэгэн эмнэлэгт гарсан дэгдэлт ХДХВ-ын сурьеэд нөлөөлөх дээрхи гурван механизмыг бүгдийг нь дэлгэн харуулсан (зураг 91)[319]. M.tuberculosis-oop урьд халдварлагдсан байсан ХДХВ-ын халдвартай өвчтөнд, сурьеэгийн дотоод идэвхжилээс үүссэн сурьеэг нь таниж оношлоогүй нь нэг палатны ХДХВ-ын халдвартай өвчтөнөөс нь сурьеэгийн 2 дах тохиолдлыг араасаа дагуулж бий болгосон байна. Энэ нь ХДХВ-ын халдвар дээр давхцсан сурьеэгийн халдвар нелөөлнөөс сурьеэ өвчин шууд огюом идэвхжиж үүссэн байж болох юм. Эцэст нь үүнээс болж ХДХВ-ын халдваргүй эмнэлгийн ажилтан сурьеэ өвчнөөр өвчилсэн байна.

Нийгмийн эруул мэндийн хэтийн төлөвт онцгой сэлтэл зовоож байгаа зүйл бол халдварын тархалт нэмэгдэх явдал юм. Энэ нь араасаа халдвар авсан хүний тоог нэмж эдгээр нь ирээдүйд өвчлөлийн тохиолдлын тоог өсгөх болно. АНУ-д хийсэн, нэгэн судалгаанд сахны халдвар тархалт болсныг тодорхойлох заагчаар 5-аас доош насны АНУ-д төрсөн хүүхдүүдийн сурьеэгийн өвчлөлийн хандлагыг ашигласан [300]. Энэ аргыг хэрэглэж АНУ-д халдвар авах эзгигийг тооцоолоход 1980-аад оны сүүлчтэй 1990 оны эхийг


харыгуулахад халдвартай авах эгзэг 10%-иар нэмэгдсэн байжээ. Нийт хүн ам доторхи халдвартай авах эгзэг магадгүй бага зэрэг нэмэгдэх юм, яагаад гэвэл АНУ-ын нийт сурьеэтэй өвчтөнүүдийг арьсны өнгө гарал угсаагаар цөөнхл тооцогдох хүн амын хүүхдүүдтэй харыгуулах боломжгүй юм [146].

Хүүхдийн сурьеэл ХДХВ-ын халдвартай нөлөөллийг дэлхий даяараа анхаарах болсон, энэ талаар онцгой сонирхолтой баримтууд Сахарын Африкаас олджээ [327-331]. Хүүхэд бол тархвар судлалын үүднээс нийгэмд халдвартай холбогдол бүхий эх уурхайд тооцогддогтуй [332]. Тэд сурьеэ өвчний эпидемийн хандлагыг тодорхойлогч нь болдог [299]. Мөн Сахарын Африкийн ажиглалтын баримт нь ХДХВ-ын цар тахлын нөлөөгөөр олон орон нутагт нилээд их талбайг хамарсан сурьеэгийн савханцарын тархалт болох магадлалтай гэсэн таамаглал хийжээ.

АНУ ба баруун Европ

1985 онд АНУ-ын Жеоржия мужийн Атланта хотод зохион байгуулсан анхны Олон Улсын Коференци дээр Нью-Йорк хотоос ирсэн тархвар судлаачид, тус хот дахь сурьеэгийн шинэ өвчлөлийн болон ДОХ-ын өсөлтийн тархалтанд газар зүйн холбогдол байгаа талаар мэдэгдсэн [333]. Үүнээс хагас жилийн дараа АНУ-ын Centers for Disease Control and Prevention (CDC)-ын тандалт судалгаагаар сурьеэгийн тохиолдол 1985 оны эхний 39 долоон хоногийн хугацаанд яг урд жилийнхтэйгээ ижил түвшин хүртэл буурсан талаар мэдээлжээ [265]. Үүний дараагаар CDC ДОХ ба сурьеэгийн хоорондах холбоог илүү сайн тодорхойлох зорилготойгоор, муж болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч хэд хэдэн судалгааг Флорида муж [140,154] болон Нью-Йорк хотод санаачилсан.

Тэгэхдээ энэ үед тандалт судалгааны тодорхойлолтонд буюу сурьеэг ДОХ-ын тодорхойлогч нөхцөл гэж хараахан хамруулаагүй байсныг тэмдэглэх




Зураг 91. Сурьеэгийн халдвартай тохиолдол бүртгэгдсэнээс хойш ХДХВ-ын халдвартай өвчтөнүүдээс хоёрдагч сурьеэгийн тохиолдол илэрсэн хугацаа, Верона, Итали улс. Хэр дугуй нь халдвартай авах эх уурхайг, цагаан дугуйнууд нь хоёрдагч тохиолдуудыг илтгэнэ.[319]-еес эх баримтыг ашиглав.

хэрэгтэй. ДОХ-той болон ДОХ-утгуй сурьеэ өвчтөй өвчтөнүүдийн хүн ам зүй болон эмнэл зүйн оншгий шинжүүдийн талаар арвин их мэдлэгтэй болох нь энэ хамтын ажиллагааны зорилт байв. Эдгээр дескриптив болон ретроспектив судалгаанууд урд өмнө хийгдсэн жижиг судалгаануудаас дэвшүүлсэн таамаглалыг баталсан юм [334]. Цараах зүйлүүд тэмдэглэгдсэн [335]. Нэгдүгээрт, сурьеэ өвчин нь сурьеэгийн савханцарын халдварын тархалт өндөр мөн ДОХ-той өвчтөн олонтой хүн амд элбэг тохиолдоно. Хоёрдугаарт, сурьеэ өвчин, ихэвчлэн ДОХ-ыг тодорхойлох эмнэл зүйн шинж тэмдэгүүд бурдэхээс өмнө урьтан гарч ирдэг. Гуравт, ДОХ-ой өвчтөнд сурьеэгийн эмнэл зүйн хэлбэрүүд ихэнхи тохиолдолд хэвшил болсон илэрлүүдээсээ гажиж байдаг.


Флорида мужид хийгдсэн ретроспектив судалгааны явцад тухайн мужийн сурьеэ болон ДОХ-той тохиолдолын хувь харьцааг тодорхойлохын тулд нийт ДОХ-той өвчтөнүүдийг сурьеэ оношлох шинжилгээнүүдэл оруулсан (зураг 92)[140]. Хоорондох ялгаа нь их байсан, давтамжийн хүрээ нь испани-биш цагаан арьстнуудын дундах 2%-иас, Гaitийн хүмүүсийн дундах 27% хүртэл байсан байна. Энэ ялгааны шалтгаан бол *M.tuberculosis*-ын халдварын тархалтаас хамаарч байгаа нь ойлгомжтой. Яагаад гэвэл сурьеэгийн савханцар нь ХДХВ-ийн хамааралт сурьеэ өвчин үүсэхэд зайлшгүй нөлөөлдөг шалтгаан юм. Сурьеэгийн халдварын тархалт бага байдаг хүн амын бүлгээс цөөн тооны сурьеэтэй өвчтөн олдсон байна. Тиймээс ХДХВ-ын хамааралт сурьеэгийн давтамж нь тухайн бүлэг хүн ам дах сурьеэгийн болон ХДХВ-ын халдварын тархалт, эдгээр хэсгүүдийн давхацах үед үүсэх хэрчимиийн хэмжээнээс шийдвэрлэхүйцээр хамаарна (зураг 93). Флоридын судалгаанд [140], ДОХ-той Гантчууд өмнө нь сурьеэгийн савханцарын халдвартыг аваагүй байсан ба сурьеэ өвчин үүссэн өвчтөнүүд Флорида мужид байгаагүй учир тохиолдуудыг олж тогтооход хялбар байсан байна. Иймээс хавсарсан халдварт авсан тохиолдолд нийт амьдралын хугацаандаа сурьеэгээр өвчлих эгзэг нь ХДХВ-ын халдварын чиглэл байдлаас хамааран 30%-ийг давах боломжтой юм.

Насаар ангилсан халдварын тархалтаас хамаарч (зураг 43-45) ХДХВ-ын халдварт нь 15-49 насны бүлгийн хүмүүсийг амархан халдвартуулах нь илэрхий. ХДХВ-ын халдварын сурьеэгийн тархалтанд нөлөөлөх үйлчлэл Сахарын Африкт, АНУ буюу Баруун Европынкоос мэдэгдэхүйц илүү байна.

АНУ-ын Нью-Йорк хотод бүртгэгдсэн баримтанд дун шинжилгээ хийхэд хар арьстнуудын халдварт авсан байдлыг испани-биш цагаан арьстантай харьцуулахад ХДХВ-ын халдварт илүүтэйгээр өртөж байгаа мэт байв [266]. Тэгэхдээ, эдгээр өсөлтийг ХДХВ-ын халдвараас үүдэлтэй гэж үзэж болохгүй, бусад хүчин зүйлсийг мөн сайтар бодолцож үзэх хэрэгтэй [268,269,336]. Тиймээс АНУ-ын хүн амын цөөнхөд ХДХВ-ын эпидеми нь нөлөөлж өөрийн араасаа сурьеэгийн эпидемийн байдлыг муудуулж байгаа гэдэгт бага зэрэг эргэлзээ төрнө.



Зураг 92. Арьсны өнгө, удам угсаанаас хамаарч сүрьеэз өвчнөөр өвдсөн ДОХ-той өвчтөнүүд. Флорида, АНУ, 1981–1986. [140]-өөс эх баримтыг авав.



Зураг 93. Нийгэм дэх ХДХВ-ын халдвартай хавсарсан сүрьеэз өвчний давтамжийг тодорхойлогч.


Яагаад гэвэл, эдгээр бүлэг хүмүүсд сурьеэз нь нөхөн үржихийн насанд нь өргөн шар хүрээтгээгээр тогтмол үйлчилж тэдний үр удамд халдварт дамжих нь цагаан арьстай хүн амынхаас илүү их байдаг.

Тухайн цаг үеийн цөөн тооны ХДХВ-ын шинэ тохиолдолууд Баруун Европын сурьеэгийн тархварт ноцтойгоор нөлөөлсөн [270]. Тийм боловч Европын улс орнуудад ДОХ-ыг тодорхойлогч нь болж оношлогдсон УБЭ сурьеэгийн давтамж хоорондоо ялгаа ихтэй байсан (зураг 94)[337]. Испани ба Португалд ДОХ-ын тохиолдол болон УБЭ-ийн сурьеэгийн харилсан хамаарал нь өндөр байжээ. Гэвч энэ нь тийм ч сонин зүйл биш байв. Яагаад гэвэл энэ 2 оронд Баруун Европын орнуудаас сурьеэ хамгийн өндөр бүртгэгдсэн байв [282]. Испанид 1988 ба 1993 онуудын хооронд УБЭ сурьеэ нь ДОХ-той өвчтөний тодорхойлогч өвчин болж 30%-д нь илэрсэн байна [314]. Каталонияд (зүүн хойд Испани) гүйцэд боловсруулаагүй баримтаар сурьеэгийн шинэ өвчлөлийн түвшин 1987-оос 1993 онуудын хооронд 50% хүртэл өссөн байв. Энэ өсөлтийн 60% нь шууд ДОХ-той хамаарлтай байжээ [338]. Бусад Европын улсуудад, ХДХВ-ын халдвартай холбоотой сурьеэгийн өсөлт мэдэгдэхүүц их байж чадаагүй. Зарим нэг хотод, жишээ нь, Францын Париж [339] болон Нидерландын Амстердамд [340] дээрхи нөлөөлөл анхаарал татахуйш байсныг тэмдэглэжээ. Үүний эсрэгээр ХДХВ-ын халдвартын нөлөөлөл нь Англи болон Уэлсд маш бага байв [341]. Шотланди улсын Эдинбург хотод хийсэн судалгаагаар ХДХВ-ын халдварт авсан өвчтөнүүдийн 1000-ын 5-д нь л сурьеэ өвчин үүсдэг болохыг тогтоожээ [343].


Сахарын Африк

Сахарын Африкийн олон тооны орнуудад сурьеэгийн эпидемид ХДХВ-ын эпидеми ноцтой нөлөө үзүүлсэн юм [143,288,344,345]. Хэрэв Сахарын Африкт 1985 оны өмнөх чиг хандлага үргэлжилсээр байх юм бол дундажаар нийт сурьеэгийн тохиолдолуудын 1/3 нь, 1985-аас 1993 онуудын хооронд 0-оос 72% хүртэл шинээр гарч ирэх болохыг тооцоолсон [346].

Бурундын улсад бүртгэгдсэн сурьеэгийн тохиолдолын тоо 1984 онд байснаасаа 1991 он гэхэд 2 дахин их болсон байв [347]. Конго улсын Браззавиллед сурьеэ өвчтэй өвчтөнүүдийн дундах ХДХВ-ын тархалт 1988-аас 1992 оны хооронд 4 жилийн дотор 3%-иас 24% болгоо өссөн байв [348]. Коте д'Ивойрд, ХДХВ-ын халдварт авсан байсан өвчтөнүүдэд эмгэг судлалын шинжилгээ хийж үзэхэд 32%-д нь сурьеэ өвчин нас баралтын шалтгаан болсон байсныг нь тогтоожээ [349]. Малави улсад сурьеэгийн тохиолдолын тоо 1985-1995 онуудад мөн 4 дахин нэмэгдсэн байсан [350]. Мөн ХДХВ-ын хамаарлтайгаар сурьеэгийн тохиолдлын тооны огцом их өсөлт Кени улсад [351], Замби улсад [352], Зимбабве улсад [353] болон бусад өөр орнуудад бүртгэгдсэн [354,355].



Зураг 94. Халдвэр дамжуулсан бүлэг болон хүйснээс хамаарч, Европын улс орнуудад дах УБЭ сурьеэ нь ДОХ-ыг илтгэгч болох харьцангуй магадлал. Цэгчилсэн босоо шугам нь харьцуулах заагийг илтгэнэ, цагаан дугуй нь үзүүлэлт бүрийн болон хэвтээ дервэлжингүүдийн 95%-ийн итгэлийн заагийг илтгэнэ.



Зураг 95. Сурьеэгийн тохиолдолын доторхи хэлбэрүүд, Танзани улс, 1984–1995 онууд.[356]–аас эх баримтыг авч хэвлэв.

Танзани улсал, бүртгэгдсэн сурьеэгийн тохиолдлын тоо 1984-өөс 1995 оны хооронд мэдэгдэхүйц өссөн (зураг 95)[356]. Тохиолдлын тоо өсөж байгаа дээр нэмж, цэрийн түрхэц зэрэг өвчтөнүүдийн тоо насны ангиалд бүлэгт тархах байдал нь мөн өөрчлөгдхөйг тэмдэглэх хэрэгтэй. 1984-өөс 1995 онуудад цэрийн түрхэц зэрэг тохиолдолын тархалт залуу насны хүмүүст өндөр хувьтай байсан (зураг 96)[356]. Энэ нь тархвар судалалын хувьд таагүй шинж юм. Тархвар зүйн нөхцөл байдлыг сайжруулахад сурьеэтэй өвчтөнүүдийн median нас нь өсөж байх хэрэгтэй, үүний эсрэгээр дундач нь бага насныханд байх нь залуу насны бүлэг хүн амд халдвартархалт мөд өндөр болохыг итгэнэ.


Танзанид улсын хэмжээнд сурьеэтэй өвтөнүүдийн ийлдэст ХДХВ-ыг тодорхойлсноор, сурьеэгийн өвчлөлд ХДХВ-ийн нөлөөг баталсан [357]. Энэ судалгааны дунд бүх сурьеэтэй өвчтөнүүдийн 30%-45% нь ХДХВ-ын халдвартай байгааг тодорхойлжээ. Нэг улс оронд ХДХВ-ын халдвартай авах эгзэг тэгш бус тархалттай байна. 25-аас 34 насны сурьеэтэй өвчтөнүүд илүүтэйгээр ХДХВ-ын халдвартай авах боломжтойг судалгаанууд харуулсан байна. Сурьеэ өвчтэй эмэгтэй хүн ХДХВ-ын халдвартай авах боломж илүү их байсан. УБЭ-ний сурьеэгийн тохиолдлууд илүү ихээр ХДХВ-ын халдвартай авсан байх магадлалтай байжээ. BCG вакцин хийлгэсэн хүмүүст ХДХВ-ын халдвартай аван авталь сурьеэгийн эсрэг тодорхой хэмжээний хамгаалалт BCG вакцинаар хангагдаж байсан. Энэ судалгааны 2 дахь үед болох хэсэгт ХДХВ-ын халдвартай үүссэнээсээ хойш маш хурдан, богино хугацаанд 3 жилийн дотор идэвхжиж байсныг харуулсан (зураг 97, өмнө нь нийтлэгдэж байгаагүй баримт, Танзани улс, National Tuberculosis /Leprosy Programme, ДЭМБ, ОУСҮӨТХ).

Aзи


Ази дахь ХДХВ-ын халдвартай уйилчлэл нь Урд Тайландийн жишигийн дээр тодорхойлжсан. Энэ судалгааны явцад сурьеэтэй өвчтөнүүдэд тогтмол ХДХВ-ын шинжилгээ хийж байсан ба бүртгэгдсэн сурьеэгийн хурдаштай өсөлт 1990-ээс 1994 онуудын хооронд тэмдэглэгджээ (зураг 98)[358]. Энэ өсөлт зөвхөн ХДХВ-ын халдвартай хамааралтай байсан нь илт тодорхой байсан.

Энэтхэгийн сурьеэтэй өвчтөнүүдийн дунд тархсан ХДХВ-ын халдвартай талаар товчхон дурдая. Tamil Nadu мужийн Өмнөд Аркотд хийсэн нэгэн судалгаагаар шинжилгээнд хамрагдсан 3000 сурьеэтэй өвчтөнүүдийн зөвхөн 2%д нь ХДХВ-ын халдвартай илэрсэн [359]. Сурьеэтэй өвчтөний тоо өсөх магадлал их байна: Минипурт 1991 онд анх оношлогдсон ХДХВ-ын халдвартай 4 өвчтөн мөн Энэтхэгийн зүүн урд мужийн нэг өвчтөн, бүгд сурьеэтэй байжээ [360].

Вьетнамын Хо Ши Мин хотод амьсгалын замын эрхтэний өвчтөний эмнэлэгт хийсэн судалгаагаар шинж тэмдэг нь илэрсэн ХДХВ-ын халдварталт 1992 онд 1%тай байсан бол 1996 он гэхэд 39% болтлоо өсжээ. Тус улсын 53 мужийн 42-т нь ХДХВ-ын халдвартай тодорхойлогддогдажээ [362]. Үүний улмаас сурьеэгийн өвчлөл ойрын хэдэн жилд өсөж болох юм.



Зураг 96. Танзани улсын цэрний түрхэц-зэрэг тохиолдлын насвар ангилсан тархалтын 1984 оны түвшинг 1995 онтой харьцуулсан байдал. [356]-аас эх баримтыг авав.



Зураг 97. Танзани улсын сүрьеэтэй өвчтөнүүдийн ХДХВ-ын ийлдэсний шинжилгээгээр халдварталт 1991-1993 оны болон 1994-1996 оны тандалттаар өөрчлөгдсөн байдал. Нийтлэгдэж байгаагүй баримт, Танзани улс, National Tuberculosis /Leprosy Programme, ДЭМБ, ОУСУӨТХ.

Латин Америк

1987-1988 онуудад Бразил улсад хийсэн судалгаагаар, уушигны сурьеэтэй хүмүүст ХДХВ-ын халдварт 1 %-иас бага байсан байна. Рио де Жанейрорд хийсэн нэгэн судалгаагаар 1989 онд сурьеэтэй өвчтөнүүд дотор ХДХВ-ын халдварт авсан хүний тоо өсөж 5% болсон байв [364]. Сүүлийн үеийн судалгаагаар, сурьеэз өвчин нь ДОХ-ын илрэл болдог 3 гол өвчний нэг бөгөөд Бразилийн Сан Пауло дах шоронд байгаа эмэгтэйчүүдэд хийсэн судалгаанаас ХДХВ-ын халдварт авсан хүмүүсд сурьеэгийн халдварт илэрсэн байв [365].


Доминикан улсын Санто Домингод 1991-1994 онд судалгаагаар, хүүхдийн ийлдэсийг шинжлэхэд ХДХВ-ын халдварт 6%д илэрчээ [366].

Нийт сурьеэгийн өвчлөлд анхдагч хүрц өвчин, хүрээлэн буй орчноос давтан халдварт авах болон дотоод идэвхжилт явагдсанаас үүссэн өвчин нөлөөлөх нь


Доорхи гурван бүрэлдэхүүн сурьеэгийн өвчлөлд мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлнэ:

- Анхдагч хүрц сурьеэз (эмнэл зүйн шинж тэмдэггүй халдвараас идэвхжиж 5 жилийн дотор өвчин болон илэрнэ [137]);
- M.tuberculosis-ын халдварыг давтан авснаас болж үүсэх тохилдолууд (сурьеэз өвчин 2 дах удаагаа халдварт авснаасаа үүснэ, анхны халдварыг давж чадсан ч);
- Анхны халдварт авсны дараагаар дотоод идэвхжил болсны улмаас сурьеэз өвчин үүссэн (анхны халдварт авснаас хойш 5-аас дээш жилийн дараагаар үүснэ)[367]

1951-ээс 1970 онд Sutherland ба хамтран ажиллагсал нь сурьеэгээр өвчлөхөд дэмжих нөлөө үзүүлдэг гурван бүрэлдэхүүнийг тооцоолж дээрхи хугацаанд бүртгэгдэх мэдээ баримтыг Нидерланд улсад хийсэн судалгааны загварыг боловсруулжээ [367]. Зураг 99-ийн жишээн дээрээс 15-19 ба 60-64 насны эрэгтэйчүүдэд насны зөрүүнээс хамаарсан ялгаа харагдахгүй байгаа бөгөөд мөн энэ нь цаг хугацаанаас хамаарч мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй байна. Дээрхи хугацаанаас хойш, Нидерланд улсад дахь сурьеэгийн халдварын эгзэг жил бүр буурч дунджаар бараг 14% хүрчээ. Ямар ч үед залуу насны хунд, сурьеэз үүсэх хамгийн их нөлөөтэй нь анхдагч халдварт байв. Нөгөө хоёрын нөлөө нь бага үүрэгтэй байсан байна. Үүний эсрэгээр, ажиглалт хийгдсэн хугацаанд ахимаг насны булэгт, анхдагч сурьеэз нь өвчлөлийг дэмжихэд маш бага нөлөөтэй байсан бол, давтан халдварт авах болон дотоод идэвхжил хоёрын холбоот нөлөө байраа сольж илүүтэйгээр нөлөөлсөн байв. Энэ насныханд халдварын эгзэг буурч, дотоод идэвхжилийн оролцооны холбогдол нэмэгджээ.



Зураг 98. ХДХВ халдвартын байдлаас хамаарсан сурьеэз, Чайнг Рай, Тайланд, 1990-1994. [358]-ын эх баримтаас.



Зураг 99. Сурьеэгийн евчлел сахан авсан халдварт(харлуулсан дугуй), дотоод идэвхжил (гурвалжин), мөн гадаад нөлөөллөөс(хоосон дугуй)-хамаарсан хувь. Баримтыг Нидерландулын 15-19, 60-64 насын эрэгтэйчүүдийн судалгаанаас тохируулан [367]-аас авав.

Дээрхи байдлыг дараах зүйлээр тайлбарлаж болно. Ахимаг насны хүмүүсд урд өмнө авсан байсан халдварын дотоод идэвхжил шинэ өвчлөл болон илрэхэд илүү нөлөөтэй байдаг. Энэ нөхцөл байдал ихэнх аж үйлдвэржсэн улс орнуудад ажиглагджээ. Эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгийн харилцан холбооны талаарх мэдлэг нь нийт сурьеэгийн өвчлөлийн хор уршигийг тооцоолход чухал холбогдолтой. Хөндлөнгийн оролцоо хийж халдвартархах хугацааг богиносгох нь сурьеэг бууруулахад хамгийн их үр дүн өгөх арга болж болох магадлалтай.

Саяхан авсан болон давтан халдвар авснаас үүссэн сурьеэг дотоод халдварын идэвхжилээс үүссэн сурьеэтэй, *M.tuberculosis*-ын омогийн хувь шинж чанараас хэрхэн хамаарахыг молекулын түвшинд харьцуулаж судалжээ. *M.tuberculosis*-ын омогийн төрлүүдийг тодорхойлох RFLP арга техникийг ашиглан судлахад, АНУ-ын зарим бүсэд саяхан халдвар авснаас үүссэн сурьеэгийн давтамж урд өмнө нь авсан халдвараас үүссэн сурьеэгээс илүү байсныг тогтооожээ.

Саяхан халдвар авсны улмаас үүссэн сурьеэгийн тохиолдол Нью-Йорк хотод [368] нийт өвчлөлийн 40%-ийг, Сан-Францисковд [369] 1/3-ийг эзэлж байжээ. Хяналтын хэмжилт бүртгэлийг сайжруулсны үндсэн дээр Нью-Йорк хотын сурьеэгийн өвчлөлд үзүүлж байгаа нөлөө мөн шалтгааныг тогтооно [245].

***M.bovis*-ын нөлөөгөөр үүсэх сурьеэ**


Аж үйлдвэржсэн орнуудад, *M.bovis* шалтгаант сурьеэ бараг тохиолдохoo болж байна. Гэвч оношилгоо нь маш хүндрэлтэй байдаг [47] Мөн дутуу мэдээлсэн болон мэдээлэгдээгүй эсвэл *M.tuberculosis*-ын бурдэлийн бусад төрлүүд шиг алдаатай бодож ангилдаг байдал нь үүнд нөлөөлж болно. Kleeberg *M.bovis*-ын давтамж тархалтын талаар судлан дүгнэлт хийсэн байна [370]. 20-р зууны эхний арван жилд, булчирхайн сурьеэгийн тохиолдлуудын 10-30% нь, ушигны сурьеэгийн тохиолдлуудын 5 %-ийг нь үхрийн сурьеэгийн савханцарын давтамж эзэлдэг гэсэн мэдээ байжээ. 1960-д оны байдлаар энэ тохиолдлуудын хувь буурч 1-2%-иас бага болсныг ихэнх улс орнууд тайлагнан мэдээлжээ.

Таамаглах тархвар судлал: эпидем гарах хэтийн төлөв

Аж уйлдвэржсэн улс орон

Аж үйлдвэржсэн улс орнуудын сурьеэгийн эпидемийн чиглэл олон төрлийн хүчин зүйлсээс хамаарах болно. Сурьеэгийн халдвартай хүн амын дундах ХДХВ-ын халдварын эгзэг когортын хувь байрлалаа хурдан хугацаанд өөрчлөх тул Баруун Европын орнуудад ХДХВ-ын халдварын үйлчилэл маш бага байх магадлалтай болно. Хэрэв ХДХВ-ын халдвартай ХДХВ-ын халдвартаай архи, хар тамхи хэтрүүлэн хэрэглэгчдийн сурьеэгийн өсөлтийн шалтгаан болсон ч, энэ нь өвчлөлийг нэмэгдүүлсэн ч эдгээр орны үндсэн хүн амын нийт өвчлөлд төдийлөн нөлөөлж чадахгүй юм.

Сүрьеэгийн өвчлөлийн түүхэн дүн шинжилгээнд үндэслэн Härd Финланди улсын сүрьеэгийн шинэ тохиолдолын тоог когорт төрөлтэнд нь тооцоолон гаргасан [271]. Энэ тооцоогоор Финланди улсын үндсэн хүн ам дахь сүрьеэгийн өвчлөл хурдааттай буурахыг таамагласан (зураг 100). 2015-2020 он гэхэд сүрьеэгийн өвчлөл сая хүн амд 1 тохиолдол болтгол буурна.



Зураг 100. 2000–2010 онуудад Финнланди улсын эрэгтэйчүүдэд үүсэж болох амьсгалын замын сурьеэз евчний шинэ тохиолдолын тоо. 5 жилийн когорт төрөлтэнд ажиглагдсан насны-хамааралтай тайлагнагдсан сурьеэгийн тохиолдууд. Цэгчилсэн шугамууд нь ижил когорт төрөлт дэх шинэ евчлэлийг тооцоосоныг илтгэнэ, үүнээс 2000 болон 2010 онуудад насны-хамааралт шинэ тохиолдолын тоог таамаглан гаргажээ. [271]—ээс эх баримтыг ашиглав.


Финланди улсад тооцоологисон таамаглал ихэнхи Баруун Европын үндсэн хүн амын дунд тохирч болох юм. Гэвч аж үйлдвэржсэн орнуудад бусад улсаас цагаачлан ирэх хүмүүсийн тоо нэмэгдэх нь бүртгэгдэх сурьеэгийн тоонд нөлөөлөхийг угүйсгэхгүй. Эцэст нь, эдгээр улс орны ихэнхид нь сурьеэгийн өвчлөл үргэлжлэн буурах, эсвэл цагаачлал ба цагаачдын өвчлөлөөс хамааран есч болно. Суурь хүн амын дундаас гарах сурьеэгийн тохиолдол ос халдварт авах эзгэг буурахтай адил цар хүрээтэйгээр, цагаачдын сурьеэгийн тохиолдлын халдварт тараалт харилцан холбоотойгоор улс орны өвчлөлд чухал нөлөөтэй байна. 1993-1995 онуудад Нидерланд улсын дани хүн амаас өвчилсөн тохиолдлын 1/5-ээс бага тохиолдолд дани-биш эх уурхайгаас халдварт авсны улмаас сурьеэ өвчинеэр өвчилсөн байв [304]. Тэгэхдээ дээрхи маягаар халдварт аваад өвчилсөн тохиолдлын тоо харьцангуй бага юм. Энэ нь цаашид хэвээр байх хангальтай боловч энэ маш удаан байгаа нь сурьеэ өвчин устах магадлалыг бууруулж байгаа нь сэтгэл зовоосон асуудал хэвээр байна.

Маш олон үндэстэн амьдардаг улс орны нэг болох АНУ-д сурьеэгийн халдварт тархалт өндөртэй яс үндэстэнд сурьеэгийн хяналтыг сүл хийвэл энэ нь араасаа, сурьеэ өвчин дахин сэргэх үзэгдэл маш хурдан эхэлдэгийг урьд нь дурьдсан. Хэрэв хэд хэдэн хүчин зүйлс нэгдэж дээрхи халдварт тархах болон халдварт өвчин болж идэвхжихэд нөлөөлвлөх холбогдол нь үнэлэхүүцээр нэмэгдэх болно. Нью-Йорк хотоос мэдээлсэн баримт туршлагаас үзэхэд, сурьеэ өвчинтэй тэмцэхэд оновчтой шийдэмгийн авсан арга хэмжээнүүд нь сурьеэгийн эпидемд нөлөөлж чадлаг тэдгийг харуулсан юм.

Буурай хөгжилтэй улс орнууд

Сурьеэ болон ХДХВ-ын халдварт нь хүний эсийн дархлалын тогтолцооны бүрэн бүтэн байдлыг эвдэж, хамгаалах чадварыг нь ноцтойгоор алдагдуулдаг хоёр нөхцөл болдог. ХДХВ-ын халдварт нь цаашид энэ тогтолцоог бүрэн устгадаг. Үүнээс болж буурай хөгжилтэй орнуудад сурьеэгийн эпидемийн хандлага ойрын ирээдүйд улам ихээр муудах төлөвтэй байна. Өнөө үед сурьеэгийн халдварт тархалт өндөр, тэгэхдээ ХДХВ-ын халдвартын цар тахалд өртөөгүй байгаа улс орнуудын залуу насны хүмүүсл нөхцөл байдал аюултай хэвээр үлдэж байна. Эдгээр улс орнуудын эпидемийн чиг хандлага нь нийт хүн амын халдварт авах эзгийг бууруулах боллогыг хэр амжилттай, хэр шаламгай хэрэгжүүлснээс ихээхэн хамаарах болно.

Сахарын Африкийн өнөөгийн тулгамдсан асуудлууд, бэрхшээл дээр үндэслэн ирээдүйн хэтийн загварыг урьдчилан таамаглан тооцоолвол, хичнээн өөдрөг үзэлтэн байсан ч, 1980-аас 2000 оны сүүлч гэхэд сурьеэ өвчин 50%-иас 60% хүртэл өсөх хандлагатай байна [371]. Дээрхи загварын дагуу цэرنд түрхэц зэрэг тохиолдлын тоо 10 дахин нэмэгдэнэ гэсэн нь тийм ч итгэмээргүй зүйл биш юм.



Зураг 101. ДЭМБ-аас сүрьеэгийн шинэ өвчлөлийн түвшин Африк болон өндөр аж үйлдвэржсэн орнуудад 1999-2000 онуудад ямар байхыг урьдчилан тооцоолон харуулжээ. [289]-ээс эх баримтыг авав.

1993 онд ДЭМБ дэлхийн янз бүрийн бус нутагийн сүрьеэгийн шинэ өвчлөлийн хэтийн төлөвийг тооцоолох оролдлого хийсэн. Энэ тооцоог хийхдээ тус бус нутгийн сүрьеэтэй тэмцэх хяналтын өнөөгийн байдал, хүн амын өсөлт, ХДХВ-ын халдвартын үйлчлэл, мөн бусад хүчин зүйлүүдийг анхааралдаа авч үзсэн [289]. Сахарын Африкийн хэтийн төлев байдал өндөр аж үйлдвэржсэн улс орнуудынхаас эрс тэс ялгаатай байна(зураг 101).

Сүрьеэтэй тэмцэх өнөөгийн арга барилтайгаа, мөн шинэ халдвартай хэлбэрийн сүрьеэгийн тохиолдлыг цаг алдалгүй оношилж халдвартамжих замыг таслан зогсоох өөр нэмэлт арга барилгийг нэвтрүүлэхгүйгээр дэлхий дээрхи сүрьеэгийн байдал ирэх жилүүдэд дордох магадлалтай байна гэж ДЭМБ-ын Dye болон хамтран зүтгэгчид нь тэмдэглэжээ [126]. Мөн ХДХВ-ын халдвартын цар тахалд аль хэдийн ноцтойгоор нэрвэгдсэн байгаа болон сүрьеэтэй тэмцэх сүл хөтөлбөртэй улс орнуудад энэ аюул ялангуяа хурцаар тусах болно.

БҮЛЭГ 4

СҮРЬЕЭГИЙН НАС БАРАЛТ

Нилээд урт хугацаанд аж үйлдвэржсэн орнуудад сүрьеэгийн эпидемийг тодорхойлогч шинж нь сүрьеэ өвчний улмаас нас барах явдал байсан юм. Үүний эсрэгээр, буурай хөгжилтэй орнуудад нас баралтын тухай мэдээ тайланг маш ховор эсвэл ер нь тогтмол бүртгэж нэгтгэдэгтүй байжээ. Тийм учраас нас баралт буюу тохиолдлын эндэгдлийн талаархи баримтыг тайлбарлахдаа дээрхи байдлыг анхаарч байх шаардлагатай. Сүрьеэ өвчний улмаас нас барах явдлыг зарим улс оронд хэдэн зууны өмнө, тухайн өвчний халдвартайг болон үүсгэгчийг нь тодорхойлохоос хамаагүй өмнө тэмдэглэдэг байжээ. Сүрьеэ нь нас баралтын шалтгаан болдог гэлгийг, маш эртний эх сурвалжаас мэдэж болно. Энэ зууны 2-р хагасд хими эмчилгээ нэвтэрснээр сүрьеэгийн улмаас нас барах тохиолдлын тоог мэдэгдэхүйцээр бууруулжээ. Тийм учраас ихэнх аж үйлдвэржсэн орнуудад сүрьеэгийн нас баралт нь сүрьеэ өвчний цар хүрээг тодорхойлогч шинж болж чадахаа болжсон. Цаашид аж үйлдвэржсэн орнууд дун бүртгэлээ нас баралтын гэрчилгээний баримт мэдээнд үндэслэн хийдэг болжсон нь, алдааг олон дахин нэмэгдүүлэх магадлалтай [372,373].

Үүсгэгчийн холбогдолтой тахвар судлал: сүрьеэгийн нас баралтанд нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйлс (тохиолдолын эндэгдэл)


Сүрьеэгийн улмаас нас барах эгзэг нь өвчний явц болон хэлбэрээс мөн оношлогдсон хугацаанаас хамаарна. Хими эмчилгээний-өмнөх үед, сүрьеэгийн менингитээс эндэх тохиолдол 100%д хүрч байсан [374,375]. Нөгөө талаас, захын тунгалгын булчирхайн сүрьеэ нь үнэндээ эндэгдэлд нөлөөлөхгүй ч [160], тунгалаг болон цусаар тархсан сүрьеэ эсвэл өөр хэлбэрийн сүрьеэгийн дунд үүсэлтэй бол ярвигтай болно.

Тархвар судлалын талаас нас баралтын ихэнх хувийг эзэлдэг, ушигны хэлбэрийн сүрьеэгээр нас барах явдал илүү их анхаарал татдаг. Ушигны сүрьеэгийн церний түрхэц-эерэг тохиолдлын эндэгдэл церний түрхэц-сөрөг тохиолдоос хамаагүй их өндөр байдаг. Үүний жишээг, 1912-1927 онуудын


хооронд Шведийн нэгэн сувилалд сурьеэтэй өвчтөнүүдийг даган судалсан судалгаанаас харж болно; "ил" хэлбэрийн сурьеэгийн тохиолдлын эндэгдэл тэнд 60%д лөхсөн байсныг 10-15%тай байсан "хаалттай" хэлбэртэй сурьеэтэй харьцуулан судалжээ (зураг 102)[376]. Хими эмчилгээний-өмнөх үеийн хэд хэдэн судалгаагаар цэргийн түрхэц-эерэг сурьеэтэй өвчтөний тохиолдолын эндэгдэл өндөр байсныг мөн гэрчилжээ [129,377-382]. Их Британи [380], Швед [129] ба Дани [382] улсуудад: цэргийн түрхэц-эерэг сурьеэтэй өвчтөнүүдийн 1/3 нь оношлогсоноосоо хойш 1 жилийн дараа, мөн улсэн 2/3 нь 5 жилийн дотор нас барсан байжээ (зураг 103).

Сурьеэ өвчний тавилан хими эмчилгээ нэвтэрснээр мэдэгдэхүйц сайжирсан юм. Гэсэн хэдий ч, хэд хэдэн шалтгааны улмаас сурьеэ өвчний эндэгдэл нүдэнд өртөхүйц буурахгүй хэвээр байна.


Яг хэдэн өвчтөн оношлогоогүй сурьеэгийн улмаас нас барж байгааг нарийн тогтоох боломжгүй юм. Учир нь ихэнхи ийм өвчний тохиолдлуудын талаар бид хэзээ ч мэдэж чадахгүй билээ. Энэ асуудалтай холбоотой хэд хэдэн судалгаа хийгдсэн. 1985-1988 онуудын хооронд 4 жилийн хугацаанд, АНУ-д бүртгэгдсэн нийт сурьеэгийн тохиолдлын 6% нь хэзээ ч сурьеэгийн эсрэг эмчилгээ авч байгаагүй байжээ [383]. Өвчтөн нас барсны дараагаар оношлогдсон тохиолдлуудын харьцаа насын хамааралтай (зураг 104) нэмэгдсэн бөгөөд тархмал, менингит ба гэдэсний сурьеэ 15-20%д нь байжээ. Энэ судалгаанд өвчний тохиолдлыг зөвхөн эмгэг судлалын шинжилгээгээр болон тохиолдлын эмнэл зүйн хувьд сэжиглэж байсан боловч зөв оношийг зөвхөн тухайн тохиолдол нас барсны дараагаар тодорхойлсныг ялгаж салгаагүй байна. Бусад өөр судалгаануудад дээрхи 2 хамаарал тодорхой



Зураг 102. Свиссийн сувилалд өвөрмөц эмчилгээгүй байсан уушигны сурьеэтэй өвчтөнүүдийн дунд судалсан эндэгдийн түвшин. [376]-аас эх баримтыг авав.



Зураг 103. Уушигын хэлбэрийн цэрний түрхэц-ээрэг тохиолдлуудын эндэгдэл Их Британид 1928–1938 онуудад [380], Швед улсад 1910–1934 онуудад (15аас 29 насны хүмүүс)[129], мөн Дани улс 1925–1929 онуудад (16аас 25 насны хүмүүс)[382].




Зураг 104. Тохиолдол нас барсны дараагаар оношлогдсон сурьеэгийн хувийг насаар харуулав, АНУ, 1985–1988. [383]-аас эх баримтыг авч хэвлэв.

байжээ. Хэд хэдэн эмгэг судлалын шинжилгээгээр сурьеэ өвчин нь идэвхжихгүй орхигдох буюу хэзээ ч сэжиглэгдэхгүй байж болохыг тогтоосон [385-388]. Тус тусдаа хийгдсэн гурван судалгааны дүнгээс үзэхэд сурьеэгийн тохиолдлуудын 50%д нь сурьеэ өвчин нас баралтын шалтгаан болсон байхад, эмгэг судлалын шинжилгээнээс өмнө сурьеэгийн тохиолдлыг таниагүй байжээ [384,385,389]. Тохиолдлын эндэгдэл нь мөн эмчийн мэргэшлийн ялгааг харуулсан [390].


